

Үндэсний статистикийн газрын дарга,
Сангийн сайдын **2007 оны 7 дугаар сарын 9–ний**
өдрийн 101/203 тоот тушаалын хавсралт

**ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО
ТООЦОХ АРГАЧЛАЛ**

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ГАЗАР

2007 он

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО ТООЦОХ АРГА ЗҮЙ

Гарчиг

Нэг. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг тооцох ерөнхий зарчим

- 1.1 Нийтлэг үндэслэл..... 3
- 1.2 Дотоодын нийт бүтээгдэхүүнийг тооцох арга зүйн баримтлалууд.....3

Хоёр. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн аргаар тооцох арга зүй

- 2.1 Дотоодын нийт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцох4
 - 2.1.1 Салбаруудын нэмэгдэл өртгийн тооцоо5
 - 2.1.2 Албан бус секторын тооцоо33
 - 2.1.3 Салбаруудын нэмэгдэл өртгийн үнэлгээг макро түвшинд уялдуулах34
 - 2.1.3.1 Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ34
 - 2.1.3.2 Салбаруудын нэмэгдэл өртгийг бараа, үйлчилгээний татвар, татаасын хэмжээгээр засварлах34
 - 2.1.4 Дотоодын нийт бүтээгдэхүүнийг өмчийн хэлбэрээр тооцох35
- 2.2 Дотоодын нийт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн аргаар, зэрэгцүүлэх үнээр тооцох36
- 2.3 Дотоодын нийт бүтээгдэхүүний зэрэгцүүлэх үнийн суурийг шинэчлэх46

Гурав. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг эцсийн ашиглалтын аргаар тооцох арга зүй

- 3.1 Дотоодын нийт бүтээгдэхүүнийг эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр тооцох.....48
 - 3.1.1 Эцсийн хэрэглээ48
 - 3.1.2 Нийт хөрөнгийн хуримтлал50
 - 3.1.3 Бараа, үйлчилгээний цэвэр экспорт.....54
- 3.2 Дотоодын нийт бүтээгдэхүүнийг эцсийн ашиглалтын аргаар, зэрэгцүүлэх үнээр тооцох56
 - 3.2.1 Эцсийн хэрэглээ56
 - 3.2.2 Нийт хөрөнгийн хуримтлал57
 - 3.2.3 Бараа, үйлчилгээний цэвэр экспорт.....58

Дөрөв. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг орлогын аргаар, оны үнээр тооцох арга

- зүй60

Тав. Аймаг, нийслэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн аргаар тооцох арга зүй

- 5.1 Ерөнхий зүйл61
- 5.2 Аймаг, нийслэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнийг оны үнээр тооцох61
- 5.3 Аймаг, нийслэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнийг зэрэгцүүлэх үнээр тооцох63

Зургаа. Үндэсний нийт орлого тооцох арга зүй

- 6.1 Үндэсний нийт орлогыг оны үнээр тооцох64
- 6.2 Үндэсний нийт орлогыг зэрэгцүүлэх үнээр тооцох65

НЭГ. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ТООЦОХ ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

1.1 Нийтлэг үндэслэл

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь Үндэсний тооцооны системийн (ҮТС) хүрээнд чухал байр эзэлдэг эдийн засгийн үр дүнг илэрхийлэх нэгдмэл (интеграл) үзүүлэлт юм. Хүний аливаа зорилго чиглэлтэйгээр, тодорхой хэмжээний хөдөлмөр, хөрөнгө зарцуулсан үйл ажиллагааны үр дүнг эдийн засгийн ухаанд ДНБ зэрэг үр дүнгийн үзүүлэлтээр хэмждэг байна. Олон улсын байгууллагуудын боловсруулан гаргасан “Үндэсний тооцооны систем (ҮТС)-93” зөвлөмжөөс үзэхэд ДНБ-ийг **үйлдвэрлэлийн, ашиглалтын, орлогын** гэсэн 3 аргаар тооцдог.

Нийт үйлдвэрлэлтээс завсрын хэрэглээг хасч нэмэгдэл өртөг тооцохыг **үйлдвэрлэлийн**; хэрэглээ, хуримтлалын сан, гадаад худалдааны тэнцлийн зөрүүг тооцох замаар ДНБ-ий хэмжээг тодорхойлохыг **эцсийн ашиглалтын**; хөдөлмөрийн хөлс, үндсэн хөрөнгийн элэгдэл, шууд бус татвар, ашиг, түүнтэй адилтгах орлого зэрэг орлогын элементүүдийн нийлбэрээр ДНБ тооцохыг **орлогын** арга гэж тус тус нэрлэдэг.

ДНБ-ийг үйлдвэрлэлийн аргаар тооцсоноор улс орны эдийн засгийн өсөлт, түүний бүтцийн байдалд дүн шинжилгээ хийхийн хамт ҮТС-ийн данс, тухайлбал, үйлдвэрлэлийн дансыг эдийн засгийн сектороор байгуулах мэдээллийг бий болгоно. Орлогын аргын тооцоо нь орлогын дансуудыг байгуулахад чиглэгдсэн байхад ашиглалтын аргынх нь орлого ашиглалтын болон хөрөнгийн дансны мэдээллийг бүрдүүлнэ.

1.2 Дотоодын нийт бүтээгдэхүүн тооцох арга зүйн баримтлалууд

ДНБ-ий тооцооны хамрах хүрээ. ДНБ нь улс орны хил хязгаарын дотор нэг жилийн хугацаанд эдийн засгийн болон нийгмийн үйлчилгээний хүрээнд шинээр бүтээгдсэн нэмэгдэл өртгийн нийлбэр юм. Үүнээс үзвэл ДНБ-ий тооцоо нь нутаг дэвсгэрийн зарчимд тулгуурлаж эдийн засгийн харъяат болон харъяат бус бүх нэгжүүдийг хамруулна. Үүгээрээ үндэсний нийт орлогын (ҮНО) хамрах хүрээнээс ялгаатай.

Бараа, үйлчилгээний тухай ойлголт. Бараа, үйлчилгээ нь ДНБ-ий тооцооны гол объект бөгөөд түүнийг үйл ажиллагааны хүрээний бусад хэлбэрээс ялгах шалгуур нь бусдын хэрэгцээнд зориулан төлбөртэй үйлдвэрлэх, эсвэл үйлчлэх явдал юм. Харин хувь хүний хоол ундаа хийх, хувцсаа угаах, орон гэрээ цэвэрлэх, усанд орох, гоо сайхны үйлчилгээ хийх зэрэг хүний ахуйн болон амьдралын хэв маягтай холбоотой хөдөлмөрийн үйл ажиллагааг ҮТС-д хамааруулахгүй.

ДНБ-ий тооцоонд хэрэглэгдэх үнийн төрөл, агуулга. ҮТС-ийн арга зүйн чухал баримтлалын нэг нь үнийн төрөл, тэдгээрийн агуулгын талаархи ойлголт юм. ДНБ-ий тооцоонд дараах 3 төрлийн үнэ хэрэглэнэ. Үүнд: *үндсэн үнэ, үйлдвэрлэгчийн үнэ, худалдан авагчийн үнэ.* ҮТС-ийн арга зүй дэх үнэ бүрдэх зарчмыг үндсэнд нь үйлдвэрлэлийн ба арилжааны хүрээний гэсэн 2 үндсэн агуулгаар ойлгодог. Үйлдвэрлэлийн хүрээнийхэнд үндсэн үнийг, арилжааны хүрээнийхэнд үйлдвэрлэгчийн болон худалдан авагчийн үнийг тус тус хамруулдаг. Үнийн төрлүүдийн агуулга, үүргүүдийг дараах байдлаар томъёолно.

Үндсэн үнэ. Үйлдвэрийн газар нь аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлд гаргасан зардал, ашгаа тооцон багтаасан үнийг үндсэн үнэ гэнэ. Үүний зэрэгцээ үндсэн үнэд татаасыг оруулж тооцно. ҮТС-д энэ үнийг цэвэр үйлдвэрлэлийн хүрээний тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний гаргалтын буюу аливаа бүтээгдэхүүнд ногдуулсан татвар, түүнтэй төстэй бусад хураамжуудыг төлөхийн өмнөх үнэ гэж үздэг. Иймээс үндсэн үнийн бүрэлдэхүүнд бараа, үйлчилгээний татварыг оруулдаггүй. Үүний зэрэгцээ үндсэн үнийг үйлдвэрлэлийн хэмжээг жинхэнэ бодитой илэрхийлэх хэмжигдэхүүн гэж үзээд ДНБ-ий тооцооны нөхцөлд салбаруудын нийт үйлдвэрлэлийг үндсэн үнээр үнэлэхийг **үндсэн аргачлал** гэж зөвлөмж болгодог. Завсрын хэрэглээ нь худалдан авагчийн үнээр үнэлэгдсэн байдаг.

Үйлдвэрлэгчийн үнэ. Үндсэн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулдаг бараа, үйлчилгээний татваруудыг (нэмэгдэл өртгийн албан татвараас бусад) нэмж, татаасыг хасч тооцсон үнийг **үйлдвэрлэгчийн үнэ** гэнэ. Бараа, үйлчилгээг борлуулсны төлбөрийг (барааны үнийг) үйлдвэрлэгчийн үнээр хийдэг бөгөөд аж ахуйн нэгжүүд нэмэгдэл өртгийн татварыг хассан үнээр өөрийнхөө борлуулалтын хэмжээг тодорхойлдог.

Зах зээлийн буюу худалдан авагчийн үнэ. Үйлдвэрлэгчийн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулдаг нэмэгдэл өртгийн албан татварыг нэмж тооцсон үнийг **зах зээлийн буюу худалдан авагчийн үнэ** гэнэ.

ХОЁР. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АРГААР ТООЦОХ АРГА ЗҮЙ

2.1 Дотоодын нийт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцох

ДНБ-ий тооцооны үндсэн нэгж нь эдийн засгийн салбар, түүнд харъяалагдах аж ахуйн нэгж, байгууллага юм. Түүнчлэн зах зээлд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх өрхийн аж ахуйн үйл ажиллагааг мөн хамруулна. Үйлдвэрлэлийн аргын тооцоог эдийн засгийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангиллын дагуу үндсэн салбар, түүний дэд салбар тус бүрээр тооцно. Нэгжүүдийн үйл ажиллагааг зах зээлийн, зах зээлийн бус, өөрийн эцсийн хэрэглээнд зориулсан үйлдвэрлэлт гэж ялгаж авч үзнэ.

Зах зээлийн үйлдвэрлэлт нь зөвхөн ашиг олоход чиглэгдсэн байхын зэрэгцээ нэмэгдэл өртгийн бүтцэд нь ашиг, түүнтэй адилтгах орлого зэрэг үйлдвэрлэлийн хэмжээг цаашид нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын эх үүсвэр агуулагдсан байдаг. Зах зээлийн үйлдвэрлэлтэд санхүүгийн бус болон санхүүгийн зуучийн бүх салбарууд, өрхийн аж ахуй, түүнчлэн эдийн засгийн гадаад харилцааны үйл ажиллагаа хамаарна.

Зах зээлийн бус үйл ажиллагааны нөхцөлд худалдах, худалдан авах арилжааны харилцаа үүсэхгүй. Зах зээлийн бус үйлдвэрлэлтэд төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа, төрийн бус байгууллага зэрэг нийгмийн нийтлэг үйлчилгээний хүрээний үйл ажиллагааг оруулна.

Хэрэв зах зээлийн бус салбарын зарим нэгж бизнесийн үйл ажиллагаа явуулж, үйлдвэрлэлийн болон шууд бус татвар төлсөн бол энэ үйл ажиллагааг бүхэлд нь зах зээлийн үйлдвэрлэлтэд хамруулна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлт эрхэлдэг өрх, жижиг нэгжүүдэд өөрийн эцсийн хэрэглээнд зориулсан үйлдвэрлэлт явагддаг. Жишээ нь өрх нь өөрийн үйлдвэрлэсэн мах, сүү, ноос, ноолуураас өөрсдийн хэрэгцээнд хэрэглэх. Салбаруудын хувьд аж үйлдвэр, барилгын салбарууд нь өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс үйлдвэрлэлтэндээ хэрэглэх явдал байдаг. Тухайлбал, мах боловсруулах үйлдвэр нь хиам хийхдээ өөрийн үйлдвэрлэсэн махыг хэрэглэх, барилгын аж ахуйн нэгж нь дэргэдээ тоосгоны жижиг үйлдвэртэй бол өөрийн үйлдвэрлэсэн тоосгоо барилга барихдаа ашиглах гэх мэт. Өөрийн үйлдвэрлэлтээс өөрийн хэрэгцээнд хэрэглэсэн хэмжээг нийт үйлдвэрлэлтэд оруулж тооцно.

Зах зээлийн үйлдвэрлэлт явуулдаг нэгжүүдийн хувьд тэдгээрийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого, бусад орлогын нийлбэрээр нийт үйлдвэрлэлтийг тооцно. Үндсэн үйл ажиллагааны орлого нь тухайн нэгжийн голлон эрхэлж буй үйлдвэрлэл, үйлчилгээний орлого байх бөгөөд хэрвээ нэгж нь хэд хэдэн үйл ажиллагаа явуулдаг бол тэдгээрийн орлогыг үндсэн бус үйл ажиллагааны орлого гэнэ.

Өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг өөрийн эцсийн хэрэглээнд хэрэглэсэн бол түүнийг нийт үйлдвэрлэлтийн хэмжээнд оруулж тусгана. Зах зээлд борлуулсан нийт бүтээгдэхүүний борлуулалт дээр өөрийн хэрэгцээнд хэрэглэсэн бүтээгдэхүүний хэмжээг нэмж оруулна.

Зах зээлийн бус үйлдвэрлэлт явуулдаг нэгжүүдийн хувьд тухайн жилд зарцуулсан нийт урсгал зардлын хэмжээгээр нийт үйлдвэрлэлтийг тооцно.

Үйлдвэрлэл, үйлчилгээгээ явуулахын тулд зарцуулсан материалын зардал (хөрөнгө оруулалтын зардал орохгүй) болон үйлчилгээний төлбөрийг завсрын хэрэглээний зардал гэж үзнэ. Энэ нь нэгжүүдийн хувьд ерөнхийдөө адил төстэй зардлууд байдаг. Үүнд: үндсэн, туслах түүхий эд материал, эрчим хүч, ус, шатахуун, шатах тослох материал, сэлбэг хэрэгсэл, урсгал засвар, үйлдвэрлэл явуулахад хэрэглэсэн түлээ, нүүрс, барилга, байшин, тоног төхөөрөмж түрээсэлсний зардал, гадны байгууллага, тээврээр үйлчлүүлсний төлбөр, албан томилот, баяр ёслолын үйл ажиллагааны зардал, шуудан, холбоо, эргэлтийн бус сав баглаа боодол, ном, хэвлэл захиалга, бичиг хэрэгслэл, дахин сургалт, даатгал, харуул хамгаалалт, хөдөлмөр хамгаалал, зар сурталчилгааны зардал, үндсэн бус үйл ажиллагааны бусад зардал (ногдол ашгийн зардал, валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн алдагдал орохгүй) зэрэг зардлыг хамруулна. Эдгээр зардлуудаас гадна салбарын үйлдвэрлэлийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой зардлууд тусгагдана. Энэхүү нэмж тусгагдах зардлуудыг салбаруудын тооцоонд жич тусгасан болно.

Салбаруудын нэмэгдэл өртгийг тооцохдоо нийт үйлдвэрлэлтээс завсрын хэрэглээг хасна.

Нийт үйлдвэрлэлтийг үндсэн үнээр үнэлж тооцно. Салбаруудын нэмэгдэл өртгийн дүнгээс санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээний хэмжээг хасч, бүтээгдэхүүний цэвэр татварыг нэмж өгснөөр улсын дүнгээр ДНБ-ий хэмжээг зах зээлийн үнэ буюу худалдан авагчийн үнээр тооцогдоно. Үүнийг жишээгээр харуулбал:

сая төгрөг.			
А	Нийт үйлдвэрлэлт 1	Завсрын хэрэглээ 2	Нэмэгдэл өртөг 3=1-2
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	580.7	183.3	397.4
Загасны аж ахуй	4.1	2.5	1.6
Уул уурхай, олборлох үйлдвэр	757.2	391.6	365.6
Боловсруулах үйлдвэр	349.2	250.8	98.5
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	197.9	136.7	61.2
Барилга	178.8	132.3	46.5
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	600.0	135.0	465.1
Зочид буудал, зоогийн газар	58.4	38.5	19.9
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	621.2	380.3	240.9
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	183.1	111.8	71.3
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	100.1	72.8	27.3
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	177.0	106.2	70.8
Боловсролын салбарын үйл ажиллагаа	134.8	69.3	65.5
Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	76.6	43.7	32.9
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	28.1	16.8	11.3
Салбаруудын нэмэгдэл өртөг, үндсэн үнээр	4,047.4	2,071.6	1,975.8
Хасах нь: Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ			65.0
Нэмэх нь: Бараа, үйлчилгээний татвар (НӨАТ*-аас бусад)			150.0
Хасах нь: Татаас			30.0
Дотоодын нийт бүтээгдэхүүн, үйлдвэрлэгчийн үнээр			2,030.8
Нэмэх нь: Бараа, үйлчилгээний татвар НӨАТ*			160.0
Дотоодын нийт бүтээгдэхүүн, зах зээлийн үнээр			2,190.8

* Нэмэгдсэн өртгийн албан татвар

2.1.1 Салбаруудын нэмэгдэл өртгийн тооцоо

Салбаруудын нэмэгдэл өртгийн тооцоо хийхэд гол анхаарах зүйл нь мэдээллийг бүрэн хамруулах, нийт үйлдвэрлэлтийг салбаруудын онцлогийг тусган тооцох явдал юм.

ХӨДӨӨ АЖ АХУЙ, АН АГНУУР, ОЙН АЖ АХУЙ

1. Газар тариалан

1.1. Хамрах хүрээ. Газар тариалангийн салбарт улаан буудай, арвай, овъёос, хөх тариа, чихрийн манжин, тосны болон тамхины ургамал, малын тэжээл, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ зэргийг тариалах, хадлан бэлтгэх үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн аж ахуйн үйл ажиллагаа хамрагдана.

1.2. Мэдээллийн эх үүсвэр. “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн 200... оны ... сарын мэдээ” ХАА-3, “Хөдөө аж ахуйн компани, хоршооны үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын тайлан” ХАА-4, “Жимс, жимсгэний тариалсан талбай, хураасан ургацын мэдээ” ХАА-5, “Хадлан, тэжээл бэлтгэл, ургац хураалт” ХАА-7, “Газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжийн тариалсан талбайн 200... оны жилийн эцсийн мэдээ” ХАА-8, “Аж ахуйн нэгжийн (ХЭАА-гаас бусад) хураасан ургацын эцсийн мэдээ” ХАА-10а, “Өрх, хувиараа эрхлэх аж ахуйн хураасан ургацын эцсийн мэдээ” ХАА-10б маягт, Хүнс, хөдөө аж ахуйн яамны захиргааны статистик мэдээллийн маягт “Уринш элдэншүүлэлтийн 200... оны ... сарын мэдээ” нь мэдээллийн эх үүсвэр болно.

Газар тариалангийн үйл ажиллагаа голлон эрхэлдэг нэгжүүдэд бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн үнийн судалгаа, өрхүүдэд газар тариалангийн үйлдвэрлэлийн зардлын бүтцийн түүвэр судалгааг 5 жил тутам явуулж, бүтээгдэхүүний нэр төрлүүдээр улсын дундаж үйлдвэрлэгчийн үнийг, өрхийн үйлдвэрлэлтийн зардлын бүтцийг тогтооно. Уг судалгааны үр дүнг ҮСГ-ын даргын шийдвэрээр баталгаажуулж, салбарын тооцоонд ашиглана. Судалгаа хоорондын онуудын үйлдвэрлэгчийн үнийг тооцоходоо хөдөө аж ахуйн

бүтээгдэхүүний зах зээлийн үнийн мэдээний жилийн дундаж үнийн өөрчлөлтийг ашиглаж жил бүр тогтооно.

1.3. Нийт үйлдвэрлэлт. Газар тариалангийн салбарын нийт үйлдвэрлэлт нь үр тарианы, төмс, хүнсний ногооны, малын тэжээлийн ургамлын, жимс, жимсгэний гэх мэт бүтээгдэхүүний нэр төрлөөрх нийт ургацын үйлдвэрлэлт, дуусаагүй үйлдвэрлэлийн өөрчлөлтөөс бүрдэнэ.

Ургац хураалтын эцсийн мэдээ болон жимс, жимсгэний хураасан ургацын мэдээгээр авсан ургацын хэмжээг бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрээр нь үйлдвэрлэгчийн үнээр үнэлж, ургацын нийт үйлдвэрлэлтийг тооцно.

Нийт үйлдвэрлэлтийг зах зээлд борлуулсан, аж ахуйн дотоодод болон үрэнд, мөн өрхийн аж ахуйд хэрэглэсэн бүтээгдэхүүнээр задална.

Дуусаагүй үйлдвэрлэлийн өөрчлөлтийг уринш болон үр жимсээ өгөх хугацаа нь болоогүй суулгацын хувьд тооцно. Уриншийн хувьд тухайн жилийн эцэс дэх уринш боловсруулсан талбайн хэмжээнээс жилийн эхний талбайн хэмжээг хасч; үр жимсээ өгөх хугацаа болоогүй суулгацын хувьд мөн оны эцэс дэх тухайн насны суулгацын тооноос оны эхний суулгацын тоог хасч дуусаагүй үйлдвэрлэлийн өөрчлөлтийг тооцно.

Үүний дараа уриншийн талбайн дуусаагүй үйлдвэрлэлийн өөрчлөлтийг 1 га талбайн уринш боловсруулахад гарсан зардлаар үржүүлж; суулгацын тооны өөрчлөлтийг 1 суулгацыг тарьж ургуулахад зарцуулсан зардлаар үржүүлж, дуусаагүй үйлдвэрлэлтийн хэмжээг тооцно.

Нийт үйлдвэрлэлтийг аж ахуйн нэгжүүд болон өрхийн аж ахуй гэж тус бүрд нь тооцож улсын дүнг нэгтгэн гаргана. Нийт үйлдвэрлэлтийг зардлаар нь задлахдаа аж ахуйн нэгжийн хувьд жил бүр авдаг “Хөдөө аж ахуйн компани, хоршооны үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын тайлан”-гаас зардлын бүтцийг ашиглаж, өрхийн хувьд тусгайлсан судалгааны үр дүнг ашиглана.

Жич: Салбарын завсрын хэрэглээний онцлог зардал нь тухайн жилийн үйлдвэрлэлд хэрэглэсэн үр, тарих суулгацын зардал, бордооны зардал, усжуулалт, хортон мэрэгчидтэй тэмцэх зардал зэрэг зардлууд байна.

2. Мал аж ахуй

2.1. Хамрах хүрээ. Таван хошуу мал, цаа буга, илжиг, луус, гахай, шувуу, зөгий, туулай, нохой зэрэг мал амьтад өсгөн үржүүлж, ашиг шимийг нь ашиглах үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн аж ахуй, фермерийн аж ахуй хамрагдана.

2.2. Мэдээллийн эх үүсвэр. Мал аж ахуйн бүтээгдэхүүнийг тооцох гол мэдээлэл нь жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогын дүн юм. Мөн “Мал төллөлт, төл бойжилт” (ХАА-1), “Том малын зүй бус хорогдол” (ХАА-2), “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн 200... оны ... сарын мэдээ” ХАА-3, “Хөдөө аж ахуйн компани, хоршооны үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын тайлан” ХАА-4, “Мах боловсруулах үйлдвэрүүдэд бэлтгэсэн малын мэдээ” ХААБ-2 мэдээ нь мэдээллийн эх үүсвэр болно. Мал аж ахуй голлон эрхэлдэг нэгжүүдэд бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн үнэ, ашиг шимийн бүтээгдэхүүний гарцын түүвэр судалгааг тодорхой давтамжтайгаар явуулж, бүтээгдэхүүний нэр төрлүүдээр бүсийн үйлдвэрлэгчийн дундаж үнэ, ашиг шимийн бүтээгдэхүүний бүсийн дундаж гарцыг тогтооно. Уг судалгааг 5 жил тутам явуулж, судалгааны үр дүнг ҮСГ-ын даргын шийдвэрээр баталгаажуулна. Судалгаа хоорондын онуудын үйлдвэрлэгчийн дундаж үнийг тооцохдоо хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн мэдээний жилийн дундаж үнийн индексийг ашиглана.

2.3. Нийт үйлдвэрлэлт. Мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлт нь дараах үндсэн 3 төрлийн бүтээгдэхүүнээс бүрдэнэ. Үүнд:

2.3.1 Малын ашиг шимийн бүтээгдэхүүн

2.3.2 Малын өсөлт, үржилтийн бүтээгдэхүүн

2.3.3 Бусад бүтээгдэхүүн

2.3.1 Малын ашиг шимийн бүтээгдэхүүн. Мал бусад тэжээвэр амьтдыг өсгөж үржүүлсний дүнд бий болдог мах, ноос, ноолуур, арьс, шир, хөөвөр, хялгас, сүү, өндөг, бал зэрэг бүтээгдэхүүнийг ашиг шимийн бүтээгдэхүүн гэнэ.

Махны үйлдвэрлэлт. Махны нийт үйлдвэрлэлтийг махны хэрэглээнд зарцуулсан малын тоонд үндэслэн доорхи дарааллаар тооцно. Үүнд:

1. Тайлант оны эхний малын тоо, бойжуулсан төлийн нийлбэрээс зүй бусаар хорогдсон мал болон тайлант оны эцэст тоологдсон малын тоог хасч, хэрэглээнд зарцуулсан нийт малын тоог төрөл тус бүр дээр тодорхойлно.
2. Хэрэглээнд зарцуулсан нийт малын тооноос мах боловсруулах үйлдвэрт нядалсан малын тоог хасч, мал аж ахуйн салбарт тухайн жилд махны хэрэглээнд зарцуулсан малын тоог төрөл тус бүрээр тооцно.
3. Мэдээллийн эх үүсвэр хэсэгт дурьдсан түүвэр судалгааны үр дүнд үндэслэн малын амьдын жигнэсэн дундаж жинг төрөл тус бүр дээр бүсээр тогтооно. Энэхүү бүсээр тогтоосон жигнэсэн дундаж жинг шинэ судалгааны үр дүн гарах хүртэл тооцоонд ашиглах бөгөөд ингэхдээ жил бүрийн мал тооллогын үр дүнд үндэслэж, малын төрөл тус бүр дээр нас, хүйсээр жигнэж тооцно. Харин дараачийн судалгааны үр дүнг ашиглан 2 судалгааны хоорондох онуудын жигнэсэн дундаж жингийн гарцыг засварлаж, мах үйлдвэрлэлтийн динамикийг шинэчлэн тооцно.

Тооцоонд ашиглагдах тэмээний амьдын дундаж жинг тооцох жишээ:

	Нас гүйцсэн тэмээ		Өсвөр насны тэмээ		Буур
	эр	эм	эр	эм	
Тэмээн сүргийн бүтэц, 2005 онд, мал тооллогын дүнгээр, нас, хүйсээр	38.7	34.6	13.7	11.5	1.5
2006 онд явагдсан судалгаагаар бүсээр тогтоосон дундаж жин, кг	462	429	334	312	425

$$2005 \text{ оны тооцоонд ашиглах жигнэсэн дундаж жин} = (38.7 \cdot 462 + 34.6 \cdot 429 + 13.7 \cdot 334 + 11.5 \cdot 312 + 1.5 \cdot 425) / 100 = 415 \text{ кг}$$

4. Махны хэрэглээнд зарцуулсан малын тоог малын төрөл тус бүрээр бүсчилж тогтоосон жигнэсэн дундаж жингээр нь үржүүлж, мах үйлдвэрлэлтийн биет хэмжээг гаргана.
5. Малын төрөл тус бүрээр бүсчилж тогтоосон амьдын жингийн үйлдвэрлэгчийн дундаж үнийг амьдын жинг нядалгааны жинд шилжүүлэх хувиар үржүүлж, нядалгааны жингээрх үйлдвэрлэгчийн дундаж үнийг бүсчлэн тогтооно. Амьдын жинг нядалгааны жинд шилжүүлэх хувь хэмжээг мах боловсруулах үйлдвэрүүдийн мэдээлэлд үндэслэн жил бүр шинэчлэн тогтооно.
6. Мах үйлдвэрлэлтийн биет хэмжээг төрөл тус бүрийн нядалгааны жингийн бүсчилж тогтоосон үйлдвэрлэгчийн дундаж үнээр шууд үнэлж, малын амьдын жингээрх тухайн жилийн махны үйлдвэрлэлтийг тооцно. Судалгаа хоорондын онуудын үйлдвэрлэгчийн дундаж үнийг тооцохдоо хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн мэдээний жилийн дундаж үнийн индексийг ашиглана.

Сүүний үйлдвэрлэлт. Сүүний үйлдвэрлэлтийн хэмжээг төлтэй малаас сааж ашигласан сүүний хэмжээгээр тооцно.

Энэ нь тухайн жилд бойжуулсан төлийн тоог эх малын саалинд хамрагдалтын түвшин, нэг малын сүүний дундаж гарцаар үржүүлж, үйлдвэрлэсэн сүүний нийт хэмжээг тооцно гэсэн үг юм.

1. Тайлант онд бойжуулсан төлийн тоог эх малын саалинд хамрагдалтын түвшингээр үржүүлж саалинд хамрагдсан нийт эх малын тоог тодорхойлно. Эх малын саалинд хамрагдалтын түвшинг мал тооллогын дүнд үндэслэн малын төрлөөр тогтооно.
2. Саалинд хамрагдсан малын тоог малын төрөл тус бүрийн сүүний гарцаар нь үржүүлж, малаас сааж ашигласан сүүний хэмжээг гаргана.
3. Малаас сааж ашигласан сүүний хэмжээг бүсчилж тогтоосон үйлдвэрлэгчийн дундаж үнээр шууд үнэлж, тухайн жилийн сүүний үйлдвэрлэлтийн хэмжээг тодорхойлно. Сүүний үйлдвэрлэгчийн дундаж үнийг 5 жил тутам явуулдаг түүвэр судалгааны үр дүнд үндэслэн бүсчлэн тогтооно. Судалгаа хоорондын онуудын үйлдвэрлэгчийн дундаж үнийг тооцохдоо хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн мэдээний жилийн дундаж үнийн индексийг ашиглана.

4. Харин дараачийн судалгааны үр дүнд үндэслэн 2 судалгааны хоорондох онуудын сүүний гарцыг дахин засварлаж, сүүний үйлдвэрлэлийн динамикийг шинэчлэн тооцно.

2006 онд явагдсан түүвэр судалгааны үр дүнгээр өмнөх онуудын сүүний гарцыг засварлах жишээ:

Үнээний сүүний гарц, литр

	2006 оны түүвэр судалгаагаар	1998 оны түүвэр судалгаагаар	1998, 2006 оны судалгааны зөрүү	Нэг онд ногдох гарц	1999	2000	2001	2002	2003	2004	2005
Үнээний сүү, литр	497	402	95	12	414	426	438	450	462	474	485

1999 оны тооцоонд ашиглах үнээний сүүний гарц=402+12=414

2000 оны тооцоонд ашиглах үнээний сүүний гарц=414+12=426

2005 оны тооцоонд ашиглах үнээний сүүний гарц=474+12=485

Ноосны үйлдвэрлэлт. Тухайн жилд авч ашигласан ноосны нийт хэмжээг оны эхний малын тоон дээр үндэслэн тооцно. Оны эхний малын тоог нэг малаас авч ашиглах ноос, ноолуур, хөөвөр, хялгасны гарц болон ноос, ноолуур, хөөвөр, хялгасны үйлдвэрлэгчийн үнээр үржүүлж тооцно. Ноос, ноолуур, хөөвөр, хялгасны гарц, ноос, ноолуур, хөөвөр, хялгасны үйлдвэрлэгчийн үнийг 5 жил тутам явагдах түүвэр судалгааны үр дүнгээр тогтооно. Тооцооны ерөнхий зарчим, дараалал нь дээр дурьдсан мах, сүүний үйлдвэрлэлтийг тооцох аргатай адил байна.

Судалгааны үр дүнд тогтоосон нэг малаас авч ашиглах ноос, ноолуур, хөөвөр, хялгасны гарцад үндэслэж, хоёр судалгааны хоорондох жилүүдийн динамикийг засварлахдаа дараахь дарааллыг баримтална.

1. Хоёр судалгааны үр дүнгээр тогтоосон ноос, ноолуур, хөөвөр, хялгасны гарцын зөрүүг судалгаа хоорондын оны тоонд хувааж нэг жилд ногдох ноос, ноолуур, хөөвөр, хялгасны гарцны засварлагдах хэмжээг тодорхойлно.
2. Нэг жилд ногдох ноос, ноолуур, хөөвөр, хялгасны гарцны засварлагдах хэмжээн дээр өмнөх судалгаагаар тогтоосон ноос, ноолуур, хөөвөр, хялгасны гарцыг нэмж, тухайн жилийн ноос, ноолуур, хөөвөр, хялгасны засварласан гарцыг тогтооно. Ингэхдээ өмнөх оны засварласан гарц дээр нэг жилд ногдох ноолуур, хөөвөр, хялгасны гарцны засварлагдах хэмжээг нэмэх замаар дараачийн онуудын гарцыг тогтооно.

2006 онд явагдсан түүвэр судалгааны үр дүнгээр өмнөх оны хонины ноосны гарцыг засварлах жишээ:

Хонины ноосны гарц, грамм

	2006 оны түүвэр судалгаагаар	1998 оны түүвэр судалгаагаар	1998, 2006 оны судалгааны зөрүү	Нэг онд ногдох гарц	1999	2000	2001	2002	2003	2004	2005
Хонины ноос, грамм	1182	1426	-244	-30.5	1395	1365	1334	1304	1273	1243	1212

1999 оны тооцоонд ашиглах хонины ноосны гарц=1426+(-30.5) =1395

2000 оны тооцоонд ашиглах хонины ноосны гарц=1395+(-30.5) =1365

2005 оны тооцоонд ашиглах хонины ноосны гарц=1243+(-30.5) =1212

Арьс, ширний үйлдвэрлэлт. Арьс, ширний үйлдвэрлэлтийг хүнсний хэрэглээнд зарцуулсан нийт мал, том малын зүй бус хорогдол, хорогдсон төл болон хорогдсон малын

арьс, шир ашиглалтын хувийг ашиглаж тооцно. Тайлант жилд хүнсэнд хэрэглэсэн нийт малын арьсыг тооцоонд бүрэн хэмжээгээр, зүй бусаар хорогдсон том мал, төлийн арьсыг тодорхой хувиар бодож, арьс, ширний үйлдвэрлэлтэд оруулж тооцно. Хорогдсон том мал, хорогдсон төлийн арьсны ашиглагдах хувь хэмжээг мал тооллогын үр дүнгээр жил бүр шинэчлэн тогтооно. Нийт үйлдвэрлэлтийг тооцохдоо хүнсэнд хэрэглэсэн мал, зүй бусаар хорогдсон том мал, хорогдсон төлөөс ашигласан арьс, ширний хэмжээг судалгаагаар тогтоодог үйлдвэрлэгчийн үнээр үржүүлж тооцно. Судалгаа хоорондын онуудын үйлдвэрлэгчийн дундаж үнийг тооцохдоо хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн мэдээний жилийн дундаж үнийн индексийг ашиглана.

2.3.2 Малын өсөлт үржилтийн бүтээгдэхүүн нь тайлант хугацаанд тоологдсон бэлэн төл болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хүрээнд нөөцлөгдөн үлдсэн мал, амьтдын толгойн тооны өөрчлөлт юм. Манай орны нөхцөлд малын тарга хүч, жин нь намар гүйцдэг боловч өвөл, хаврын улиралд турж, намар авсан жингийнхээ гуравны нэгийг хүртэл алддаг тул суурин маллагаатай улс орнуудынхыг бодвол малын жин аль ч улиралд тогтвортой хадгалагдаж чаддаггүй. Иймд малын өсөлт, үржилтийн бүтээгдэхүүнийг тооцоход малын жин биш тоо толгойн өөрчлөлт голлох үүрэгтэй болно.

Малын өсөлт үржилтийн бүтээгдэхүүнийг дотор нь бэлэн төл, нас гүйцсэн болон өсвөр насны мал гэсэн хоёр ангиллаар тооцно. Үүнд:

- Тайлант хугацаанд тоологдсон бэлэн төлийг мал аж ахуйд шинээр бий болсон бүтээгдэхүүн гэж үзэж, төлийн төрөл тус бүрийн тоо толгойг бүсийн үйлдвэрлэгчийн дундаж үнээр нь шууд үнэлж тооцно.
- Нийт малын тооноос бэлэн тоологдсон төлийг нь хасч, оны эцэст байгаа нас гүйцсэн болон өсвөр насны малын тоог тооцно. Дараа нь оны эцэст байгаа нас гүйцсэн болон өсвөр насны малын тооноос оны эхэнд байсан энэ ангиллын малын тоог хасч, энэ насны малын тооны тайлант оны өөрчлөлт буюу тухайн онд нэмэгдсэн/хорогдсон тоог тооцож гаргана. Эцэст нь энэхүү нас гүйцсэн болон өсвөр насны малын тайлант оны өөрчлөлтийг малын төрөл бүр дээр үйлдвэрлэгчийн дундаж үнээр үнэлж, энэ насны малын өсөлт, үржилтийн бүтээгдэхүүнийг тооцно.

Малын өсөлт үржилтийн бүтээгдэхүүнийг улсын хэмжээнд тооцоход харгалзах нэг үзүүлэлт нь том малын зүй бус хорогдлын босго үзүүлэлт байна. Тайлант жилд том малын зүй бусын хорогдол нь малын төрөл бүр дээр доорхи босгоос давсан тохиолдолд хэвийн бус хорогдол гэж үзэж; босгоос давсан хэмжээг нас гүйцсэн малын өсөлт, үржилтийн бүтээгдэхүүний тооцоонд нэмж оруулж тооцно. Малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь буюу босго нь тэмээ, адууны хувьд 9.0 хувь, үхэр, хонь, ямааны хувьд тус бүр 10.0 хувь байна (Үндэсний статистикийн газрын дарга, Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 11 дүгээр сарын 15 – ны өдрийн 235/345 тоот хамтарсан тушаал).

Өсөлт үржилтийн бүтээгдэхүүнийг гахай, шувуу, цаа буга зэрэг тэжээвэр амьтдын хувьд зөвхөн толгойн тооны зөрүүгээр, дээрх аргаар тооцно.

3.3.3 Бусад бүтээгдэхүүнд тэжээвэр амьтдын арьс, бугын цусан эвэр, шувууны өндөг, өд, зөгийн бал, малын аргал, хөрсөн, өтөг бууцыг оруулж тооцно.

Зөгийн бал, бугын цусан эвэр, каракуль, булга, үнэг мэт үслэг амьтдын аж ахуйн арьсны үйлдвэрлэлтийг тухайн үйл ажиллагааг эрхлэн явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн аж ахуйгаас мал, тэжээвэр амьтдын тооллоготой хамтатган холбогдох мэдээллийг цуглуулж тооцно.

Өндөгний үйлдвэрлэлтэд тахиа болон бусад шувуунаас жилийн туршид авч ашигласан өндгийг оруулж тооцно. Өндгийг үнэлэхдээ мэдээллийн эх үүсвэр хэсэгт дурьдсан судалгааны үр дүнгээр гарсан үнийг ашиглана.

Малын аргал хөрсөн, өтөг бууцыг аж ахуйд ашигласан хэмжээ, үйлдвэрлэгчийн үнийг 5 жил тутам явагдах түүвэр судалгааны үр дүнгээр бүсчлэн тогтооно. Аж ахуйд ашигласан хэмжээг тухайн жилд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн гэж үзэн бүсийн үйлдвэрлэгчийн дундаж үнээр үнэлж тооцно.

Жич: Салбарын завсрын хэрэглээнд орох онцлог зардал нь малын тэжээл, эм тарилга, аргал хөрсөнгийн зардал зэрэг зардлууд байна.

Мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлтийг тооцох жишээ

Үзүүлэлт	Үйлдвэрлэлтийн хэмжээ
1. Малын ашиг шим бүтээгдэхүүн	(1=1.1+1.2+1.3+1.4)
1.1 Мах	(Хүнсэнд хэрэглэсэн мал *1 малын амьдын жин)* нэгжийн үнэ
1.2 Сүү	(Бойжуулсан төл * саалинд хамралтын хувь* 1 малын сүүний гарц)*нэгжийн үнэ
1.3 Ноос, ноолуур	(Оны эхний мал * ноос, ноолуур авалтын хувь* 1 малын ноос, ноолуурын гарц) *нэгжийн үнэ
1.4 Арьс шир	{Хүнсэнд хэрэглэсэн мал + (зүй бусаар хорогдсон мал, төл*арьс ашиглах хувь)}*нэгжийн үнэ
2.Өсөлт үржилтийн бүтээгдэхүүн	(2=2.1+2.2+2.3)
2.1 Бэлэн төл	(Бойжуулсан төл - төлийн бүх төрлийн зарлага) * нэгжийн үнэ
2.2 Том малын өсөлт үржилт	Том мал = өсвөр насны мал + нас гүйцсэн мал
	(Оны эцэс дэх том малын тоо - Оны эхэн дэх том малын тоо)* нэгжийн үнэ
2.3 Тэжээвэр амьтдын өсөлт үржилт	(Оны эцэс дэх гахай, шувуу, цаа буга, үнэг, туулай, илжиг, бүл зөгий - Оны эхэн дэх гахай, шувуу, цаа буга, үнэг, туулай, илжиг, бүл зөгий)* нэгжийн үнэ
3.Бусад бүтээгдэхүүн	(3=3.1+3.2+3.3+3.4+3.5)
3.1 Өндөг	(Тухайн жилд үйлдвэрлэсэн өндөг, зөгийн бал, бугын эвэр)*нэгжийн үнэ
3.2 Зөгийн бал	
3.3 Бугын эвэр	
3.4 Үслэг арьс	(Тухайн жилд үйлдвэрлэсэн каракуль арьс, үнэг, туулайн арьс) *нэгжийн үнэ
3.5 Өтөг, бууц, аргал, хөрзөн	(Тухайн жилд үйлдвэрлэсэн өтөг бууц, аргал хөрзөн) *нэгжийн үнэ
4. Нийт үйлдвэрлэлт	4=1+2+3

3. Ан агнуур

3.1. Хамрах хүрээ. Энд арилжааны зориулалтаар болон амьтны хүрээлэн, судалгаа, хүнсний зориулалтаар ан агнах, барих, агнасан ангийн арьс үсийг ашиглах, зэрлэг амьтан өсгөж, үржүүлэх үйл ажиллагаа хамрагдана. Энд аж ахуйд өсгөж үржүүлсэн амьтны бүтээгдэхүүн, спорт зугаалгын чиглэлийн ан агнуур орохгүй.

3.2. Мэдээллийн эх үүсвэр. Мэдээллийн гол эх үүсвэр нь Байгаль орчны яамны захиргааны статистик мэдээлэл болох "Агнуурын нөөц ашиглалт, хамгаалалтын тайлан" (БОХ-6), ан агнуурын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдээс авдаг албан ёсны статистик мэдээлэл болох "Ан агнуурын аж ахуйн үйл ажиллагааны жилийн тайлан" (АА-1), гадаад худалдааны статистик мэдээллийн мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний экспортын мэдээлэл байна.

3.3. Нийт үйлдвэрлэлт. Энэ салбарын нийт үйлдвэрлэлтийн хэмжээг Байгаль орчны яамны "Агнуурын нөөц ашиглалт, хамгаалалтын тайлан"-гийн "үйлдвэрлэлийн зориулалтаар", "ахуйн зориулалтаар" агнасан болон барьсан ан амьтны тоог ан амьтны (загас болон махны зориулалтаар агнасан ангаас бусад) төрлөөр гаргуулан ан амьтны төрөл тус бүрийн тоог "Ан, агнуурын тухай" Монгол улсын хуулинд заасны дагуу ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ, ан олзворын жишиг үнийг үндэслэн Засгийн газраас тогтоосон үнээр үржүүлэн тооцно. "Ан агнуурын тухай" Монгол улсын хуулинд заасны дагуу хууль бусаар агнуурын амьтан агнасан, барьсан этгээдийн ангийн зэвсэг, хэрэгсэл, агнасан, барьсан агнуурын амьтан, тэдгээрийн арьс, үс, мах, эвэр, заар, бусад түүхий эд болон олсон орлогыг хурааж улсын орлого болгодог учир хууль тогтоомж зөрчиж агнасан, барьсан ан амьтны тоог салбарын нийт үйлдвэрлэлтэд оруулахгүй.

Бугын ясан эвэр болон ан амьтныг агналгүйгээр бэлтгэдэг бүтээгдэхүүний хувьд гадаад худалдааны экспортын мэдээллээс экспортонд гаргасан тоо хэмжээг үйлдвэрлэгчийн үнээр үнэлэн тооцно.

Жич: Салбарын завсрын хэрэглээнд орох онцлог зардал нь нь ан амьтныг агнахад зарцуулсан сум, тээврийн хэрэгслийн ашиглалт, хоол хүнсний болон бусад зардлуудаас бүрдэнэ. Бусад зардал гэдэгт ан амьтныг агнах, барихад ашигласан өгөөш, бусад түүхий эд материалын зардлыг оруулна. Ан амьтныг агнахад зарцуулагдах сум, тээврийн хэрэгслийн ашиглалтын зардлыг ан амьтны төрөл тус бүрээр тооцно.

4. Ойн аж ахуй, мод бэлтгэл

4.1. Хамрах хүрээ. Энэхүү дэд салбарт мод суулгах, тарих, арчлах, ойн зурвас гаргах, гуалин, түлшний мод бэлтгэх, байгалийн ургамал (жимс, самар, мөөг зэрэг) түүж ашиглах үйл ажиллагаа (02 дугаар дэд салбар)-г хамруулна. Энд мөн цэцэг тарих, арчлах, чимэглэлийн зориулалттай ургамал, мод, сөөг тариалах, зүлэгжүүлэх үйл ажиллагаа орно.

4.2. Мэдээллийн эх үүсвэр. Дэд салбарын нийт үйлдвэрлэлтийн хэмжээг тооцоход Байгаль орчны яамны захиргааны статистик мэдээлэл болох “Ойн нөөцийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн тайлан” (БОХ-5), дээрх үйл ажиллагааг эрхэлдэг аж ахуйн нэгжүүдээс авдаг албан ёсны статистик мэдээлэл болох “Ойн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан” (ОАА-1), “Өрхийн орлого, зарлагын судалгаа”-ны үр дүнг голлон, бусад эх үүсвэрийг нэмэлт мэдээллийн хэлбэрээр ашиглана.

4.3. Нийт үйлдвэрлэлт. Дэд салбарын нийт үйлдвэрлэлтийн хэмжээг дараахь байдлаар тодорхойлно. Үүнд:

Нэр төрөл	Үйлдвэрлэлтийн хэмжээ	Мэдээллийн эх үүсвэр
1. Ойгоос мод бэлтгэх	1.1 Ойгоос бэлтгэсэн мод (мян.м ³) * Нэгжийн үйлдвэрлэгчийн нэгжийн үнэ	Байгаль орчны яамны захиргааны статистик мэдээлэл: “Ойн нөөцийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн тайлан” (БОХ-5)
2. Байгалийн ургамал түүж ашиглах	2.1 Байгалиас түүж ашигласан самар, жимсний хэмжээ * Нэгжийн үйлдвэрлэгчийн үнэ	“Өрхийн орлого, зарлагын судалгаа”-ны “Өрхийн хүнсний зүйлсийн хэрэглээ” бүлгийн “Жимс, жимсгэнэ” хэсгийн өрхийн хэрэглэсэн байгалийн самар, байгалийн жимсний хэмжээ
3. Ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт	3.1 Борлуулсан мод, үр, суулгац 3.2 Өөртөө хэрэглэсэн мод, үр, суулгац 3.3 Дуусаагүй үйлдвэрлэл (суулгасан мод г.м)-ийн үлдэгдлийн өөрчлөлт 3.4 Үйл ажиллагааны бус бусад орлого	“Ойн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан” (ОАА-1) (Зөвхөн ойжуулалт, цэцэрлэгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн нэгтгэл)
4. Нийт үйлдвэрлэлт	4=1+2+3	

Ойгоос бэлтгэсэн мод гэдэгт үйлдвэрлэлийн аргаар ямар нэг боловсруулалт хийгээгүй (зүсмэл болоогүй) үйлдвэрлэлийн болон түлшний зориулалтаар бэлтгэсэн гуалин, түлшний модыг оруулна.

Нийт үйлдвэрлэлтийг тооцохдоо ойгоос бэлтгэсэн модны хэмжээг “Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн тухай” Монгол улсын хуульд заасны дагуу ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг ойн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээ, бэлтгэж тээвэрлэх зай, модны төрлийг харгалзан Засгийн газраас тогтоосон ойгоос бэлтгэсэн хэрэглээний болон түлшний модны 1 м³-ийн үйлдвэрлэгчийн үнээр үржүүлж тооцно.

Цэцэг тарих, арчлах, чимэглэлийн зориулалттай ургамал, мод, сөөг тариалах, зүлэгжүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн нийт үйлдвэрлэлтийн хэмжээг тусад нь гаргаж нэгтгэнэ.

Жич: Салбарын завсрын хэрэглээнд орох онцлог зардал нь тухайн жилийн үйлдвэрлэлд хэрэглэсэн үр, тарих суулгацын зардал, бордооны зардал, усжуулалт, хортон мэрэгчидтэй тэмцэх зардал зэрэг зардлууд байна. Ойгоос мод бэлтгэх, байгалийн ургамал түүж ашиглах үйл ажиллагааны завсрын хэрэглээг “Ойн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан”-гийн нийт үйлдвэрлэлтийн бүтцийг ашиглана.

ЗАГАСНЫ АЖ АХУЙ

1. Хамрах хүрээ. Энд загасыг хүнсэнд хэрэглэх, арилжих, бусад зорилгоор агнах, амьтны хүрээлэн, судалгааны ажилд зориулж барих үйл ажиллагаа (05 дугаар дэд салбар)-г хамруулна. Сонирхогчдын спортын зориулалттай загас агнуурыг энд хамруулахгүй.

2. Мэдээллийн эх үүсвэр. Мэдээллийн гол эх үүсвэр нь тухайн онд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг тогтоосон Засгийн газрын тогтоол, “Загасны аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан” (ЗАА-1), гадаад худалдааны статистик мэдээллийн мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний экспортын мэдээлэл байна. Загасны аж ахуй эрхэлдэг нэгжүүдэд бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн үнийн судалгааг жил бүр явуулж, үйлдвэрлэгчийн дундаж үнийг тогтооно.

3. Нийт үйлдвэрлэлт. Энэ салбарын бүтээгдэхүүнийг тооцохдоо тухайн онд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар олборлох загасны тоо хэмжээний дээд хязгаарыг тогтоосон Засгийн газрын тогтоолыг үндэслэнэ. Нийт үйлдвэрлэлтийг дээр дурьдсан олборлосон загасны жингийн нийт хэмжээг 1 кг загасны үйлдвэрлэгчийн дундаж үнээр үнэлж тооцно.

Жич: Салбарын завсрын хэрэглээнд орох онцлог зардал нь тухайн жилийн үйлдвэрлэлд хэрэглэсэн үндсэн, туслах түүхий эд, материалын зардал болох загас барих болон үржүүлгийн хэрэгсэл, түүний сэлбэг, загасны хоол гэх мэт зардлууд байна.

АЖ ҮЙЛДВЭР

1. Хамрах хүрээ. “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын стандарт ангилал-III”-ын дагуу аж үйлдвэрийн салбар нь дотроо 3 дэд салбарт ангилагдана.

C. Уул уурхай, олборлох аж үйлдвэр

Энэхүү салбарт газрын гүнээс болон өнгөн хэсгээс хатуу, шингэн, хийн хэлбэртэй байгалийн ашигт малтмал олборлох, түүнийг цэвэрлэх, бутлах, ялгах зэргээр анхны боловсруулалт хийх үйл ажиллагааг хамруулна. Тухайлбал манай улсын хувьд

C.10. Нүүрс олборлолт

C.11. Газрын тос, шатдаг хий олборлолт

C.12. Уран, торын хүдэр олборлолт

C.13. Металлын хүдэр олборлолт

C.14. Бусад ашигт малтмал олборлолт гэсэн дэд салбарууд байна.

D. Боловсруулах аж үйлдвэр

Энэхүү салбарт материал түүхий эд, тэдгээрийн найрлагад байгаа эд зүйлсийг биетээр болон химийн аргаар боловсруулж өөр шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагааг хамруулна. Бүтээгдэхүүний эд ангийг угсрах үйл ажиллагааг (барилгаас бусад салбарын) үйлчилгээний онцлогоос хамаарч боловсруулах үйлдвэр, үл хөдлөх хөрөнгө, бизнесийн үйл ажиллагаа юм уу, эсвэл худалдааны харгалзах дэд салбарт оруулж өгнө. Жишээлбэл, машин тоног төхөөрөмжийн засварыг боловсруулах үйлдвэрийн тухайн дэд салбарын холбогдох бүлэгт, харин компьютер засварыг үл хөдлөх хөрөнгийн 725 гэсэн бүлэгт, автомашин болон гэр ахуйн барааны засварыг худалдааны холбогдох дэд салбар (50, 52)-т, гэх мэтээр олон улсын ангиллын дагуу хуваарилна. Боловсруулах аж үйлдвэрийн салбар нь дараах дэд салбаруудаас бүрддэг. Үүнд:

D.15. Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлт

D.16. Тамхи үйлдвэрлэл

D.17. Нэхмэлийн үйлдвэрлэл

D.18. Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт

D.19. Арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл

D.20. Мод, модон эдлэл үйлдвэрлэл

D.21. Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл

D.22. Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа

D.23. Кокс, шингэн болон цацраг идэвхт түлш үйлдвэрлэл

D.24. Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл

D.25. Резин болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл

D.26. Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл

D.27. Төмөрлөгийн үйлдвэрлэл

D.28. Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл

D.29. Машин, тоног төхөөрөмж үйлдвэрлэл

- D.30. Бичиг хэргийн болон тооцоолох техникийн үйлдвэрлэл
- D.31. Цахилгаан машин, хэрэглэл үйлдвэрлэл
- D.32. Радио, телевизор, холбооны тоног төхөөрөмж үйлдвэрлэл
- D.33. Эмнэлгийн багаж хэрэгсэл, нарийн хэмжүүр, хараа зүйн хэрэгсэл, цаг үйлдвэрлэл
- D.34. Автомашин, чиргүүл үйлдвэрлэл
- D.35. Тээврийн бусад төхөөрөмж үйлдвэрлэл
- D.36. Мебель тавилга, бусад боловсруулах үйлдвэрлэл
- D.37. Хоёрдогч түүхий эд үйлдвэрлэл

E. Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж.

Энэ салбарт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, халаалтын болон эрчим хүч үйлдвэрлэх зорилгоор уур, халуун ус үйлдвэрлэх, түгээх, хүн ам, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээнд зориулж ус хуримтлуулан ариутгаж, түгээх үйл ажиллагаа хамрагдана. Энэ салбар нь дараах дэд салбараас бүрдэнэ:

- E.40 Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл
- E.41 Ус ариутгал, усан хангамж

Дээр дурьдсан уул уурхай, олборлох үйлдвэр, боловсруулах аж үйлдвэр, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн дэд салбаруудад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг аж үйлдвэрийн мэдээнд хамруулна. Хэрвээ тухайн аж ахуйн нэгж дэргэдээ засвар, үйлчилгээний газартай, уг газар нь бие даасан тайлан тэнцэл гаргадаггүй бол үндсэн нэгжийнхээ салбарыг дагаж орно.

2. Мэдээллийн эх үүсвэр. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн жилийн тайлан (АҮ-7), аж үйлдвэрийн салбарын сарын мэдээ (АҮ-1) нь мэдээллийн гол эх үүсвэр болно. Түүнчлэн Үндэсний Татварын Ерөнхий Газрын татвар төлөгчдийн нэгдсэн сангийн мэдээллийг мэдээлэл шалгах эх үүсвэр болгон ашиглана. Мэдээллийг шалгахдаа борлуулалт, үйлдвэрлэлийн зардал, ашиг/алдагдлын хэмжээг томоохон нэгжүүдээр нь тулгаж үзнэ.

Аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй нэгжүүдээс 25-аас дээш ажиллагчидтай нэгжүүд (металлын хүдэр олборлолтын салбарын хувьд бүх нэгжүүд)-ийн мэдээллийг нэлэнхүй судалгаагаар авна.

Түүврийн хүрээ. Бизнес регистрийн сангаас аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг жилийн эцсийн байдлаар гаргуулж авна. Жагсаалтанд үндэслэн түүвэр судалгаанд 25-аас доош ажиллагчидтай нэгжүүдийг хамруулна.

Түүврийн зохиомж. Салбарын ангиллын 2 орны (15 дугаар салбар буюу хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлийн салбарын хувьд дэд салбаруудаар буюу 3 орны) түвшинд бүлэглэнэ. Үүний дараа аж ахуйн нэгж байгууллагуудыг салбар тус бүрээр ажиллагчдын тоогоор бүлэглэн дугаарлана. Аж ахуйн нэгжүүдийн салбарын ангиллын код болон ажиллагчдын тооны бүлэг хоёрыг холбож, дээрх байдлаар страта буюу түүврийн бүлэг үүсгэнэ. Үүнийг нүүрс олборлолтын салбараар жишээ болгон харуулбал:

Салбарын код	Ажиллагчдын тооны бүлэг	Түүврийн бүлгийн дугаар
10	1-4	1
10	5-9	2
10	10-14	3
10	15-24	4

Түүврийн бүлэг дэх нэгжийн тооноос хамааран тухайн бүлгийн аж ахуйн нэгжийг түүвэр судалгаанд хамруулах эсвэл нэлэнхүй судалгаанд оруулах эсэхийг тодорхойлж өгнө. Хэрвээ бүлэг дэх аж ахуйн нэгжийн тоо 5-аас доош байвал нэлэнхүй судалгаагаар мэдээллийг авна. Тухайлбал, цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын 1-4 ажиллагчидтай аж ахуйн нэгжүүд буюу 21/1 дүгээр бүлгийн аж ахуйн нэгжүүдийн тоо 5 байвал нэлэнхүй судалгаанд хамрагдана гэсэн үг юм. Тухайн бүлэг дэх нийт эх олонлогийн тооноос нэлэнхүй судалгаанд хамрагдах аж ахуйн нэгжүүдийг хасч, түүвэр судалгааны эх олонлогийг тодорхойлно.

Тухайн нэг бүлгээс түүврээр сонгогдох аж ахуйн нэгжийн тоог дараахь томъёогоор тодорхойлно.

$$n_h = \left(\frac{N_h S_{hy}}{\sum_{h=1}^h N_h S_{hy}} \right) (n)$$

n_h – h бүлгээс түүврээр сонгогдох нэгжийн тоо

N_h – h бүлгийн нийт эх олонлог дахь нэгжийн тоо

S_{hy} – h бүлгийн ажиллагчдын тооны стандарт алдаа

n – түүвэрлэлтийн эх олонлог буюу тухайн бүлгийн нийт аж ахуйн нэгжийн тоо

Түүвэрлэлт. Түүврийг хийхдээ бүлэглэсэн, санамсаргүй түүврийн аргыг хэрэглэнэ. Түүвэрлэлтийг хийхдээ MS-Excel программын VLOOKUP болон RANDBETWEEN функцуудыг ашигладаг.

1. Сонгогдох аж ахуйн нэгжийн тоо бүхий хүснэгтийг түүврийн бүлэг тус бүрээр бэлтгэнэ.
2. Нийт эх олонлогийн аж ахуйн нэгж тус бүрт санамсаргүй тоог харгалзуулна.
3. Нийт олонлогийг түүврийн бүлэг болон санамсаргүй тоогоор эрэмбэлнэ.
4. Санамсаргүй тоогоор эрэмбэлсэн нийт эх олонлогийг түүврийн бүлэг тус бүрээр бэлтгэсэн сонгогдох аж ахуйн нэгжүүдийн тоотой хүснэгттэй холбоно.
5. Түүврийн бүлэг тус бүрээс аж ахуйн нэгжүүдийг санамсаргүйгээр сонгон авна.

Түүврийн тархаалт. Салбар, бүлэг тус бүрээр түүвэрт сонгогдсон нэг нэгжид ногдох гүйцэтгэлээр нийт эх олонлогт тархаана.

3. Нийт үйлдвэрлэлт. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, үйлдвэрлэлийн бус нийт үйлдвэрлэлтийн орлого, худалдааны нэмэгдэл буюу худалдаж авсан барааг дахин борлуулснаас орсон цэвэр орлогын нийлбэрээс бүрдэнэ.

1. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг дараах байдлаар тооцно:

- + Тухайн жилд борлуулсан бараа, бүтээгдэхүүний борлуулалт
- + өөрийн үйлдвэрлэсэн бэлэн бараа, бүтээгдэхүүний жилийн эцсийн үлдэгдэл
- өөрийн үйлдвэрлэсэн бэлэн бараа, бүтээгдэхүүний жилийн эхний үлдэгдэл
- + үндсэн, туслах түүхий эд, материалын жилийн эцсийн үлдэгдэл
- үндсэн, туслах түүхий эд, материалын жилийн эхний үлдэгдэл
- + дуусаагүй үйлдвэрлэлийн жилийн эцсийн үлдэгдэл
- дуусаагүй үйлдвэрлэлийн жилийн эхний үлдэгдэл
- + харъяа газрууддаа шилжүүлсэн өөрийн бүтээгдэхүүн
- + өөрөө үйлдвэрлээд өөртөө хэрэглэсэн бүтээгдэхүүн (нэгжийн эздийн хувийн хэрэглээндээ авч хэрэглэсэн бүтээгдэхүүн орно)
- + ажиллагчиддаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн

2. Үйлдвэрлэлийн бус орлогод барилга, байшин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого болон үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлого (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) зэргийг оруулна.

3. Худалдаж авсан барааг дахин борлуулснаас орсон цэвэр орлого гэдэг нь худалдааны нэмэгдэл юм. Үүнийг дараах байдлаар тооцно:

- + Цаашид дахин борлуулахаар худалдаж авсан бэлэн бараа, бүтээгдэхүүнийг борлуулсны орлого
- дахин борлуулахаар худалдан авсан бэлэн бараа, бүтээгдэхүүний өртөг буюу худалдан авсан үнэ
- + дахин борлуулахаар худалдан авсан бэлэн бараа, бүтээгдэхүүний жилийн эцсийн үлдэгдэл
- дахин борлуулахаар худалдан авсан бэлэн бараа, бүтээгдэхүүний жилийн эхний үлдэгдэл

Жич: Салбарын завсрын хэрэглээг тооцоход анхаарах зүйл нь борлуулагдаагүй бэлэн бүтээгдэхүүн, дуусаагүй үйлдвэрлэлд ногдох зардлыг завсрын хэрэглээнд тусгасан байна.

БАРИЛГА

1. Хамрах хүрээ. Барилгын салбарын үйл ажиллагаанд барилгын талбай бэлтгэх, үйлдвэр, үйлчилгээ, инженерийн барилга, байгууламж болон орон сууц, албан конторын зэрэг бүх төрлийн барилга барих, зам, талбай, дамжуулах хоолой, шугам, гүүр, гадна тохижилт хийх, тоног төхөөрөмж, агааржуулалт, цахилгаан шат, дуу чимээний эсрэг тоноглол угсрах, байрлуулах, зам талбайн гэрэл, дохиоллын тоноглол угсрах, барилгыг дуусгах шатны ажил, шиллэх, өнгөлөх, цэвэрлэх зэрэг засал чимэглэлийн ажил, барилгын машин механизмыг жолоочтой нь түрээсээр ажиллуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг бизнес регистрийн сангаас авч, барилгын салбарын бүтээгдэхүүний тооцооны хүрээ болгоно.

Зарим томоохон аж ахуйн нэгжүүд өөрийн хөрөнгөөр барилга барьж байгаа бол үндсэн салбараас нь салгаж барилгын салбарт оруулж өгнө.

Иргэдийн хувиараа барьсан барилгыг барилгын салбарын бүтээгдэхүүний тооцоонд оруулна.

2. Мэдээллийн эх үүсвэр. “Барилгын аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны ... оны жилийн тайлан” ИБ-4 нь мэдээллийн гол эх үүсвэр болно. Түүнчлэн Үндэсний Татварын Ерөнхий Газрын татвар төлөгчдийн нэгдсэн сангийн мэдээллийг мэдээлэл шалгах эх үүсвэр болгон ашиглана. Мэдээллийг шалгахдаа борлуулалт, үйлдвэрлэлийн зардал, ашиг/алдагдлын хэмжээг томоохон нэгжүүдээр нь тулгаж үзнэ.

Иргэдийн хувиараа барьсан барилгыг тооцоход ашиглалтанд орсон орон сууцны мэдээг (ОС-1) ашиглана.

3. Нийт үйлдвэрлэлт. Барилгын ажил дагнан эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн хувьд нийт үйлдвэрлэлт нь бүтээгдэхүүн борлуулалтын орлого буюу барилга угсралт, их засварын ажлын борлуулалтын орлого, өөрөө үйлдвэрлээд өөртөө хэрэглэсэн бүтээгдэхүүн, харъяа нэгждээ шилжүүлсэн бүтээгдэхүүн, үндсэн, түүхий эд материалын өөрчлөлт, ажиллагчиддаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, барилга байшин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого, дахин борлуулахаар худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, ундсах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлого (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй), дуусаагүй барилгын үлдэгдлийн өөрчлөлт, бэлэн бүтээгдэхүүний (барьж дууссан барилгаас зарагдаагүй үлдсэн барилга нь бэлэн бараа, бүтээгдэхүүнд тооцогддог) үлдэгдлийн өөрчлөлтийн нийлбэрээс бүрдэнэ. *Худалдааны нэмэгдлийг аж үйлдвэрийн салбарын тооцооны арга зүйд тусгасантай нэг адил арга зүйгээр тооцно.*

Иргэдийн барьсан барилгын нийт үйлдвэрлэлтийг тооцохдоо ашиглалтад оруулсан орон сууцны ОС-1 мэдээний сууцны тусдаа байрны тоог ашиглан тооцоо хийнэ. Ингэхдээ тус мэдээгээр ирсэн ашиглалтанд оруулсан сууцны тусдаа байрны тоог Барилгын аж ахуйн нэгжийн тайлан (ИБ-4)-гаар ирсэн мэдээний тоотой тулган, давхардсан сууцны тоог хасч, үлдсэн сууцны тоог иргэд өөрсдийн хүчээр барьсан гэж үзнэ. Үүний дараа нийт үйлдвэрлэлтийн хэмжээг нь тодорхойлохдоо тодорхой давтамжтайгаар явуулсан “Иргэдийн хувиараа барьсан орон сууцны төсөвт өртөг”-ийн судалгааны үр дүнгээр гарсан энэ төрлийн орон сууцны өртгөөр үржүүлнэ. Завсрын хэрэглээг нь энэхүү судалгааны үр дүнгээр гарсан зардлын бүтцийг ашиглан тооцно. Судалгаа хоорондын онуудад иргэдийн барьсан барилгын төсөвт өртгийг хэрэглээний үнийн индексийн барилгын материалын үнийн индексээр засварласан үнээр үнэлж тооцно.

Барилгын салбарын нийт үйлдвэрлэлт нь барилгын ажил дагнан эрхэлдэг аж ахуйн нэгжүүд, томоохон аж ахуйн нэгжүүдийн өөрийн хөрөнгөөр барьж байгаа барилга, их засварын ажил, зам, гүүрийн ажил болон иргэдийн барьсан барилгын нийт үйлдвэрлэлтийн нийлбэр байна.

Жич: Салбарын завсрын хэрэглээг тооцоход анхаарах зүйл нь борлуулагдаагүй бэлэн бүтээгдэхүүн, дуусаагүй үйлдвэрлэлд ногдох зардлыг завсрын хэрэглээнд тусгасан байна.

БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА, МАШИН, ГЭР АХУЙН БАРААНЫ ЗАСВАРЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Хамрах хүрээ. Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд нь өөрсдөө үйлдвэрлэл явуулахгүй боловч үйлдвэрлэгчдээс бараа, материал худалдан авч, худалдан авсан бараагаа ямар нэгэн боловсруулалт хийхгүйгээр дахин худалддаг онцлогтой салбар юм. Худалдааны байгууллагууд ихэнхдээ бөөний болон жижиглэн худалдаа дагнах эсвэл холимог хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэн явуулж байна. Эмийн сангийн үйл ажиллагаа нь худалдааны салбарт хамрагдана.

“Бөөний болон жижиглэн худалдаа”-ны салбар нь дотроо 3 дэд салбарт ангилагдана. Үүнд:

G.50. Машин, мотоцикль, түлш, шатахууны худалдаа, засвар үйлчилгээ

G.51. Машин, мотоциклээс бусад барааны бөөний болон комиссын худалдаа

G.52. Машин, мотоциклээс бусад барааны жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ

Машин, мотоцикль, түлш, шатахууны худалдаа, засвар үйлчилгээ - шинэ болон хуучин автомашин мотоциклийн бөөний болон жижиглэнгийн худалдаа, техникийн засвар үйлчилгээ, сэлбэг шатахууны жижиглэн худалдаа орно.

Машин, мотоциклээс бусад барааны бөөний болон комиссын худалдаа - жижиглэн худалдаа, үйлдвэр, аж ахуйн газар, байгууллагын хэрэгцээнд барааг бөөнөөр нийлүүлдэг байгууллага, экспорт, импорт эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа орно.

Машин, мотоциклээс бусад барааны жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ - хүн ам, гэр ахуйн хэрэгцээнд дэлгүүр, лангуу, үүргийн болон захиалга, дуудлагаар бараа худалдах үйл ажиллагаа орно.

2. Мэдээллийн эх үүсвэр. Худалдааны албан секторын хувьд “Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны жилийн тайлан” ХУ-1 мэдээллийн маягтаар аж ахуйн нэгж байгууллагаас цуглуулсан мэдээлэл нь худалдааны салбарын нэмэгдэл өртгийг тооцох мэдээллийн үндсэн эх үүсвэр нь болно. Түүнчлэн Үндэсний Татварын Ерөнхий Газрын татвар төлөгчдийн нэгдсэн сангийн мэдээллийг мэдээлэл шалгах эх үүсвэр болгон ашиглана. Мэдээллийг шалгахдаа борлуулалт, үйлдвэрлэлийн зардал, ашиг/алдагдлын хэмжээг томоохон нэгжүүдээр нь тулгаж үзнэ.

Түүврийн хүрээ. Бизнес регистрийн сангаас худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг жилийн эцсийн байдлаар гаргуулж авна. Түүвэр судалгаанд жилд 50.0 сая төгрөгөөс доош борлуулалтын орлоготой нэгжүүдийг хамруулна.

Түүврийн зохиомж. Салбарын ангиллын 3 орны түвшинд бүлэглэнэ. Үүний дараа аж ахуйн нэгж байгууллагуудыг салбар тус бүрээр нийт борлуулалтын орлогоор бүлэглэн дугаарлана. Аж ахуйн нэгжүүдийн салбарын ангиллын код болон борлуулалтын орлогын бүлэг хоёрыг холбож, дээрх байдлаар страта буюу түүврийн бүлэг үүсгэнэ. Үүнийг жишээгээр харуулбал:

Салбарын код	Борлуулалтын орлогын бүлэг (төг)	Түүврийн бүлгийн дугаар
501	0 – 9 999 999	1
501	10 000 000 - 19 999 999	2
501	20 000 000 - 29 999 999	3
501	30 000 000 - 39 999 999	4
501	40 000 000 – 49 999 999	5

Түүврийг Улаанбаатар хот, аймгууд гэсэн 2 байршлаар хийнэ. Түүврийн бүлэг дэх нэгжийн тооноос хамааран тухайн бүлгийн аж ахуйн нэгжийг түүвэр судалгаанд хамруулах эсвэл нэлэнхүй судалгаанд оруулах эсэхийг тодорхойлж өгнө. Хэрвээ бүлэг дэх аж ахуйн нэгжийн тоо 5-аас доош байвал нэлэнхүй судалгаагаар мэдээллийг авна. Тухайлбал, жишээн дээрх салбарын 1 сая хүртэлх төгрөгийн борлуулалттай аж ахуйн нэгжүүд буюу 501/1 дүгээр бүлгийн аж ахуйн нэгжүүдийн тоо 5 байвал нэлэнхүй байдлаар сонгоно гэсэн үг юм. Тухайн бүлэг дэх нийт эх олонлогийн тооноос нэлэнхүй судалгаанд хамрагдах аж ахуйн нэгжүүдийг хасч, түүвэр судалгааны эх олонлогийг тодорхойлно.

Түүвэрлэлт. Түүврийг хийхдээ бүлэглэсэн, санамсаргүй түүврийн аргыг хэрэглэнэ. Түүвэрлэлтийг хийхдээ MS-Excel программын VLOOKUP болон RANDBETWEEN функцуудыг ашигладаг.

1. Сонгогдох аж ахуйн нэгжийн тоо бүхий хүснэгтийг түүврийн бүлэг тус бүрээр бэлтгэнэ.
2. Нийт эх олонлогийн аж ахуйн нэгж тус бүрт санамсаргүй тоог харгалзуулна.
3. Нийт олонлогийг түүврийн бүлэг болон санамсаргүй тоогоор эрэмбэлнэ.
4. Санамсаргүй тоогоор эрэмбэлсэн нийт эх олонлогийг түүврийн бүлэг тус бүрээр бэлтгэсэн сонгогдох аж ахуйн нэгжүүдийн тоотой хүснэгттэй холбоно.
5. Түүврийн бүлэг тус бүрээс аж ахуйн нэгжүүдийг санамсаргүйгээр сонгон авна.

Түүврийн тархаалт. Салбар, бүлэг тус бүрээр түүвэрт сонгогдсон нэг нэгжид ногдох гүйцэтгэлийг Улаанбаатар хот, аймаг гэсэн 2 байршлаар тус бүрт нь тооцно. Нэг нэгжийн гүйцэтгэлийг нийт эх олонлогт түүврийн 2 байршлаар тус бүрт нь тархаана.

3. Нийт үйлдвэрлэлт. Бөөний болон жижиглэн худалдааны байгууллагуудын бүтээгдэхүүнийг худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, барилга, байшин, ажиллагчиддаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс олсон орлого, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) нийлбэрээр тооцно.

Худалдааны нэмэгдлийг дараах байдлаар тооцно:

- + Худалдаж авсан бэлэн бараа, бүтээгдэхүүнийг борлуулсны орлого
- Худалдан авсан бэлэн бараа, бүтээгдэхүүний өртөг
- + Худалдан авсан бэлэн бараа, бүтээгдэхүүний жилийн эцсийн үлдэгдэл
- Худалдан авсан бэлэн бараа, бүтээгдэхүүний жилийн эхний үлдэгдэл

Үнэ нь буурсан, гэмтэж муудсан, хулгайд алдсан, идэж шамшигдуулсан барааны хувьд хорогдол гарч болох бөгөөд энэ үед тухайн барааны хувьд бүтээгдэхүүн нь хасах тэмдэгтэй гарч болох юм.

ЗОЧИД БУУДАЛ, ЗООГИЙН ГАЗАР

1. Хамрах хүрээ. Зочид буудал, амралт, сувилалын газрууд, замын дагуух буудал, түр хоноглох газрууд, ресторан, кафе, баар, гуанз, цайны газар, нийтийн хоолны газар, албан газрын гуанз, түр болон зөөврийн цайны газар, аялал жуучлал эрхэлж буй нэгжийн харъяа зочид буудал, ресторан, цайны газрууд хамрагдана.

2. Мэдээллийн эх үүсвэр. Зочид буудал, зоогийн газрын нэмэгдэл өртгийн тооцоог гаргахад мэдээллийн гол эх үүсвэр нь зочид буудлын үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан (ЗБ-1), зоогийн газрын үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан (ЗГ-1) маягтууд юм. Түүнчлэн Үндэсний Татварын Ерөнхий Газрын татвар төлөгчдийн нэгдсэн сангийн мэдээллийг мэдээлэл шалгах эх үүсвэр болгон ашиглана. Мэдээллийг шалгахдаа борлуулалт, үйлдвэрлэлийн зардал, ашиг/алдагдлын хэмжээг томоохон нэгжүүдээр нь тулгаж үзнэ.

Улаанбаатар хотод зоогийн газрын салбарт үйл ажиллагаа явуулж буй нэгжүүдээс 15-аас дээш ажиллагчидтай нэгжүүд, аймгуудын зоогийн газрын салбарт үйл ажиллагаа чвуулж буй нэгжүүдийн мэдээллийг нэлэнхүй судалгаагаар авна.

Түүврийн хүрээ. Бизнес регистрийн сангаас зоогийн газрын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг жилийн эцсийн байдлаар гаргуулж авна. Аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл нь байгууллагын нэр, регистрийн дугаар, байршлын код, хаяг утас, үйл ажиллагааны чиглэлийн код, ажиллагчдын тоо гэсэн үзүүлэлтүүдээс бүрдэнэ. Түүвэр судалгаанд Улаанбаатар хот дахь 15-аас доош ажиллагчидтай нэгжүүдийг хамруулна.

Түүврийн зохиомж. Аж ахуйн нэгжүүдийг ажиллагчдын тоогоор бүлэглэн дугаарлаж, түүврийн бүлэг үүсгэнэ.

Ажиллагчдын тооны бүлэг	Түүврийн бүлгийн дугаар
1-3	1
4-6	2
7-9	3
9-11	4
11-14	5

Түүврийн бүлэг дэх нэгжийн тооноос хамааран тухайн бүлгийн аж ахуйн нэгжийг түүвэр судалгаанд хамруулах эсвэл нэлэнхүй судалгаанд оруулах эсэхийг тодорхойлж өгнө. Хэрвээ бүлэг дэх аж ахуйн нэгжийн тоо 5-аас доош байвал нэлэнхүй судалгаагаар мэдээллийг авна. Тухайлбал, 1-3 ажиллагчидтай аж ахуйн нэгжүүдийн тоо 5 байвал нэлэнхүй байдлаар сонгоно гэсэн үг юм. Тухайн бүлэг дэх нийт эх олонлогийн тооноос нэлэнхүй судалгаанд хамрагдах аж ахуйн нэгжүүдийг хасч, түүвэр судалгааны эх олонлогийг тодорхойлно.

Түүврийн тархаалт. Түүврийн бүлэг тус бүрээр түүвэрт сонгогдсон нэг нэгжид ногдох гүйцэтгэлийг тооцож; нийт эх олонлогт нь тархаана.

3. Нийт үйлдвэрлэлт. Зочид буудал, зоогийн газрын салбарын нийт үйлдвэрлэлтийг салбар тус бүрээр тооцож, дараа нь нийлбэр дүнгээр нь авна.

Зочид буудлын нийт үйлдвэрлэлтийг зочид буудлын ор хоногийн орлого, буудлын дэргэдэх зоогийн газрын хоолны үйлчилгээний орлого, буфетийн худалдааны нэмэгдлийн орлого, үндсэн, түүхий эд материалын өөрчлөлт, байр, тоног төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого, ажиллагчиддаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) нийлбэрээр тооцно.

Зоогийн газрын нийт үйлдвэрлэлтийг тооцохдоо зоогийн газрын хоолны үйлчилгээний орлого, буфетийн худалдсан бүтээгдэхүүний худалдааны нэмэгдлийн орлого, үндсэн, түүхий эд материалын өөрчлөлт, байр, тоног төхөөрөмжийн түрээснээс орсон орлого, ажиллагчиддаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, ажиллагчиддаа үнэ төлбөргүй өгсөн хоол, түлээ, нүүрсний зардал, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөрийн орлого орохгүй) нийлбэрээр тооцно.

Буфетийн худалдсан барааны худалдааны нэмэгдлийг дараах байдлаар тооцно:

- + Худалдаж авсан бэлэн бараа, бүтээгдэхүүнийг борлуулсны орлого
- Худалдан авсан бэлэн бараа, бүтээгдэхүүний өртөг
- + Худалдан авсан бэлэн бараа, бүтээгдэхүүний жилийн эцсийн үлдэгдэл
- Худалдан авсан бэлэн бараа, бүтээгдэхүүний жилийн эхний үлдэгдэл

Жич: Салбарын завсрын хэрэглээнд орох онцлог зардал нь хоолны хольц материалын зардал, цагаан хэрэглэл худалдаж авсан болон угааж цэвэрлэсэн зардал зэрэг зардлууд байна.

ТЭЭВЭР, АГУУЛАХЫН АЖ АХУЙ, ХОЛБОО

Энэ салбарын нэмэгдэл өртгийг дэд салбар, дэд бүлэг тус бүрээр тооцно.

1. Тээвэр, агуулахын аж ахуйн салбарын үйл ажиллагаа

1.1. Хамрах хүрээ. Тээврийн салбарт төмөр зам, агаарын тээвэр, авто болон усан замын тээвэр эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын зорчигч тээвэрлэлт, ачаа тээвэрлэлт, тээврийн бусад үйлчилгээг хамруулна. Хэрвээ тухайн аж ахуйн нэгж дэргэдээ засвар, үйлчилгээний газартай, уг газар нь бие даасан тайлан тэнцэл гаргадаггүй бол үндсэн нэгжийнхээ салбарыг дагаж орно.

Хувьдаа тээврийн хэрэгсэлтэй хувь хүмүүсийн бусдад үзүүлсэн тээврийн үйлчилгээг аль болох тооцож оруулах шаардлагатай. Ердийн хөсгөөр төлбөртэй үйлчилгээ хийсэн бол оруулна, өрх өөрийнхөө ердийн хөсгөөр нүүх, тээвэр хийсэн бол хамаарахгүй.

1.2. Мэдээллийн эх үүсвэр. Тээвэр, агуулах, тээврийн зуучлалын үйл ажиллагаа эрхэлдэг, санхүүгийн тайлан баланс гаргадаг аж ахуйн нэгж, байгууллагуудаас цуглуулдаг

“Тээврийн салбарын үйл ажиллагааны жилийн тайлан” Т-5 мэдээ нь мэдээллийн гол эх үүсвэр байна. Түүнчлэн Үндэсний Татварын Ерөнхий Газрын татвар төлөгчдийн нэгдсэн сангийн мэдээллийг мэдээлэл шалгах эх үүсвэр болгон ашиглана. Мэдээллийг шалгахдаа борлуулалт, үйлдвэрлэлийн зардал, ашиг/алдагдлын хэмжээг томоохон нэгжүүдээр нь тулгаж үзнэ.

1.3. Нийт үйлдвэрлэлт. Нийт үйлдвэрлэлт нь ачаа тээвэрлэлтийн орлого, зорчигч тээвэрлэлтийн орлого, үндсэн, түүхий эд материалын өөрчлөлт, хэрвээ бэлэн бараа, бүтээгдэхүүнийг цаашид дахин борлуулахаар худалдан авч борлуулсан бол худалдааны нэмэгдэл, байр, тоног төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) нийлбэрээр тооцно. *Худалдааны нэмэгдлийг аж үйлдвэрийн салбарын тооцооны арга зүйд тусгасантай нэг адил арга зүйгээр тооцно.*

2. Аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаа

2.1. Хамрах хүрээ. Иргэдийг гадаад, дотоодод аялал жуулчлалаар явуулдаг нэгжүүд болон жуулчин хүлээж авдаг үйл ажиллагаа эрхэлдэг нэгжүүд (жуулчны бааз, гэр бааз, ангийн отгууд) хамрагдана.

2.2. Мэдээллийн эх үүсвэр. Зам, Тээвэр, Аялал Жуулчлалын Яамны захиргааны статистик мэдээлэл “Аялал жуулчлалын аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан” ДБЯ-6 нь мэдээллийн гол эх үүсвэр болно. Түүнчлэн Үндэсний Татварын Ерөнхий Газрын татвар төлөгчдийн нэгдсэн сангийн мэдээллийг мэдээлэл шалгах эх үүсвэр болгон ашиглана. Мэдээллийг шалгахдаа борлуулалт, үйлдвэрлэлийн зардал, ашиг/алдагдлын хэмжээг томоохон нэгжүүдээр нь тулгаж үзнэ.

2.3. Нийт үйлдвэрлэлт. Гадаад, дотоодод аялал жуулчлалаар явуулдаг нэгжүүдийн хувьд нийт үйлдвэрлэлт нь аялал жуулчлалыг зохион байгуулсан зуучлалын орлого, ажиллагчиддаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, барилга байшин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого, хэрвээ бэлэн бараа, бүтээгдэхүүн худалдан авч цаашид дахин борлуулсан бол барааг дахин борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) нийлбэрээс бүрдэнэ. *Худалдааны нэмэгдлийг аж үйлдвэрийн салбарын тооцооны арга зүйд тусгасантай нэг адил арга зүйгээр тооцно.*

Аялал жуулчлалыг зохион байгуулсан зуучлалын орлогыг дараах байдлаар тооцно:

- + *Иргэдээс аялал жуулчлалын төлбөрт авсан нийт орлого*
- *Аялал жуулчлалыг зохион байгуулахад гарсан нийт бодит зардал буюу ертөг*

Аялал жуулчлалыг зохион байгуулахад гарсан холбогдох зардал гэдэг нь тухайн үйлчилгээг үзүүлэхэд гарсан бодит зардлууд (тээврийн зардал, зочид буудал, хоол, орчуулга, үзвэр үйлчилгээний зардал гэх мэт) юм.

Иргэдээс аялал жуулчлалын төлбөрт авсан нийт орлогыг тооцохдоо аялалыг зохион байгуулах зардалд 1 хүнээс авч байгаа багц төлбөрийг жуулчлалд хамрагдсан нийт иргэдийн тоогоор үржүүлж гаргана.

Аялал жуулчлалыг зохион байгуулахад гарсан бодит зардлыг тооцохдоо мөн тухайн аяллыг зохион байгуулахад 1 хүнд зарцуулсан бодит зардлыг жуулчлалд хамрагдсан нийт иргэдийн тоогоор үржүүлж гаргана.

Жуулчин хүлээж авдаг үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн хувьд нийт үйлдвэрлэлт нь буудлын ор хоногийн орлого, буудлын дэргэдэх зоогийн газрын хоолны үйлчилгээний орлого, буфетийн худалдааны нэмэгдэл, үндсэн, түүхий эд материалын өөрчлөлт, байр, тоног төхөөрөмжийн түрээснээс орсон орлого, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) нийлбэрээр тооцно. *Худалдааны нэмэгдлийг аж үйлдвэрийн салбарын тооцооны арга зүйд тусгасантай нэг адил арга зүйгээр тооцно.*

Хэрвээ тухайн нэгж нь аялал, жуулчлалыг өөрсдөө бие даан зохион байгуулдаг бол аялал жуулчлалыг зохион байгуулсан зуучлалын орлогыг тооцож, нийт үйлдвэрлэлтэд оруулна.

Жич: Салбарын завсрын хэрэглээнд орох онцлог зардал нь хэрвээ тухайн нэгж өөрсдөө жуулчин хүлээж авдаг үйл ажиллагаа эрхэлдэг бол хоолны хольц материалын зардал, цагаан хэрэглэл худалдаж авсан болон угааж цэвэрлэсэн зардал зэрэг зардлууд байна.

3. Холбооны салбарын үйл ажиллагаа

3.1. Хамрах хүрээ. Улсын шуудангийн үйл ажиллагаа, улсын шуудангаас бусад буухиа шуудангийн үйл ажиллагаа, яриа, дүрсийг дамжуулах, мэдээ болон мэдээллийг кабелийн шугам (кабелийн телевиз), радио телевизийн шугам, релей ба сансрын антеннын тусламжтай дамжуулах, телефон утас, телеграф ба телефаксын холбоо, радио ба телевизийн нэвтрүүлгийг дамжуулах, сүлжээний засвар үйлчилгээг үзүүлэх, интернетэд холбогдох, түүнийг ашиглах үйлчилгээ үзүүлэх, олон нийтийн үйлчилгээний утас (таксафон), үүрэн телефон холбоо зэрэг үйлчилгээ үзүүлдэг дэд салбарууд хамрагдана.

3.2. Мэдээллийн эх үүсвэр. “Холбооны салбарын үйл ажиллагааны жилийн тайлан” Х-5 мэдээ нь мэдээллийн гол эх үүсвэр байна. Түүнчлэн Үндэсний Татварын Ерөнхий Газрын татвар төлөгчдийн нэгдсэн сангийн мэдээллийг мэдээлэл шалгах эх үүсвэр болгон ашиглана. Мэдээллийг шалгахдаа борлуулалт, үйлдвэрлэлийн зардал, ашиг/алдагдлын хэмжээг томоохон нэгжүүдээр нь тулгаж үзнэ.

3.3. Нийт үйлдвэрлэлт. Холбооны салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын нийт үйлдвэрлэлт нь шуудан болон цахилгаан холбооны орлого, телефоны сарын хураамж, радиожуулалтын орлого, телевизийн хураамж, түрээсийн сувгийн болон шугамын орлого, холбооны хэрэгслийн шинээр тавилт, шилжүүлэлтийн орлого, үндсэн, туслах түүхий эд материалын өөрчлөлт, хэрвээ бэлэн бараа, бүтээгдэхүүн худалдан авч цаашид дахин борлуулсан бол барааг дахин борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) нийлбэрээс бүрдэнэ. *Худалдааны нэмэгдлийг аж үйлдвэрийн салбарын тооцооны арга зүйд тусгасантай нэг адил арга зүйгээр тооцно.*

САНХҮҮГИЙН ГҮЙЛГЭЭ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Энэ салбарын нэмэгдэл өртгийг дэд салбар, дэд бүлэг тус бүрээр тооцох бөгөөд дараахь үйл ажиллагааг хамруулна. Үүнд:

65. Даатгал, тэтгэврээс бусад санхүүгийн гүйлгээ

651. Мөнгөн гүйлгээ. Энд мөнгөн хөрөнгө хүлээн авах, хадгаламж бүрдүүлэх ажиллагаа орно. Санхүүгийн байгууллагуудын хоорондын тооцоо хийх банкны үйл ажиллагаанд хяналт тавих, гадаад валютын нөөцтэй байх зэргээр улс орны мөнгөн гүйлгээ хийдэг байгууллагууд болон хадгаламжийн банк, зээлийн банкны үйл ажиллагаа хамрагдана.

659. Санхүүгийн бусад гүйлгээ хийдэг байгууллага. Энд санхүүгийн түрээс (машины тоног төхөөрөмж, гэр ахуйн барааны түрээс 71-д орно.), банкны системээс гаднах санхүүгийн бус байгууллагын олгосон зээл, өргөн хэрэгцээт барааны баталгаат зээл, үйлдвэрийн урт хугацааны зээл г.м орно. Мөн зээлээс бусад замаар хийх санхүүгийн гүйлгээ болох хөрөнгө оруулалтын үнэт цаас, хувь нийлүүлэгчийн эрхийн бичиг, төлбөрийн баталгаа зэрэг үнэт цаасны гүйлгээ орно.

66. Албан журмын нийгмийн даатгалаас бусад даатгал. Энд амь даатгал, гэнэтийн осол, гал түймэр, эд хөрөнгийн даатгал орно.

67. Санхүүгийн туслах үйл ажиллагаа

Үүнд санхүүгийн гүйлгээтэй холбоотой үйлчилгээ үзүүлэх, санхүүгийн зах зээлийг хөтлөн явуулах үйл ажиллагаа, хөрөнгийн биржийн үйл ажиллагааг хамруулна.

Манай практикт энэ салбарт мөнгөн хадгаламж, зээллэг, үнэт цаас худалдан борлуулах зэргээр бэлэн мөнгө цуглуулан санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг арилжааны банк, түүний салбар, нэгжүүд, даатгалын байгууллагууд, түүний салбарууд, хөрөнгийн бирж, үнэт цаасны компаниуд хамрагдана. Энд мөн хонжворт сугалаа эрхлэн явуулдаг

газрууд, барьцаат зээллэг олгох газрууд, түүнчлэн валют солих цэгүүдийн үйл ажиллагааг хамруулна.

1. Банкны үйл ажиллагаа

1.1 Хамрах хүрээ. Энэ салбарт Монгол банк, арилжааны банкуудын үйл ажиллагааг хамруулна.

1.2. Мэдээллийн эх үүсвэр. “Монгол Банкны орлого, зарлагын мэдээ” МБ-1 маягт, “Арилжааны банкны орлого, зарлагын улирлын тайлан” ББ-1 маягтыг ашиглана.

1.3. Нийт үйлдвэрлэлт. Монгол банкны хувьд нийт үйлдвэрлэлт нь хүүгийн (гадаадын банкнаас орох хүү, зээлийн хүү, засгийн газарт олгосон хүү, засгийн газрын үнэт цаасны хүү) орлогоос төлсөн хүүгийн (гадаадын банкинд төлсөн хүү, харилцах хадгаламжийн хүү, зээлийн хүү, Сангийн яаманд төлсөн хүү, Төв банкны үнэт цаасны хүү) төлбөрийг хассан зөрүү буюу хүүгийн цэвэр орлого, гадаад валютын арилжааны цэвэр орлого, худалдсан мөнгөн тэмдэгтийн цэвэр орлого, гүйлгээний шимтгэл, торгууль, байр, тоног төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого, бусад орлого (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) зэргээс бүрдэнэ.

Хүүгийн цэвэр орлогыг дараах байдлаар тооцно:

- + Хүүгийн орлого
- Хүүгийн зардал

Гадаад валютын арилжааны цэвэр орлогыг дараах байдлаар тооцно:

- + Гадаад валютын арилжааны орлого
- Гадаад валютын арилжааны зардал

Арилжааны банкуудын хувьд нийт үйлдвэрлэлт нь хүүгийн орлогоос хүүнд төлсөн төлбөрийг хассан зөрүү буюу хүүгийн цэвэр орлого, гадаад валютын арилжааны цэвэр орлого, үнэт цаасны арилжааны цэвэр орлого, үйлчилгээний шимтгэлүүд, торгууль, хөрөнгийн түрээс буюу барилга, байшин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого, бусад үндсэн бус үйл ажиллагааны орлого (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) зэргээс бүрдэнэ. Гадаад валютын болон үнэт цаасны ханшийн тэгшитгэлийн орлогыг нийт үйлдвэрлэлтэд оруулахгүй. Хүүгийн цэвэр орлого, гадаад валютын арилжааны орлогыг Монгол банкны тооцоонд тусгасантай адил зарчмаар тооцно.

Жич: Салбарын завсрын хэрэглээнд орох онцлог зардал нь СВИФТ-ийн зардал (гадаадын банкуудаар дамжуулан гүйлгээ хийх эрхийн төлбөр), автоматжуулалтын зардал зэрэг зардлууд байна.

2. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа

2.1 Хамрах хүрээ. Энэ салбарт зээлийн үйлчилгээ, гадаад валютын үйлчилгээ, санхүүгийн түрээсийн үйлчилгээ хийдэг санхүүгийн байгууллага буюу банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг хамруулна.

2.2. Мэдээллийн эх үүсвэр. “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны 20... оны ...-р улирлын тайлан” ББСБ-1 маягтаар Санхүүгийн зохицуулах хорооноос авдаг мэдээллийг ашиглана. Түүнчлэн Үндэсний Татварын Ерөнхий Газрын татвар төлөгчдийн нэгдсэн сангийн мэдээллийг мэдээлэл шалгах эх үүсвэр болгон ашиглана. Мэдээллийг шалгахдаа борлуулалт, үйлдвэрлэлийн зардал, ашиг/алдагдлын хэмжээг томоохон нэгжүүдээр нь тулгаж үзнэ.

2.3. Нийт үйлдвэрлэлт. Банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд нийт үйлдвэрлэлт нь хүүгийн цэвэр орлого, гадаад валютын арилжааны цэвэр орлого, санхүүгийн түрээсийн орлого, үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого, торгуулийн орлого, байр, тоног төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого, ердийн бус цэвэр орлого, бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) нийлбэрээс бүрдэнэ.

Хүүгийн цэвэр орлогыг дараах байдлаар тооцно:

- + Зээлийн хүүгийн орлого
- + Хадгаламж харилцах дансны хүүгийн орлого
- Хүүгийн зардал

Гадаад валютын арилжааны цэвэр орлогыг дараах байдлаар тооцно:

- + Гадаад валютын арилжааны орлого
- Гадаад валютын арилжааны зардал

Ердийн бус цэвэр орлогыг дараах байдлаар тооцно:

+ *Ердийн бус орлого*

- *Ердийн бус зардал*

Жич: Салбарын завсрын хэрэглээнд орох онцлог зардал нь торгуулийн зардал, даатгалын зардал, автоматжуулалтын урсгал зардал, үнэт цаас, зээл, санхүүгийн түрээсийн тооцоо, итгэлцлийн үйлчилгээ, факторингийн (зээлдүүлэгч буюу үүрэг гүйцэтгүүлэгчээс мөнгөн төлбөрийн үүргийг шаардах эрхээ гуравдагч этгээдэд бүхэлд нь шилжүүлэх, худалдах) үйлчилгээтэй холбогдон гарсан зардал зэрэг зардлууд байна.

3. Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа

3.1 Хамрах хүрээ. Энэ салбарт хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааг хамруулна.

3.2. Мэдээллийн эх үүсвэр. “Хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагааны 20... оны ...-р улирлын тайлан” ХЗХ-1 маягтаар Санхүүгийн зохицуулах хорооноос авдаг мэдээллийг ашиглана. Түүнчлэн Үндэсний Татварын Ерөнхий Газрын татвар төлөгчдийн нэгдсэн сангийн мэдээллийг мэдээлэл шалгах эх үүсвэр болгон ашиглана. Мэдээллийг шалгахдаа борлуулалт, үйлдвэрлэлийн зардал, ашиг/алдагдлын хэмжээг томоохон нэгжүүдээр нь тулгаж үзнэ.

3.3. Нийт үйлдвэрлэлт. Хадгаламж, зээлийн хоршооны хувьд нийт үйлдвэрлэлт нь хүүгийн цэвэр орлого, шимтгэл, торгууль, бусад үйлчилгээний орлого, барилга байшин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого, бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) нийлбэрээс бүрдэнэ. Хүүгийн цэвэр орлогыг Монгол банкны тооцоонд тусгасантай адил зарчмаар тооцно.

Жич: Салбарын завсрын хэрэглээнд орох онцлог зардал нь торгуулийн зардал, автоматжуулалтын урсгал зардал зэрэг зардлууд байна.

4. Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ

4.1 Хамрах хүрээ. Энэ салбарт барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийг хамруулна.

4.2. Мэдээллийн эх үүсвэр. “Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын 20... оны ...-р улирлын тайлан” БЗҮ-1 нь мэдээллийн эх үүсвэр болно. Регистрийн сан дахь тухайн үйл ажиллагаа эрхэлдэг нэгжүүдийн тоонд үндэслэн аймгууд дахь нэгжүүдийн мэдээллийг нэлэнхүй судалгаагаар, нийслэл дэх нэгжүүдийн мэдээллийг түүвэр судалгаагаар авна. Түүвэрлэлтийг орлогын мэдээлэлд тулгуурлан хийнэ. Түүнчлэн Үндэсний Татварын Ерөнхий Газрын татвар төлөгчдийн нэгдсэн сангийн мэдээллийг мэдээлэл шалгах эх үүсвэр болгон ашиглана. Мэдээллийг шалгахдаа борлуулалт, үйлдвэрлэлийн зардал, ашиг/алдагдлын хэмжээг томоохон нэгжүүдээр нь тулгаж үзнэ.

4.3. Нийт үйлдвэрлэлт. Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд нийт үйлдвэрлэлт нь зээлийн хүүгийн орлого, барьцаанд авсан эд зүйлсийг борлуулсны цэвэр орлого, банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого, торгууль, алдангийн орлого, бусад үйлчилгээний хураамжийн орлого, барилга байшин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого, үндсэн үйл ажиллагааны бус бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) нийлбэрээс бүрдэнэ.

Барьцаанд авсан эд зүйлсийг борлуулсны цэвэр орлогыг дараах байдлаар тооцно:

+ *Барьцаанд авсан эд зүйлсийг борлуулсны орлого*

- *Барьцаанд авсан эд зүйлсийг үнэлсэн үнэ*

Жич: Салбарын завсрын хэрэглээнд орох онцлог зардал нь торгуулийн зардал, автоматжуулалтын урсгал зардал зэрэг зардлууд байна. Барьцаанд авсан эд зүйлсийн үнэлсэн үнийг завсрын хэрэглээнд оруулахгүй.

5. Валют солих цэгүүдийн үйл ажиллагаа

5.1 Хамрах хүрээ. Энэ салбарт гадаад валют солих үйлчилгээ хийдэг нэгжүүдийн үйл ажиллагааг хамруулна.

5.2. Мэдээллийн эх үүсвэр. “Валют солих цэгүүдийн орлого, зарлагын улирлын мэдээ” ВС-1 маягт нь мэдээллийн гол эх үүсвэр болно. Түүнчлэн Үндэсний Татварын Ерөнхий Газрын татвар төлөгчдийн нэгдсэн сангийн мэдээллийг мэдээлэл шалгах эх үүсвэр болгон ашиглана. Мэдээллийг шалгахдаа борлуулалт, үйлдвэрлэлийн зардал, ашиг/алдагдлын хэмжээг томоохон нэгжүүдээр нь тулгаж үзнэ.

5.3. Нийт үйлдвэрлэлт. Валют солих үйлчилгээ эрхэлдэг нэгжүүдийн хувьд нийт үйлдвэрлэлтийг гадаад валютын арилжааны цэвэр орлого, санхүүгийн түрээсийн орлого, байр, тоног төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого, бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс орсон орлого орохгүй) нийлбэрээс бүрдэнэ.

Гадаад валютын арилжааны цэвэр орлогыг дараах байдлаар тооцно:

+ Гадаад валютын арилжааны орлого

- Гадаад валютын арилжааны зардал

Жич: Салбарын завсрын хэрэглээнд орох онцлог зардал нь автоматжуулалтын урсгал зардал байна.

6. Даатгалын үйл ажиллагаа

6.1 Хамрах хүрээ. Энэ салбарт даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийг хамруулна.

6.2. Мэдээллийн эх үүсвэр. “Даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны тайлан” Д-1 маягтаар Санхүүгийн зохицуулах хорооноос авдаг мэдээллийг ашиглана. Түүнчлэн Үндэсний Татварын Ерөнхий Газрын мэдээлэл болон аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайлан тэнцэл, орлогын тайланг, мэдээллийг шалгах эх үүсвэр болгон ашиглана. Мэдээллийг шалгахдаа борлуулалт, үйлдвэрлэлийн зардал, ашиг/алдагдлын хэмжээг томоохон нэгжүүдээр нь тулгаж үзнэ.

6.3. Нийт үйлдвэрлэлт. Даатгалын байгууллагын хувьд нийт үйлдвэрлэлтийг дараах байдлаар тооцно:

+ Тухайн жилийн даатгалын бодит орлого

+ Даатгалын нөөц хөрөнгийг ашигласнаас (бусад салбарт хөрөнгө оруулалт хийх гэх мэт) олсон орлого

- Даатгалын нөхөн төлбөр

- Амь даатгал болон тэтгэврийн даатгалын сангийн өөрчлөлт

+ Бусад орлого (байр түрээслүүлсний, зөвлөгөө өгсний гэх мэт. Харин үндсэн хөрөнгө борлуулсны орлого, ногдол ашгийн орлого орохгүй.)

7. Хөрөнгийн биржийн үйл ажиллагаа

7.1 Хамрах хүрээ: Энэ салбарт хөрөнгийн бирж, брокерийн пүүсүүдийн үйл ажиллагааг хамруулна.

7.2. Мэдээллийн эх үүсвэр: Хөрөнгийн биржийн мэдээллийг “Монголын хөрөнгийн бирж ХК-ны ... оны орлого зарлагын улирлын тайлан” ХБ-1 маягтаар Хөрөнгийн биржээс, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын мэдээллийг “Брокерийн пүүсүүдийн орлого зарлагын жилийн тайлан” БП-1 маягтаар Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хорооноос авч ашиглана.

7.3. Нийт үйлдвэрлэлт: Хөрөнгийн биржийн нийт орлого нь арилжааны гүйлгээний шимтгэл, арилжааны бус гүйлгээний шимтгэл, бондын шимтгэлийн орлого, гишүүний (суудлын эрхийн) хураамж, дансны хураамж, бүртгэл судалгааны хураамж болон бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) нийлбэрээс бүрдэнэ.

Брокерийн пүүсийн нийт үйлдвэрлэлт борлуулалтын орлого, хүү, торгууль, хөнгөлөлтийн орлого, үндсэн үйл ажиллагааны бус бусад орлогоос бүрдэнэ.

Жич: Салбарын завсрын хэрэглээнд орох онцлог зардал нь биржийн шимтгэл зэрэг зардлууд байна.

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ, ТҮРЭЭС, БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Олон улсын салбарын стандарт ангиллын дагуу энэ бүлэг дараахь 5 гол дэд бүлгээс бүрддэг. Үүнд:

70. Үл хөдлөх хөрөнгөтэй холбогдох үйл ажиллагаа. Үүнд орон сууцны болон сууцны бус барилга, газар түрээслэх, үнэлэх, борлуулах, худалдан авах, ашиглах, барилга барих

талбайг засаж бэлтгэх үйл ажиллагаа эрхлэх, мөн хувийн орон сууцтай хүн орон сууцандаа амьдарч байгаа нөхцөлд хийсвэр тооцогдсон түрээсийг хамруулна.

71. Машин тоног төхөөрөмж, гэр ахуйн хэрэгслийн түрээс. Энд бүх төрлийн тээврийн хэрэгсэл, ХАА-н техник, барилгын машин механизм, бусад төрлийн машин төхөөрөмж, гэр ахуйн бараа түрээслэх үйл ажиллагааг хамруулна.

72. Компьютерийн техник, түүнтэй холбоотой үйл ажиллагаа. Компьютер угсрах, засах, программ ашиглах талаар зөвлөгөө өгөх, мэдээллийг боловсруулах, мэдээллийн баазын үйл ажиллагаа зэргийг дагнан эрхэлдэг газрууд орно.

73. Эрдэм шинжилгээний ажил. Энд эрдэм шинжилгээний суурь болон хэрэглээний судалгаа шинжилгээ, туршилтын ажил эрхэлдэг байгууллагууд орно.

74. Бизнесийн бусад үйл ажиллагаа. Бизнесийн бусад үйл ажиллагаанд нотариатын байгууллагын үйлчилгээ, хуулийн зөвлөгөө болон нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцлээр хөндлөнгийн хяналт тавих (аудит) үйл ажиллагаа, татвар, зах зээл судлал, бизнесийн удирдлагаар зөвлөгөө өгөх үйл ажиллагааг бие даан явуулдаг газрууд орно.

1. Үл хөдлөх хөрөнгөтэй холбогдох үйл ажиллагаа

1.1 Орон сууцны үйлчилгээ

1.1.1 Хамрах хүрээ: Орон сууцны үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүд хамрагдана.

1.1.2 Мэдээллийн эх үүсвэр. Төрийн өмчийн байгууллагуудын мэдээллийн үндсэн эх үүсвэр нь улсын болон орон нутгийн төсвийн гүйцэтгэл, тухайн байгууллагууд дээр хөтлөгдөж байгаа нягтлан бодохын тайлан тэнцэл болон бусад тайлан мэдээ байна.

Хувийн хэвшлийн байгууллагуудын хувьд “Орон сууц, нийтийн аж ахуйн орлого, зарлагын ... оны ...-р улирлын мэдээ” МЗ-1 нь мэдээллийн эх үүсвэр болно. Түүнчлэн Үндэсний Татварын Ерөнхий Газрын татвар төлөгчдийн нэгдсэн сангийн мэдээллийг мэдээлэл шалгах эх үүсвэр болгон ашиглана. Мэдээллийг шалгахдаа борлуулалт, үйлдвэрлэлийн зардал, ашиг/алдагдлын хэмжээг томоохон нэгжүүдээр нь тулгаж үзнэ.

1.1.3 Нийт үйлдвэрлэлт. Төрийн өмчийн байгууллагуудын нийт үйлдвэрлэлтийг тооцохдоо тухайн байгууллагуудаас гаргасан урсгал зардлын хэмжээгээр тооцно. Энэ тооцоо нь “Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа”-ны салбарынхтай адил зарчмаар тооцогдоно.

Орон сууцны хувийн хэвшлийн конторуудын нийт үйлдвэрлэлт нь цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус түгээлтийн цэвэр орлого, засвар үйлчилгээний орлого, барилга, байшин түрээслүүлсний орлого, түүхий эд материалын өөрчлөлт, ажиллагчиддаа үнэ төлбөргүй өгсөн хоол, түлээ, нүүрсний зардал, дахин борлуулахаар худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл болон бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) нийлбэрээс бүрдэнэ. *Худалдааны нэмэгдлийг аж үйлдвэрийн салбарын тооцооны арга зүйд тусгасантай нэг адил арга зүйгээр тооцно.*

Цахилгаан, дулаан, усны түгээлтийн цэвэр орлогыг дараах байдлаар тооцно:

+ *Оршин суугчдаас төлсөн цахилгаан, дулаан, цэвэр бохир усны төлбөр*

- *Цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны зардал*

1.2 Сууц өмчлөгчдийн холбоо

1.2.1 Хамрах хүрээ: Сууц өмчлөгчдийн холбоодыг хамарна. Эдгээр нэгжүүдийн үйл ажиллагаа нь зарим талаар орон сууцны үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдтэй адил байдаг.

1.2.2 Мэдээллийн эх үүсвэр. Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааны талаарх тайлан мэдээ нь мэдээллийн эх үүсвэр болно.

1.2.3 Нийт үйлдвэрлэлт. Сууц өмчлөгчдийн холбооны нийт үйлдвэрлэлтийг тооцохдоо тухайн байгууллагуудаас гаргасан урсгал зардлын хэмжээгээр тооцно. Энэ тооцоо нь “Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа”-ны салбарынхтай адил зарчмаар тооцогдоно.

1.3 Үл хөдлөх хөрөнгийн төлбөрт үйлчилгээ

1.3.1 Хамрах хүрээ: Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах байр түрээслүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг нэгжүүд, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний газар хамрагдана.

1.3.2 Мэдээллийн эх үүсвэр. “Үл хөдлөх хөрөнгө, түрээсийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн орлого, зардлын жилийн тайлан” ҮХХ-1 нь мэдээллийн эх үүсвэр болно. Түүнчлэн Үндэсний Татварын Ерөнхий Газрын татвар төлөгчдийн нэгдсэн сангийн мэдээллийг мэдээлэл шалгах эх үүсвэр болгон ашиглана. Мэдээллийг шалгахдаа

борлуулалт, үйлдвэрлэлийн зардал, ашиг/алдагдлын хэмжээг томоохон нэгжүүдээр нь тулгаж үзнэ.

1.3.3 Нийт үйлдвэрлэлт. Нийт үйлдвэрлэлт нь үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах барилга, байшин түрээслүүлснээс орсон орлого, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас орсон орлого, үл хөдлөх хөрөнгийг баталгаажуулах, худалдах, эзэмших эрхийг шилжүүлэх үйлчилгээний хураамжаас орсон орлого, бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) нийлбэрээс бүрдэнэ.

1.4 Өөрийн эзэмшлийн орон сууцны түрээс

1.4.1 Хамрах хүрээ: Хувийн эзэмшлийн сууцны тусдаа байр, орон сууцны байр, гэрийн тоо, түүнд амьдарч буй өрхүүдийг хамарна.

1.4.2 Мэдээллийн эх үүсвэр. Өөрийн эзэмшлийн орон сууцны бодит болон хийсвэр түрээсийн тооцоонд мэдээллийн дараах эх үүсвэрүүдийг ашиглана.

- Нийт өрхийн болон сууцны тоо, сууцны төрлөөрх мэдээллийн эх үүсвэр:
 - а. Суурь он – Нийт өрхийн тоо, сууцны төрлөөр, *Хүн ам, орон сууц (ХАОС)-ны тооллого*
 - б. Нийт сууцны тоо, сууцны төрлөөр, Хүн ам, орон сууцны тооллого.
 - в. Нийт өрхийн тоо, жилийн эцсийн байдлаар, Суурин хүн амын жилийн судалгаа
 - г. Шинээр ашиглалтанд орсон орон сууцны тоо – *Шинээр ашиглалтанд орсон орон сууцны судалгаа*
- Түрээсийн зардал - *Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)*
- Орон сууцны байрны засвар үйлчилгээний зардал
 - *Хэрэглээний үнийн мэдээний орон сууцны 1 ам. метр талбайн сарын засвар үйлчилгээний үнийн мэдээлэл*

1.4.3 Нийт үйлдвэрлэлт. Өөрийн эзэмшлийн орон сууцны түрээсийн тооцоо нь ихээхэн онцлогтой байдаг тул нийт үйлдвэрлэлтийг дараах байдлаар тооцно.

I шат - Өөрийн эзэмшлийн сууцанд амьдардаг өрх, сууцны төрлөөр

1.1 Нийт өрхөөс өөрийн эзэмшлийн сууцны тусдаа байранд амьдардаг өрхийн тоо (ХАОС-ны тооллогын дүнгээр)

+ Шинээр ашиглалтанд орсон тусдаа сууцны тоо

= *Өөрийн эзэмшлийн сууцны тусдаа байранд амьдардаг өрхийн тоо*

1.2 Нийт өрхөөс өөрийн эзэмшлийн орон сууцны байшинд амьдардаг өрхийн тоо, өрөөний тоогоор (ХАОС-ны тооллогын дүнгээр)

+ Шинээр ашиглалтанд орсон орон сууцны байшингийн тоо, өрөөний тоогоор

= *Өөрийн эзэмшлийн орон сууцны байранд амьдардаг өрхийн тоо, өрөөний тоогоор*

1.3 Тайлант оны нийт өрхийн тоо

- Өөрийн эзэмшлийн сууцны тусдаа байранд амьдардаг өрхийн тоо

- Өөрийн эзэмшлийн орон сууцны байранд амьдардаг өрхийн тоо

= *Гэр болон бусад төрлийн сууцанд амьдардаг өрхийн тоо*

1.4 Гэрт амьдардаг өрхийн тоо (ХАОС-ны тооллогын дүнгээр)

: Гэр болон бусад төрлийн сууцанд амьдардаг өрхийн тоо (ХАОС-ны тооллогын дүнгээр)

= *Гэр болон бусад төрлийн сууцанд амьдардаг өрхийн тоонд гэрт амьдардаг өрхийн эзлэх хувийн жин (ХАОС-ны тооллогын дүнгээр)*

1.5 Гэр болон бусад төрлийн сууцанд амьдардаг өрхийн тоо

* Гэр болон бусад төрлийн сууцанд амьдардаг өрхийн тоонд гэрт амьдардаг өрхийн эзлэх хувийн жин (ХАОС-ны дүнгээр)

= *Гэрт амьдардаг өрхийн тоо*

Эхлээд тусдаа сууцны тусдаа байр болон орон сууцны байранд амьдардаг нийт өрхийн тоог ХАОС-ны тооллого явагдсан оноор тооцож гаргана.

Дараа нь нийт өрхийн тооноос сууцны тусдаа байр, орон сууцны байшинд амьдардаг өрхийн тоог хасч, гэр болон бусад төрлийн сууцанд амьдардаг өрхийн тоог гаргана. Үүний дараа мөн тооллогын үр дүнд суурилан гэр болон бусад төрлийн сууцанд (нийтийн байр, улсын эзэмшлийн сууц г.м) амьдардаг нийт өрхийн тоонд гэрт амьдардаг өрхийн тооны эзлэх хувийн жинг тооцож гаргана. *Энэхүү хувийн жинг гэрт амьдардаг өрхийн тоог цаашид жил жилээр тооцоход ашиглана.*

ХАОС-ны тооллого явагдсан оны жилийн эцэст байгаа тусдаа байр, орон сууцанд амьдардаг нийт өрхийн тоон дээр дараагийн тайлант оны шинээр тусдаа байр, орон сууцны байшинд орсон өрхийн тоог нэмж тухайн тайлант оны жилийн эцсийн байдлаарх тусдаа байр, орон сууцны байшинд амьдардаг нийт өрхийн тоог тооцож гаргана.

Үүний дараа тайлант оны жилийн эцсээрх нийт өрхийн тооноос тусдаа байр, орон сууцанд амьдардаг нийт өрхийн тоог хасч, гэр болон бусад төрлийн сууцанд (нийтийн байр, улсын эзэмшлийн сууц г.м) амьдардаг нийт өрхийн тоог гаргана. Дараа нь ХАОС-ны тооллогын дүнгээр гаргаж авсан дээр дурьдсан гэрт амьдардаг өрхийн тооны эзлэх хувийн жинг ашиглан тайлант оны байдлаарх гэрт амьдардаг өрхийн тоог тооцож гаргана. Энэ маягаар он тус бүрийн хувьд тусдаа байр, орон сууц, гэрт амьдардаг нийт өрхийн тоог сууцны төрлөөр тооцож гаргана.

II шат - ӨНЭЗС-нд хамрагдсан түрээслэгч өрхийн тоо, нийт өрхөд эзлэх хувийн жин

ӨНЭЗС-д хамрагдсан түрээслэгч өрхийн тоо (сууцны төрлөөр)
: ӨНЭЗС-д хамрагдсан нийт өрхийн тоо (сууцны төрлөөр)
= ӨНЭЗС-д хамрагдсан нийт өрхөд түрээслэгч өрхийн эзлэх хувийн жин (сууцны төрлөөр)

III шат - Түрээслэгч өрхийн тоо, нийт өрхөд тархаасан байдлаар

Өөрийн эзэмшлийн сууцанд амьдардаг өрхийн тоо (сууцны төрлөөр)
* ӨНЭЗС-д хамрагдсан нийт өрхөд түрээслэгч өрхийн эзлэх хувийн жин (сууцны төрлөөр)
= Өөрийн эзэмшлийн сууцанд амьдардаг нийт өрхөөс сууцаа түрээсэлдэг өрхийн тоо (сууцны төрлөөр)

IV шат - Өөрөө орон сууцаа эзэмшигч өрхийн тоо

Өөрийн эзэмшлийн сууцанд амьдардаг өрхийн тоо (сууцны төрлөөр)
- Өөрийн эзэмшлийн сууцаа түрээсэлдэг өрхийн тоо (сууцны төрлөөр)
= Өөрөө сууцаа эзэмшдэг өрхийн тоо (сууцны төрлөөр)

V шат – Сарын түрээсийн бодит төлбөр

Сарын түрээсийн нийт бодит төлбөр (сууцны төрлөөр, ӨНЭЗС)
: Өөрийн эзэмшлийн сууцаа түрээсэлдэг өрхийн тоо (сууцны төрлөөр, ӨНЭЗС)
= 1 өрхийн сарын түрээсийн бодит төлбөр (сууцны төрлөөр, ӨНЭЗС)

VI шат - Түрээслэгч өрхийн жилийн түрээсийн хэмжээ буюу бодит түрээс

1 өрхийн сарын түрээсийн бодит төлбөр (сууцны төрлөөр)
* Нийт тархаасан түрээслэгч өрхийн тоо (сууцны төрлөөр)
* 12 сар
= Нийт тархаасан түрээслэгч өрхийн жилийн түрээсийн хэмжээ (сууцны төрлөөр)

Нийт тархаасан түрээслэгч өрхийн жилийн түрээсийн хэмжээний нийлбэр нь ӨНЭЗС-д үндэслэн ДНБ-ий эцсийн ашиглалтын тооцооны Өрхийн хэрэглээнд тусгагдсан Нийт бодит түрээсийн төлбөр буюу Нийт үйлдвэрлэлт болно.

VII шат - Өөрөө сууцаа эзэмшигч өрхийн жилийн түрээсийн төлбөр

1 өрхийн сарын түрээсийн бодит төлбөр (сууцны төрлөөр)
* Өөрөө сууцаа эзэмшигч өрхийн тоо (сууцны төрлөөр)
* 12 сар
= Өөрөө сууцаа эзэмшигч өрхийн жилийн түрээсийн хэмжээ (сууцны төрлөөр)

Өөрийн эзэмшлийн орон сууцны түрээсийн нийт үйлдвэрлэлт нь бодит болон хийсвэр түрээсийн нийлбэр буюу түрээслэгч болон өөрөө сууцаа эзэмшигч өрхүүдийн жилийн түрээсийн хэмжээ байна.

1.4.4 Завсрын хэрэглээ. Завсрын хэрэглээнд орон сууцны байшинд амьдардаг өрхийн нийтийн эзэмшлийн талбайн төлбөр, сууцны тусдаа байр, орон сууцны байшин, гэрт амьдардаг өрхийн засвар үйлчилгээний зардлыг тооцож оруулна.

VIII шат - Орон сууцны байшинд оршин суудаг өрхийн нийтийн эзэмшлийн талбайн засвар үйлчилгээний сарын жигнэгдсэн дундаж төлбөр

Орон сууцны байранд амьдардаг өрхийн нийтийн эзэмшлийн талбайн засвар үйлчилгээний хөлсийг хэрэглээний үнийн мэдээний орон сууцны 1 ам. метр талбайн сарын засвар үйлчилгээний үнийн мэдээллээр авна. Байрны талбайн хэмжээг 1 өрөө байрны хувьд дунджаар 18 ам. метр, 2 өрөө байрны хувьд дунджаар 30 ам. метр, 3 ба дээш өрөө байрны хувьд дунджаар 50 ам. метр гэж тооцон авна. Үүний дараа өрөөний тоогоор тооцсон талбайн хэмжээг орон сууцны 1 ам. метр талбайн сарын засвар үйлчилгээний үнээр үржүүлж сарын төлбөрийг тооцно. Үүнд:

- (1 өрөө байрны засвар үйлчилгээний хөлс * нийтийн орон сууцны байшингийн доторхи 1 өрөө сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувь)
 - + (2 өрөө байрны засвар үйлчилгээний хөлс * нийтийн орон сууцны байшингийн доторхи 2 өрөө сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувь)
 - + (3 ба дээш өрөө байрны засвар үйлчилгээний хөлс * нийтийн орон сууцны байшингийн доторхи 3 ба түүнээс дээш өрөө сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувь)
- = Нийтийн орон сууцны байшингийн доторхи сууцанд амьдардаг 1 өрхийн нийтийн эзэмшлийн талбайн засвар үйлчилгээний сарын дундаж хөлс

IX шат - Орон сууцны байшинд оршин суудаг өрхийн нийтийн эзэмшлийн талбайн жилийн төлбөр

- Нийтийн орон сууцны байшингийн доторхи сууцанд амьдардаг 1 өрхийн нийтийн эзэмшлийн талбайн засвар үйлчилгээний сарын дундаж хөлс
- * Орон сууцны байшинд амьдардаг өрхийн тоо, эзэмшлийн хэлбэрээр (түрээслэгч ба өөрөө эзэмшигч)
 - * 12 сар
- = Орон сууцны байшинд амьдардаг өрхийн Нийтийн эзэмшлийн талбайн жилийн төлбөр, эзэмшлийн хэлбэрээр

X шат - Гэрт оршин суудаг өрхийн засвар үйлчилгээний нийт зардал

- 1 өрхийн засвар үйлчилгээний жилийн зардал (гэрийн бүрээс солих зардал)
- * Гэрт амьдардаг өрхийн тоо, эзэмшлийн хэлбэрээр (түрээслэгч ба өөрөө эзэмшигч)
 - * 12 сар
- = Гэрт амьдардаг өрхийн засвар үйлчилгээний жилийн зардал

XI шат - Сууцны тусдаа байр, орон сууцны байшингийн засвар үйлчилгээний зардал

- Сууцны тусдаа 1 өрхийн засвар үйлчилгээний жилийн зардал (гэрийн бүрээс солих зардал)
- * Гэрт амьдардаг өрхийн тоо, эзэмшлийн хэлбэрээр (түрээслэгч ба өөрөө эзэмшигч)
 - * 12 сар
- = Гэрт амьдардаг өрхийн засвар үйлчилгээний жилийн зардал

Сууцны тусдаа байр, орон сууцны байшингийн засвар үйлчилгээний зардлыг нийт түрээсийн төлбөр буюу нийт үйлдвэрлэлтийн 5 хувьтай тэнцэх зардал гардаг гэж үзэж тооцно. Энэхүү зардлыг бодит болон хийсвэр түрээсийн гэж тус бүрд нь тооцож гаргана

1.4.5 Нэмэгдэл өртөг. Нийт үйлдвэрлэлтээс завсрын хэрэглээг хасч нэмэгдэл өртгийг тооцно.

XII шат - ДНБ-ий үйлдвэрлэлийн аргын тооцоонд тусгах хийсвэр түрээсийн тооцооны нэмэгдэл өртөг

- Өөрөө орон сууцаа эзэмшигч өрхийн жилийн нийт түрээсийн төлбөр
- Орон сууцны байшинд амьдардаг өөрөө сууцаа эзэмшигч өрхийн нийтийн эзэмшлийн талбайн жилийн төлбөр
- Өөрөө сууцаа эзэмшигч өрхийн сууцны тусдаа байр, орон сууцны байшингийн засвар үйлчилгээний зардал (Нийт түрээсийн төлбөрийн 5 хувьтай тэнцэх зардал гардаг гэж үзэж тооцно.)
- Гэрт оршин суудаг өөрөө эзэмшигч өрхийн засвар үйлчилгээний нийт зардал
- = *Хийсвэр түрээсийн тооцооны нэмэгдэл өртөг буюу холимог орлого*

XIII шат - ДНБ-ий үйлдвэрлэлийн аргын тооцоонд тусгах бодит түрээсийн тооцооны нэмэгдэл өртөг

- ӨНЭЗС-д үндэслэн ДНБ-ий эцсийн ашиглалтын тооцооны Өрхийн хэрэглээнд тусгагдсан Нийт түрээсийн төлбөр буюу Нийт үйлдвэрлэлт
- Орон сууцны байшинд амьдардаг түрээслэгч өрхийн Нийтийн эзэмшлийн талбайн жилийн төлбөр
- Түрээслэгч өрхийн сууцны тусдаа байр, орон сууцны байшингийн засвар үйлчилгээний зардал (Нийт түрээсийн төлбөрийн 5 хувьтай тэнцэх зардал гардаг гэж үзэж тооцно.)
- Түрээсэлсэн гэрт оршин суудаг өрхийн засвар үйлчилгээний нийт зардал
- = *Бодит түрээсийн тооцооны нэмэгдэл өртөг буюу холимог орлого*

ДНБ-ий үйлдвэрлэлийн аргын тооцоонд бодит болон хийсвэр түрээсийн тооцооны нэмэгдэл өртгийг хоёуланг нь нэгтгэж тусгана.

2. Машин, тоног төхөөрөмжийн түрээсийн үйл ажиллагаа

2.1 Хамрах хүрээ: Машин, тоног төхөөрөмж түрээслүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг нэгжүүд хамрагдана.

2.2 Мэдээллийн эх үүсвэр. “Үл хөдлөх хөрөнгө, түрээсийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн орлого, зардлын жилийн тайлан” ҮХХ-1 нь мэдээллийн эх үүсвэр болно. Түүнчлэн Үндэсний Татварын Ерөнхий Газрын мэдээлэл болон аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайлан тэнцэл, орлогын тайланг, мэдээллийг шалгах эх үүсвэр болгон ашиглана. Мэдээллийг шалгахдаа борлуулалт, үйлдвэрлэлийн зардал, ашиг/алдагдлын хэмжээг томоохон нэгжүүдээр нь тулгаж үзнэ.

2.3 Нийт үйлдвэрлэлт. Нийт үйлдвэрлэлт нь машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого, хэрвээ дахин борлуулахаар худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулсан бол түүнээс орсон орлого буюу худалдааны нэмэгдэл болон бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс орсон орлого орохгүй) нийлбэрээс бүрдэнэ. *Худалдааны нэмэгдлийг аж үйлдвэрийн салбарын тооцооны арга зүйд тусгасантай нэг адил арга зүйгээр тооцно.*

3. Компьютер түүнтэй холбогдох үйл ажиллагаа

3.1 Хамрах хүрээ: Компьютерийн засвар үйлчилгээ, интернет кафе эрхэлдэг нэгжүүд хамрагдана.

3.2 Мэдээллийн эх үүсвэр. “Үл хөдлөх хөрөнгө, түрээсийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн орлого, зардлын жилийн тайлан” ҮХХ-1 нь мэдээллийн эх үүсвэр болно. Түүнчлэн Үндэсний Татварын Ерөнхий Газрын татвар төлөгчдийн нэгдсэн сангийн мэдээллийг мэдээлэл шалгах эх үүсвэр болгон ашиглана. Мэдээллийг шалгахдаа борлуулалт, үйлдвэрлэлийн зардал, ашиг/алдагдлын хэмжээг томоохон нэгжүүдээр нь тулгаж үзнэ.

3.3 Нийт үйлдвэрлэлт. Нийт үйлдвэрлэлт нь компьютерийн засвар үйлчилгээнээс орсон орлого, интернет кафе ажиллуулснаас орсон орлого, байр түрээслүүлснээс орсон орлого, хэрвээ дахин борлуулахаар худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулсан бол түүнээс орсон орлого буюу худалдааны нэмэгдэл болон бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс орсон орлого орохгүй) нийлбэрээс бүрдэнэ. *Худалдааны нэмэгдлийг аж үйлдвэрийн салбарын тооцооны арга зүйд тусгасантай нэг адил арга зүйгээр тооцно.*

4. Эрдэм шинжилгээний ажил

4.1 Хамрах хүрээ: Эрдэм шинжилгээний үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчийн болон хувийн хэвшлийн нэгжүүд хамрагдана.

4.2 Мэдээллийн эх үүсвэр. Төрийн өмчийн байгууллагуудын мэдээллийн үндсэн эх үүсвэр нь улсын болон орон нутгийн төсвийн гүйцэтгэл, тухайн байгууллагууд дээр хөтлөгдөж байгаа нягтлан бодохын тайлан тэнцэл болон бусад тайлан мэдээ байна.

Хувийн хэвшлийн байгууллагуудын хувьд “Эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг хувийн хэвшлийн байгууллагуудын орлого, зардлагын 20... оны ...-р улирлын тайлан” ЭШС-1 нь эрдэм шинжилгээний үйл ажиллагаа эрхэлдэг хувийн байгууллагуудын мэдээллийн эх үүсвэр болно. Түүнчлэн Үндэсний Татварын Ерөнхий Газрын татвар төлөгчдийн нэгдсэн сангийн мэдээллийг мэдээлэл шалгах эх үүсвэр болгон ашиглана. Мэдээллийг шалгахдаа борлуулалт, үйлдвэрлэлийн зардал, ашиг/алдагдлын хэмжээг томоохон нэгжүүдээр нь тулгаж үзнэ.

4.3 Нийт үйлдвэрлэлт. Төрийн өмчийн байгууллагуудын нийт үйлдвэрлэлтийг тооцохдоо тухайн байгууллагуудаас гаргасан урсгал зардлын хэмжээгээр тооцно. Энэ тооцоо нь “Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа”-ны салбарынхтай адил зарчмаар тооцогдоно.

Хувийн хэвшлийн байгууллагуудын нийт үйлдвэрлэлт нь эрдэм шинжилгээний үйл ажиллагаанаас (бүтээгдэхүүнээ борлуулсны) орсон орлого, хөтөлбөр, төсөл, гадаадын сан байгууллагаас орсон орлого, барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого, хэрвээ дахин борлуулахаар худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулсан бол түүнээс орсон орлого буюу худалдааны нэмэгдэл болон үйл ажиллагааны бус бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс орсон орлого орохгүй) нийлбэрээс бүрдэнэ. *Худалдааны нэмэгдлийг аж үйлдвэрийн салбарын тооцооны арга зүйд тусгасантай нэг адил арга зүйгээр тооцно.*

5. Бизнесийн бусад үйлчилгээ

5.1 Зураг төсөл

5.1.1 Хамрах хүрээ: Барилгын зураг төслийг зохиох үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчийн болон хувийн хэвшлийн нэгжүүд хамрагдана.

5.1.2 Мэдээллийн эх үүсвэр. Төрийн өмчийн байгууллагуудын мэдээллийн үндсэн эх үүсвэр нь улсын болон орон нутгийн төсвийн гүйцэтгэл, тухайн байгууллагууд дээр хөтлөгдөж байгаа нягтлан бодохын тайлан тэнцэл болон бусад тайлан мэдээ байна.

Хувийн хэвшлийн байгууллагуудын хувьд “Бизнесийн бусад үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн орлого, зардлын улирал, жилийн тайлан” ҮХХ-2 нь мэдээллийн эх үүсвэр болно. Түүнчлэн Үндэсний Татварын Ерөнхий Газрын татвар төлөгчдийн нэгдсэн сангийн мэдээллийг мэдээлэл шалгах эх үүсвэр болгон ашиглана. Мэдээллийг шалгахдаа борлуулалт, үйлдвэрлэлийн зардал, ашиг/алдагдлын хэмжээг томоохон нэгжүүдээр нь тулгаж үзнэ.

5.1.3 Нийт үйлдвэрлэлт. Төрийн өмчийн байгууллагуудын нийт үйлдвэрлэлтийг тооцохдоо тухайн байгууллагуудаас гаргасан урсгал зардлын хэмжээгээр тооцно. Энэ тооцоо нь “Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа”-ны салбарынхтай адил зарчмаар тооцогдоно.

Хувийн хэвшлийн байгууллагуудын нийт үйлдвэрлэлт нь зураг төсөл боловсруулснаас орсон орлого, хөтөлбөр, төсөл, гадаадын сан байгууллагаас орсон орлого, барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого, зөвлөгөө өгсний орлого, хэрвээ дахин борлуулахаар худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулсан бол түүнээс орсон орлого буюу худалдааны нэмэгдэл болон үйл ажиллагааны бус бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашгийн орлого, даатгалын байгууллагаас авсан нөхөн төлбөр орохгүй) нийлбэрээс бүрдэнэ. *Худалдааны нэмэгдлийг аж үйлдвэрийн салбарын тооцооны арга зүйд тусгасантай нэг адил арга зүйгээр тооцно.*

5.2 Геологи хайгуул

5.2.1 Хамрах хүрээ: Геологи хайгуулын ажил эрхэлдэг төрийн өмчийн болон хувийн хэвшлийн нэгжүүд хамрагдана.

5.2.2 Мэдээллийн эх үүсвэр. Төрийн өмчийн байгууллагуудын мэдээллийн үндсэн эх үүсвэр нь улсын болон орон нутгийн төсвийн гүйцэтгэл, тухайн байгууллагууд дээр хөтлөгдөж байгаа нягтлан бодохын тайлан тэнцэл болон бусад тайлан мэдээ байна.

Хувийн хэвшлийн байгууллагуудын хувьд “Бизнесийн бусад үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн орлого, зардлын улирал, жилийн тайлан” ҮХХ-2 нь мэдээллийн эх үүсвэр болно. Түүнчлэн Үндэсний Татварын Ерөнхий Газрын татвар төлөгчдийн нэгдсэн сангийн мэдээллийг мэдээлэл шалгах эх үүсвэр болгон ашиглана. Мэдээллийг шалгахдаа борлуулалт, үйлдвэрлэлийн зардал, ашиг/алдагдлын хэмжээг томоохон нэгжүүдээр нь тулгаж үзнэ.

5.2.3 Нийт үйлдвэрлэлт. Төрийн өмчийн байгууллагуудын нийт үйлдвэрлэлтийг тооцохдоо тухайн байгууллагуудаас гаргасан урсгал зардлын хэмжээгээр тооцно. Энэ тооцоо нь “Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа”-ны салбарынхтай адил зарчмаар тооцогдоно.

Хувийн хэвшлийн байгууллагуудын нийт үйлдвэрлэлтийг үйл ажиллагааны орлого, барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого, зөвлөгөө өгсний орлого, хэрвээ дахин борлуулахаар худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулсан бол түүнээс орсон орлого буюу худалдааны нэмэгдэл болон үйл ажиллагааны бус бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) нийлбэрээс бүрдэнэ. *Худалдааны нэмэгдлийг аж үйлдвэрийн салбарын тооцооны арга зүйд тусгасантай нэг адил арга зүйгээр тооцно.*

Жич: Салбарын завсрын хэрэглээнд хайгуулын ажлын зардал орохгүй. Энэ зардал нь үндсэн хөрөнгийн хуримтлалын зардал буюу ДНБ-ий эцсийн ашиглалтын тооцооны бүрэлдэхүүн хэсэг юм.

5.3 Техникийн туршилт, шинжилгээ

5.3.1 Хамрах хүрээ: Үйлдвэрлэж буй болон импортоор оруулж ирж буй бараа, бүтээгдэхүүний чанарт хяналт тавих, сорьц хийх үйл ажиллагааг эрхэлдэг төрийн өмчийн болон хувийн хэвшлийн нэгжүүд хамрагдана.

5.3.2 Мэдээллийн эх үүсвэр. Төрийн өмчийн байгууллагуудын мэдээллийн үндсэн эх үүсвэр нь улсын болон орон нутгийн төсвийн гүйцэтгэл, тухайн байгууллагууд дээр хөтлөгдөж байгаа нягтлан бодохын тайлан тэнцэл болон бусад тайлан мэдээ байна.

Хувийн хэвшлийн байгууллагуудын хувьд “Бизнесийн бусад үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн орлого, зардлын улирал, жилийн тайлан” ҮХХ-2 нь мэдээллийн эх үүсвэр болно. Түүнчлэн Үндэсний Татварын Ерөнхий Газрын татвар төлөгчдийн нэгдсэн сангийн мэдээллийг мэдээлэл шалгах эх үүсвэр болгон ашиглана. Мэдээллийг шалгахдаа борлуулалт, үйлдвэрлэлийн зардал, ашиг/алдагдлын хэмжээг томоохон нэгжүүдээр нь тулгаж үзнэ.

5.3.3 Нийт үйлдвэрлэлт. Төрийн өмчийн байгууллагуудын нийт үйлдвэрлэлтийг тооцохдоо тухайн байгууллагуудаас гаргасан урсгал зардлын хэмжээгээр тооцно. Энэ тооцоо нь “Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа”-ны салбарынхтай адил зарчмаар тооцогдоно.

Хувийн хэвшлийн байгууллагуудын нийт үйлдвэрлэлт нь бараа, бүтээгдэхүүний чанарын хяналтын үйл ажиллагаанаас орсон орлого, бүтээгдэхүүнд сорьц хийснээс олсон орлого, барилга, байшин түрээслүүлсний орлого, бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) нийлбэрээс бүрдэнэ.

5.4 Бизнесийн бусад үйл ажиллагаа

5.4.1 Хамрах хүрээ: Хууль зүй, нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, татвар, бизнесийн болон удирдлагын талаар зөвлөгөө өгөх, зах зээл судлал, олон нийтийн үзэл бодлын талаар судалгаа хийх, зар сурталчилгаа, хөдөлмөр эрхлэхэд зуучлах, сонгон шалгаруулалт хийх, харуул хамгаалалт, барилга байгууламж, үйлдвэрийн цэвэрлэгээ, савлах, боох үйлчилгээ, орчуулга хийх, дизайнерын үйл ажиллагаа эрхэлдэг нэгжүүд хамрагдана.

5.4.2 Мэдээллийн эх үүсвэр. “Бизнесийн бусад үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн орлого, зардлын улирал, жилийн тайлан” ҮХХ-2 нь мэдээллийн эх үүсвэр болно. Түүнчлэн Үндэсний Татварын Ерөнхий Газрын татвар төлөгчдийн нэгдсэн сангийн мэдээллийг мэдээлэл шалгах эх үүсвэр болгон ашиглана. Мэдээллийг шалгахдаа борлуулалт, үйлдвэрлэлийн зардал, ашиг/алдагдлын хэмжээг томоохон нэгжүүдээр нь тулгаж үзнэ.

5.4.3 Нийт үйлдвэрлэлт. Нийт үйлдвэрлэлт нь тухайн нэгжүүдийн өөрийн үндсэн үйл ажиллагаанаас орсон орлого, байшин, тоног төхөөрөмж түрээслүүлсний орлого, дахин

борлуулахаар худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулсан бол түүнээс орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, бусад орлого, хэрвээ үйлдвэрлэл явуулсан бол бэлэн бараа, бүтээгдэхүүний үлдэгдлийн өөрчлөлт, түүхий эд материалын үлдэгдлийн өөрчлөлт болон бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) нийлбэрээс бүрдэнэ.

ТӨРИЙН УДИРДЛАГА, БАТЛАН ХАМГААЛАХ, АЛБАН ЖУРМЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.Хамрах хүрээ. Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа: Нийслэл хот, аймаг, дүүрэг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг даргын тамгын газар, хууль хяналт, нийгмийн хэв журам сахиулах байгууллагууд, цэрэг иргэний хамгаалалтын газар, татварын алба, нийгмийн даатгал зэрэг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагууд хамрагдана.

2. Мэдээллийн эх үүсвэр. Төсөвт байгууллагуудын бүтээгдэхүүнийг тооцох мэдээллийн үндсэн эх үүсвэр нь улсын болон орон нутгийн төсвийн гүйцэтгэл, тухайн байгууллагууд дээр хөтлөгдөж байгаа нягтлан бодохын тайлан тэнцэл болон бусад тайлан мэдээ байна.

3. Нийт үйлдвэрлэлтийн хэмжээ. Төсөвт байгууллагуудын нийт үйлдвэрлэлтийг тооцохдоо тухайн байгууллагуудаас гаргасан урсгал зардлын хэмжээгээр тооцно. Үүнд цалин (ажиллагчдаас төлсөн нийгмийн даатгалын шимтгэл, нэмэгдэл цалин, шагнал урамшуулал, хоол, унааны зардал орно), ажил олгогчоос нийгмийн даатгалд төлсөн шимтгэлүүд (тэтгэврийн даатгал, эрүүл мэндийн даатгал, ажилгүйдлийн даатгал, тэтгэмжийн даатгал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал, бусад), оюутны тэтгэлэг болон гадаадад суралцагчдын зардал, бараа үйлчилгээний материалын зардал, материаллаг бус үйлчилгээний зардал, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээний зардал, цаг уурын судалгааны авто болон өөрөө явагч хэрэгслийн татвар, үндсэн үйл ажиллагааны төлбөрт үйлчилгээний орлого, туслах аж ахуйн орлого зэрэг орно. Мөн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцож нийт үйлдвэрлэлтэд оруулна.

Төрийн байгууллагуудын нийт үйлдвэрлэлтэд хөрөнгө оруулалтын зардлыг оруулахгүй. Хөрөнгө оруулалтын шинжтэй зардалд нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, өмч хувьчлалын болон замын сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, үндсэн хөрөнгө худалдан авах зардлаас бүрдэнэ. Мөн энд улсын нөөц бүрдүүлэлт, геологи хайгуулын зардал, хөрөнгийн гадаад, дотоод шилжүүлгийг оруулахгүй.

Жич: Салбарын завсрын хэрэглээнд цалин, нийгмийн даатгалын шимтгэл, үндсэн хөрөнгийн элэгдлээс бусад бүх урсгал зардлууд орно.

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.Хамрах хүрээ. Суурь, бүрэн дунд, техник, тусгай мэргэжлийн болон дээд боловсрол олгох, мөн насанд хүрэгчдийн болон бусад боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчийн болон хувийн хэвшлийн нэгжүүд хамрагдана.

2. Мэдээллийн эх үүсвэр. Төрийн болон хувийн хэвшлийн сургуулиудын зардлын тайланг ЕБС-14 маягт, ДБ-10 маягтаар Боловсрол, соёл шинжлэх ухааны яамнаас авч тооцно.

Насанд хүрэгчдийн болон бусад боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг нэгжүүдийн хувьд “Мэргэжлийн болон бусад түр сургалт эрхэлдэг нэгжийн 20... оны ...-р улирлын тайлан” маягт нь мэдээллийн эх үүсвэр болно.

3. Нийт үйлдвэрлэлтийн хэмжээ. Төрийн өмчийн боловсролын байгууллагуудын нийт үйлдвэрлэлтийг тооцохдоо тухайн байгууллагуудаас гаргасан урсгал зардлын хэмжээгээр тооцно. Энэ тооцоо нь “Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа”-ны салбарынхтай адил зарчмаар тооцогдох ч ерөнхий боловсролын сургуулиудын хоолны зардлыг нийт үйлдвэрлэлтэд оруулж тооцно.

Хувийн өмчийн сургуулиуд, насанд хүрэгчдийн болон бусад боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг нэгжүүдийн хувьд нийт үйлдвэрлэлт нь сургалтын төлбөрөөс орсон орлого, хандив, тусламжийн орлого, байр, тоног төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого, дахин борлуулахаар худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулсан бол түүнээс орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийн өөрчлөлт, бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) нийлбэрээс бүрдэнэ.

Худалдааны нэмэгдлийг аж үйлдвэрийн салбарын тооцоонд тусгасантай адил зарчмаар тооцно.

Жич:Салбарын завсрын хэрэглээнд орох онцлог зардал нь ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын өдрийн хоол, дотуур байрны хүүхдүүдийн хоолны зардал байна.

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.Хамрах хүрээ. Хүн эмнэлэг, мал эмнэлэг, нийгмийн халамжийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчийн болон хувийн хэвшлийн нэгжүүд хамрагдана.

2. Мэдээллийн эх үүсвэр. Төрийн өмчийн хүн эмнэлгийн байгууллага, ерхийн эмнэлэг, нийгмийн халамжийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын мэдээллийн үндсэн эх үүсвэр нь улсын болон орон нутгийн төсвийн гүйцэтгэл байна.

Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагуудын хувьд “Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагуудын орлого, зарлагын 20 .. оны улирал, жилийн тайлан” ЭМТ-6 маягт нь мэдээллийн эх үүсвэр болно.

Мал эмнэлгийн нэгжүүдийн хувьд “Мал эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн 200... оны ...-р улирлын тайлан” МЭ-1 маягт нь мэдээллийн эх үүсвэр болно.

Нийгмийн халамжийн үйл ажиллагааг төрийн байгууллагууд эрхэлдэг бөгөөд мэдээллийн эх үүсвэр нь улсын болон орон нутгийн төсвийн гүйцэтгэл байна.

3. Нийт үйлдвэрлэлтийн хэмжээ. Төрийн өмчийн байгууллагуудын нийт үйлдвэрлэлтийг тооцохдоо тухайн байгууллагуудаас гаргасан урсгал зардлын хэмжээгээр тооцно. Энэ тооцоо нь “Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа”-ны салбарынхтай адил зарчмаар тооцогдох ч эм, тарианы болон хоолны зардлыг нийт үйлдвэрлэлтэд оруулж тооцно.

Ерхийн эмнэлгийн нийт үйлдвэрлэлтийг тооцохдоо гаргасан урсгал зардлын хэмжээгээр тооцно. Энэ тооцоо нь “Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа”-ны салбарынхтай адил зарчмаар тооцогдох ч эм, тарианы зардлыг нийт үйлдвэрлэлтэд оруулж тооцно.

Хувийн хэвшлийн хүн эмнэлгийн байгууллагуудын хувьд нийт үйлдвэрлэлт нь амбулатори, лаборатори, оношилгоо, үзлэг, хэвтэж эмчлүүлснээс орсон орлогууд, байр, тоног төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого, дахин борлуулахаар худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг (эм тариа, эмнэлгийн материал, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж) борлуулсан бол түүнээс орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийн өөрчлөлт, бусад орлого (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) зэргээс бүрдэнэ. *Худалдааны нэмэгдлийг аж үйлдвэрийн салбарын тооцоонд тусгасантай адил зарчмаар тооцно.*

Мал эмнэлгийн байгууллагуудын хувьд нийт үйлдвэрлэлт нь мал эмчилгээ, вакцинжуулалт, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, малын хээлтүүлэг зэрэг үйлчилгээнээс орсон орлогууд, байр, тоног төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого, дахин борлуулахаар худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг (эм тариа, эмнэлгийн материал, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж) борлуулсан бол түүнээс орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийн өөрчлөлт бусад орлого (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) зэргээс бүрдэнэ. *Худалдааны нэмэгдлийг аж үйлдвэрийн салбарын тооцоонд тусгасантай адил зарчмаар тооцно.*

Жич:Салбарын завсрын хэрэглээнд орох онцлог зардал нь эм тариа, эмчилгээний материалын зардал, хоолны зардал байна.

НИЙГЭМ, БИЕ ХҮНД ҮЗҮҮЛЭХ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

1. Хамрах хүрээ. Бохир ус, хаягдал цэвэрлэгээ, ариутгалын үйлчилгээ, бизнес эрхлэгчид болон мэргэжлийн чиглэлийн холбоо, эвсэл, шашны байгууллага, улс төрийн байгууллагууд болон бусад төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, кино, радио телевиз, чөлөөт цагт зориулагдсан бусад ажиллагаа, номын сан, архив, музей, түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах үйл ажиллагаа, дархан цаазат газар, биеийн тамир, чөлөөт цагт зориулагдсан бусад үйл ажиллагаа, угаалга, хими цэвэрлэгээний үйлчилгээ, үсчин, гоо сайхан, халуун ус, хог цэвэрлэгээ, тээвэрлэлт, хот тохижуулах, иргэдийн үйлчилгээ зэрэг үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчийн болон хувийн хэвшлийн нэгжүүд хамрагдана.

2. Мэдээллийн эх үүсвэр. Төрийн өмчийн байгууллагуудын мэдээллийн үндсэн эх үүсвэр нь улсын болон орон нутгийн төсвийн гүйцэтгэл, тухайн байгууллагууд дээр хөтлөгдөж байгаа нягтлан бодохын тайлан тэнцэл болон бусад тайлан мэдээ байна.

Бизнес эрхлэгчид болон мэргэжлийн чиглэлийн холбоо, эвсэл, улс төрийн байгууллагууд болон бусад төрийн бус байгууллагын хувьд “Төрийн бус байгууллагын орлого, зарлагын 20... оны ...-р улирлын тайлан” ТББ-1 маягт, шашны байгууллагын хувьд “Сүм хийдийн үйл ажиллагааны ...-р улирлын, жилийн тайлан” СХ-1 маягт, кино, радио телевиз, чөлөөт цагт зориулагдсан бусад ажиллагаа, мэдээллийн агентлагийн үйл ажиллагаа, номын сан, архив, музей, түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах үйл ажиллагаа, дархан цаазат газар, биеийн тамир, чөлөөт цагт зориулагдсан бусад үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн байгууллагуудын хувьд “Бизнесийн бусад үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн орлого, зардлын улирал, жилийн тайлан” ҮХХ-2 маягт, угаалга, хими цэвэрлэгээний үйлчилгээ, халуун ус, үсчин, гоо сайхны газруудын хувьд “Үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн орлого, зардлын 200.. оны ...-р улирлын тайлан” ҮЗ-1, хог цэвэрлэгээ, тээвэрлэлт, хот тохижуулах, иргэдийн үйлчилгээ зэрэг үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын хувьд “Орон сууц, нийтийн аж ахуйн орлого, зарлагын ... оны ...-р улирлын мэдээ” МЗ-1 маягт нь мэдээллийн эх үүсвэр болно.

Жүжигчид, дуучид, уран бүтээлчдийн хувьд тэдгээрийн тоглолтоо явуулсан танхимаар хангасан үйлчилгээний байгууллагаас авсан мэдээлэл нь тооцооны эх үүсвэр болно.

3. Нийт үйлдвэрлэлт. Төрийн бус байгууллагууд болон төрийн өмчийн байгууллагуудын нийт үйлдвэрлэлтийг тооцохдоо тухайн байгууллагуудын урсгал зардлын хэмжээгээр тооцно. Энэ тооцоо нь “Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа”-ны салбарынхтай адил зарчмаар тооцогдоно.

Хувийн хэвшлийн байгууллагуудын нийт үйлдвэрлэлт нь үндсэн үйл ажиллагаанаас олсон (үзвэр, үйлчилгээний орлого) нийт орлого, байр, тоног төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого, дахин борлуулахаар худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулсан бол түүнээс орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийн өөрчлөлт болон бусад орлого (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) зэргээс бүрдэнэ. *Худалдааны нэмэгдлийг аж үйлдвэрийн салбарын тооцоонд тусгасантай адил зарчмаар тооцно.*

Төрийн бус байгууллагууд, шашны байгууллагууд нь ашгийн бус, өрхөд зах зээлийн бус үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд учраас нийт үйлдвэрлэлтийг урсгал зардлын дүн буюу “Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа”-ны салбарынхтай адил зарчмаар тооцно.

Жүжигчид, дуучид, уран бүтээлчдийн хувьд зарагдсан тасалбарын орлого нь нийт үйлдвэрлэлт, байрны түрээсийн төлбөр нь завсрын хэрэглээ болно.

2.1.2 Албан бус секторын тооцоо

1. Хамрах хүрээ. Албан бус секторын үйл ажиллагаанд санхүүгийн тайлан тэнцэл хөтлөхгүйгээр, хоршоолон нэгдэхгүйгээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй жижиг нэгжүүд (иргэд)-ийн үйл ажиллагааг хамруулна. Эдгээр нэгжүүдийн үйл ажиллагааг холбогдох салбаруудын тооцоонд оруулж тооцно.

2. Мэдээллийн эх үүсвэр. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй жижиг нэгжүүд (иргэд)-ийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн эх үүсвэр нь 5 жил тутам явуулдаг “Аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн тооллого”-ын дүнгээр гаргасан бизнес регистрийн сан дахь бүртгэл байна. Энэхүү мэдээлэл нь эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн болон дэд салбарын ангиллаар гарна.

3. Тооцооны арга зүй. Бизнес регистрийн сангийн мэдээлэлд үндэслэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэдийн үйл ажиллагааг дараахь байдлаар тооцно:

3.1 Бизнес регистрийн сан дахь үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй жижиг нэгжүүдийн тоог ҮТЕГ-аас салбарын үйл ажиллагааны чиглэлээр нь гаргуулж авдаг патенттай иргэдийн тооны өөрчлөлтийг ашиглан жил бүр шинэчилж, засварлана.

- 3.2 Бизнес регистрийн сан дахь үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй нэгжүүдийн нэг нэгжид ногдох дундаж орлогыг тооцохдоо харгалзах салбаруудын нэмэгдэл өртгийн тооцоонд ашиглагдах түүвэр судалгааны жижиг нэгжүүдийн жилийн дундаж орлогын (худалдааны салбарын хувьд худалдааны нэмэгдлийн) өөрчлөлтийг ашиглан тооцно.
- 3.3 Албан бус секторт үйл ажиллагаа эрхэлж буй нэгжүүдийн тухайн жилийн нийт үйлдвэрлэлтийг тооцохдоо дээрх 2 үзүүлэлтийг ашиглана. Ингэхдээ үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй нэгжүүдийн шинэчилсэн тоог нэг нэгжид ногдох засварласан дундаж орлогоор (худалдааны салбарын хувьд худалдааны нэмэгдлээр) үржүүлж нийт үйлдвэрлэлтийг тооцож гаргана.
- 3.4 Завсрын хэрэглээг тооцохдоо мөн үндсэн салбаруудын түүвэр судалгааны жижиг нэгжүүдийн зардлын бүтцийг ашиглаж тооцно. Худалдаа, тээврийн салбаруудад тусгайлсан судалгааны үр дүнгээр гарсан нийт үйлдвэрлэлтийн бүтцийг ашиглана.
- 3.5 Тодорхой давтамжтай явуулсан судалгааны үр дүнг ҮСГ-ын холбогдох шийдвэрээр баталгаажуулсан байна.

4. Нэмэлт мэдээлэл. Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэрт суурилан гаргасан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй өрхийн тоо, Хувь хүний орлогын албан татварын мэдээлэл, Монгол банкинд алт тушаасан иргэдийн мэдээлэл, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, Ажиллах хүчний судалгаа гэх мэт судалгаануудын албан бус секторын үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг дээрх тооцооны хамралтыг хянаж засварлах нэмэлт эх үүсвэр болгон ашиглана.

2.1.3 Салбаруудын нэмэгдэл өртгийн үнэлгээг макро түвшинд уялдуулах

2.1.3.1 Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ

Мэдээллийн эх үүсвэр. “Монгол Банкны орлого, зарлагын мэдээ” МБ-1 маягт, “Арилжааны банкны орлого, зарлагын улирлын тайлан” ББ-1, “Банк бус санхүүгийн байгууллагуудын орлого, зарлагын 20... оны ...-р улирлын тайлан” ББ-1 маягт

Санхүүгийн зуучлагчид нь мөнгө зээлэхдээ доогуур хүү төлж, мөнгө зээлдүүлэхдээ өндөр хүү авдаг. Зээлдүүлэгчдэд төлөх болон зээлдэгчдээс авах хүүгийн хэмжээ харилцан адилгүй байдгаас үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг шууд тодорхойлох боломжгүй байдаг. Санхүүгийн зуучлагчид нь хүүгийн цэвэр орлогоор зарлагаа санхүүжүүлж, үлдсэн нь үйл ажиллагааны ашиг болно. Үүнийг ҮТС-д тодорхой төлбөргүй үзүүлсэн үйлчилгээний өртөг буюу шууд бус тооцсон санхүүгийн зуучлалын үйлчилгээ (FISIM) гэсэн шууд бус хэмжигдэхүүнийг ашиглан тооцдог. Шууд бус тооцсон санхүүгийн зуучлалын үйлчилгээний хэмжээг банкны системийн байгууллагад бусад байгууллага, иргэдээс зээлийн хүүд төлсөн төлбөр болон банкны системийн байгууллагаас бусад төлсөн хүүгийн зөрүүний нийлбэрээр тооцно.

Шууд бус тооцсон санхүүгийн зуучлалын үйлчилгээ нь санхүүгийн секторын үйлдвэрлэл, бусад салбарын үйлдвэрлэгчийн завсрын хэрэглээ, ӨАА-н эцсийн хэрэглээ эсвэл эдийн засгийн харъяат бус этгээдийн экспортын орлогын аль нэг хэлбэрээр бичигдэх ёстой. Гэвч мэдээллийн эх үүсвэрээс хамааран салбаруудын завсрын хэрэглээнд хуваарилах боломжгүй байгаа тул давхардлыг арилгах үүднээс санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээний хэмжээг нийт дүнгээр нь ДНБ-ээс хасалт хийнэ.

2.1.3.2 Салбаруудын нэмэгдэл өртгийг бараа, үйлчилгээний цэвэр татварын хэмжээгээр засварлах

Мэдээллийн эх үүсвэр. Салбаруудын нэмэгдэл өртгийн тооцоо, Улсын нэгдсэн төсвийн мэдээ байна.

Нэмэгдэл өртгийн үнэлгээ нь уг үзүүлэлт ямар үнийн агууламжтай байгаагаас шалтгаална. ДНБ-ий тооцоонд 3 төрлийн үнэ хэрэглэдэг, үүний дотор үйлдвэрлэлийн аргаар тооцох нөхцөлд үндсэн ба үйлдвэрлэгчийн үнийн аль нэгийг сонгодог. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн нийт үйлдвэрлэлт нь борлуулалтын үнэ буюу ҮТС-ийн агуулга талаасаа бол үйлдвэрлэгчийн үнээр үнэлэгдэж, энэ борлуулалтаасаа нэмэгдсэн өртгийн татвар төлж байна. Зах зээлийн зориулалттай үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг нэгж, салбаруудын нийт бүтээгдэхүүн нь *үйлдвэрлэгчийн үнээр буюу нэмэгдсэн өртгийн татвараас бусад шууд бус татвар, татаасуудыг агуулсан* байдаг. Харин зах

зээлийн бус үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг нэгжийн нийт үйлдвэрлэлт нь *шууд бус татвар, татаасуудыг* агуулаагүй буюу үндсэн үнээр үнэлэгддэг. ДНБ-ий тооцоонд салбаруудын тооцоо өөр өөр үнэлгээтэй байж болохгүй, үнэлгээ нь үнийн адил түвшинд (үндсэн, эсвэл үйлдвэрлэгчийн үнийн) байх шаардлагатай. Иймд зах зээлийн зориулалттай үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг салбаруудын нийт үйлдвэрлэлт, нэмэгдэл өртгийг үндсэн үнээр үнэлэхийн тулд түүнд тусгагдсан *нэмэгдсэн өртгийн татвараас бусад шууд бус татвар, татаасуудыг* хасч цэвэрлэх буюу засварлаж үндсэн үнээрх нийт үйлдвэрлэлт, нэмэгдэл өртгийг тооцно.

ДНБ-ийг тооцохдоо салбаруудын дүнгээр нэгтгэн гаргасан үндсэн үнээрх нэмэгдэл өртөг дээр бараа, үйлчилгээний цэвэр татварыг нэмэх буюу улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлд тусгагдсан бараа, үйлчилгээний татварын хэмжээг нэмж, харин улсын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэлээс татаасын хэмжээг хасна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлээс авах бараа, ажил, үйлчилгээний татвар:

- Нэмэгдсэн өртгийн албан татвар
- Дотоодын үйлдвэрлэлтийн архи, тамхины онцгой албан татвар
- Гадаад үйл ажиллагааны орлогын албан татвар (импортоор оруулж ирсэн архи, тамхины онцгой албан татвар орно.)

Улсын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэлээс авах бараа, ажил, үйлчилгээний үнийн татаас:

- Эрчим хүч, дулааны алдагдлын татаас
- Нийтийн тээврийн үйлчилгээний татаас

2.1.4 Дотоодын нийт бүтээгдэхүүнийг өмчийн хэлбэрээр тооцох

Улс орон зах зээлийн харилцаанд шилжих явцад эдийн засаг дахь өмчийн бүтцэд ихээхэн өөрчлөлт гардаг бөгөөд энэ нь улс орны хэмжээнд тайлант хугацаанд бий болсон ДНБ-ий дүнд төрийн болон хувийн хэвшлийн оролцоо, эзлэх байр суурийг тооцож, тодорхойлсноор илэрхийлэгдэнэ.

Мэдээллийн эх үүсвэр: ҮСГ-ын бизнес регистрийн сангийн мэдээлэл, Төрийн өмчийн хорооны мэдээлэл, салбаруудын эдийн засгийн үйл ажиллагааны жилийн тайлан, мэдээ зэрэг болно.

Бизнес регистрийн санд аж ахуйн нэгж, байгууллагыг өмчийн хэлбэрээр нь төрийн өмчийн, орон нутгийн өмчийн, хувийн өмчийн гэж 3 ангилал бөгөөд төрийн болон орон нутгийн өмчийг дотор нь төрийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой, гадаадтай хамтарсан гэж; хувийн өмчийг Монгол улсын иргэний, гадаадтай хамтарсан, гадаад улсын гэж ангилна. Эдгээр нь тус бүрдээ кодлогдсон байна. ДНБ-д төрийн болон хувийн хэвшлийн оролцоог тодорхойлохын тулд юуны өмнө салбаруудын нэмэгдэл өртгийн тооцоог аж ахуйн нэгж, байгууллага бүрээр нь гаргана.

Аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл нь өмчийн хэлбэр, төрийн болон хувийн өмчийн эзлэх хувь хэмжээ, эдийн засгийн салбарын ангилал, нэмэгдэл өртгийн хэмжээ зэрэг үзүүлэлтүүдийг агуулсан байна. Бизнес регистрийн сан дахь өмчийн хэлбэрийн харгалзах кодыг ашиглан аж ахуйн нэгжийн нэмэгдэл өртгийг төрийн болон хувийн өмчөөр нь ялгаж нэгтгэнэ.

ДНБ-ийг өмчийн хэлбэрээр тооцохын тулд аж ахуйн нэгж, байгууллагуудыг дараахь байдлаар ангилна.

1. Төрийн сектор: төрийн байгууллага, төсөвт газрууд, төрийн хяналтан доор үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага, төрийн хяналттай, гол төлөв Засгийн газраас санхүүждэг хуулийн этгээд багтдаг. Хэрэв аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 50, түүнээс дээш хувийг төр эзэмшиж байвал тэдгээр аж ахуйн нэгж, байгууллага төрийн секторт хамрагдана.
2. Хувийн сектор: төрийн хяналт, оролцоогүй аж ахуйн нэгж, байгууллагууд, эсвэл төрийн оролцоотой ч төрийн эзэмшиж буй хувь нь өмчийн 50-иас доош хувийг эзэлж байвал тухайн аж ахуйн нэгж, байгууллагууд нь хувийн секторт хамрагдана. Хувийн секторт хувийн өмчтэй болон хувийн өмч давамгайлсан дээрх нэгжүүдээс гадна өрхийн аж ахуй болон өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус байгууллагууд орно.

Ашгийн бус байгууллагыг өмчийн хэлбэрээр нь ангилахын тулд үйл ажиллагаа явуулж байгаа хэлбэрээр нь 3 хувааж авч үзнэ. Үүнд:

1. Аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилдэг ашгийн бус байгууллага – Энэ нь ҮТС-ийн тодорхойлолтын дагуу зах зээлийн үйлдвэрлэгчид юм. Өөрөөр хэлбэл, тэдгээрийн үйлчилгээг худалдан авч байгаа аж ахуйн нэгж байгууллагууд нь үйлчлүүлснийхээ төлөө төлбөр төлдөг. Аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилдэг ашгийн бус байгууллагын жишээнд Худалдаа аж үйлдвэрийн танхим, хөдөө аж ахуй, аж үйлдвэр болон худалдааны холбоод, ажил олгогчдын холбоод зэрэг байгууллагуудыг дурьдаж болно. Эдгээр байгууллагууд нь мөн *хувийн сектор*т хамрагдана.
2. Өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус байгууллага: Эдгээр нь үнэ төлбөргүй эсвэл эдийн засгийн ач холбогдолгүй үнээр үйлчилгээ үзүүлдэг зах зээлийн бус үйлдвэрлэгч юм. Эдгээр байгууллагуудын жишээнд мэргэжлийн байгууллагын холбоод, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, улс төрийн намууд, сүм хийд, нийгэм, соёлын үйл ажиллагаа явуулдаг, чөлөөт цаг болон биеийн тамирын клубууд, буяны, тусламжийн байгууллагуудыг дурьдаж болно. Эдгээр байгууллагууд нь *хувийн сектор*т хамрагдана.
3. Засгийн газрын хяналтан дор байж, Засгийн газраас гол төлөв санхүүждэг, хуулийн этгээд: өөрөөр хэлбэл, үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлдэг зах зээлийн бус үйлдвэрлэгчид юм. Эдгээр байгууллагын жишээнд Монголын Ахмадын Холбоог дурьдаж болно. Эдгээр нэгжүүд нь *төрийн сектор*т хамрагдана.

2.2 Дотоодын нийт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн аргаар, зэрэгцүүлэх үнээр тооцох

Эдийн засгийн өсөлт гэдэг нь хамгийн энгийнээр тайлбарлавал улс орны хэмжээнд тодорхой хугацааны туршид үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний өсөлт юм. Эдийн засгийн өсөлтийг бодит өсөлтөөр хэмждэг бөгөөд энэ нь инфляцийн буюу үнийн нөлөөллийг арилгасан өсөлт буюу бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлтийн биет хэмжээний өсөлт юм.

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний **тоо хэмжээ** нэмэгдээгүй байхад зөвхөн **үнэ** өссөнөөс шалтгаалж бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн хэмжээ өссөн байж болно. Энэ нь улс орны эдийн засгийн амьдралд гарч байгаа бодит өөрчлөлтийг харуулж чадахгүй юм. Иймд бодит өсөлт буюу биет хэмжээний өөрчлөлтийг тодорхойлох шаардлага зүй ёсоор тавигддаг бөгөөд энэхүү үнийн өсөлтийн нөлөөг арилгахын тулд “суурь оны үнэ буюу зэрэгцүүлэх үнэ”-ийг ашигладаг. Суурь оны үнэ гэдэг нь суурь болгож авсан тухайн нэг тодорхой “оны үнэ” байна. Тооцоонд ашиглагдах бүтээгдэхүүний суурь оны үнийг холбогдох шийдвэрээр баталгаажуулсан байна.

Эдийн засгийн бодит өсөлт нь зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ-ий өөрчлөлтөөр илэрхийлэгддэг.

ДНБ-ийг зэрэгцүүлэх үнээр үнэлэх 2 арга байдаг. Энэ нь шууд болон давхар дефляторын арга юм.

Шууд дефляторын арга гэдэг нь нэмэгдэл өртгийг шууд зэрэгцүүлэх үнэд шилжүүлэх арга, харин давхар дефляторын арга нь нийт үйлдвэрлэлт, завсрын харэглээг тус тусад нь зэрэгцүүлэх үнээр үнэлж, дараа нь тэдгээрийн зөрүүгээр зэрэгцүүлэх үнээр үнэлсэн нэмэгдэл өртгийг гаргаж авах арга юм. Давхар дефляторын аргыг ашиглах талаар аргачлал байгаа болно. Манай орны хувьд мэдээллийн эх үүсвэрийн боломжоос шалтгаалан шууд дефляторын аргыг хэрэглэж байна. Нэмэгдэл өртгийг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхэд биет хэмжээний индекс, үнийн индексийг ашиглах бөгөөд *тооцоонд биет хэмжээний индексийг ашигласан бол зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг биет хэмжээний индексээр үржүүлнэ. Харин үнийн индекс ашигласан бол тайлант оны нэмэгдэл өртгийг суурь онтой харьцуулсан үнийн индекс хувааж, зэрэгцүүлэх үнээр үнэлсэн тайлант оны нэмэгдэл өртгийг тооцно.*

Салбаруудын нэмэгдэл өртөг, санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ, бараа, үйлчилгээний татвар, татаасыг тус бүрд нь зэрэгцүүлэх үнэд шилжүүлнэ.

Салбаруудын нэмэгдэл өртгийг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэх аргыг авч үзвэл:

ХӨДӨӨ АЖ АХУЙ, АН АГНУУР, ОЙН АЖ АХУЙ

Газар тариалан, мал аж ахуй: Салбарын нэмэгдэл өртгийг зэрэгцүүлэх үнээр үнэлэхдээ дараахь дарааллыг баримтална. Үүнд:

1. Салбарын нийт үйлдвэрлэлтийн хэмжээг бүрэн төлөөлөх бүтээгдэхүүний нэр төрлүүдийн тухайн жилийн биет хэмжээний гүйцэтгэлийг бүтээгдэхүүн бүрийн суурь оны үнээр үнэлнэ. ($\square Q_{t+1} P_0$)
2. Бүтээгдэхүүний нэр төрлүүдийн өмнөх жилийн биет хэмжээний гүйцэтгэлийг бүтээгдэхүүн бүрийн суурь оны үнээр үнэлнэ. ($\square Q_t P_0$)
3. Салбарын биет хэмжээний индексийг тооцно.

$$I = \frac{\sum Q_{t+1} P_0}{\sum Q_t P_0}$$

4. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийн хэмжээг дээрх биет хэмжээний индексээр үржүүлж, зэрэгцүүлэх үнээр үнэлсэн тухайн жилийн нэмэгдэл өртгийн хэмжээг тооцно.

$$H\Theta_t = H\Theta_{t-1} * I$$

$H\Theta$ - нэмэгдэл өртөг

Ан агнуур: Тайлант жилд агнасан ангийн тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.

Ойн аж ахуй: Тайлант жилд ойгоос бэлтгэсэн модны хэмжээг өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.

ЗАГАСНЫ АЖ АХУЙ

- Тайлант жилд барьсан загасны тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг, биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.

УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАР

БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР

ЦАХИЛГААН, ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ ҮЙЛДВЭРЛЭЛ, УСАН ХАНГАМЖ

Эдгээр салбаруудын хувьд нэмэгдэл өртгийг зэрэгцүүлэх үнээр үнэлэхдээ газар тариалан, мал аж ахуйн салбаруудын нэгэн адил тухайн салбаруудын гол нэр төрлийн бүтээгдэхүүний биет хэмжээний индексийг ашиглаж тооцно. Биет хэмжээний индексийг аж үйлдвэрийн салбарын жилийн эцсийн мэдээ (маягт АҮ-7)-гээр засварласан тооцоонд үндэслэж тооцно. Аж үйлдвэрийн мэдээнд биет хэмжээний индекс тооцдоггүй машин, тоног төхөөрөмж үйлдвэрлэл, радио, телевизор, холбооны хэрэгсэл үйлдвэрлэл, тээврийн бусад төхөөрөмжийн үйлдвэрлэлийн салбаруудын хувьд цахилгаан машин, хэрэгсэл үйлдвэрлэлийн салбарын биет хэмжээний индексийг; хоёрдогч түүхий эд бэлтгэлийн салбарт мебель тавилга үйлдвэрлэл болон бусад боловсруулах аж үйлдвэрийн салбарын бусад гэсэн салбарын биет хэмжээний индексийг тус тус ашиглана.

Зарим дэд салбарын хувьд үнийн индекс ашиглана. Тухайлбал, алт, мөнгөн эдлэл үйлдвэрлэлийн салбарт хэрэглээний үнийн индексийн үнэт эдлэл, төрөл бүрийн цаг гэсэн бүлгийн суурь онтой харьцсан индексийг; бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэлийн салбарт хэрэглээний үнийн индексийн мэдээллийг боловсруулах тоног төхөөрөмж бүлгийн суурь онтой харьцсан индексийг; эрчим хүч, дулаан түгээлтийн салбарт эрчим хүч, дулаан үйлдвэрлэлтийн үнийн суурь онтой харьцсан индексийг тус тус ашиглана.

Аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийг зэрэгцүүлэх үнээр тооцох жишээг авч үзье. Аж үйлдвэрийн салбарт мэдээллийн эх үүсвэрээс шалтгаалан биет хэмжээний индекс, үнийн индексийн аль аль нь ашиглагдах тул бусад салбаруудын зэрэгцүүлэх үнийн тооцоог хийхэд дараах тооцооны зарчим хэвээр хадгалагдана.

Аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэх жишээ

Салбар	Нэмэгдэл өртөг, оны үнээр, сая төгрөг			Биет хэмжээний өсөлтийн индекс		Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр, сая төгрөг		
	Суурь он t_0	t_1	t_2	I_1	I_2	Суурь он t_0	t_1	t_2
А	1	2	3	4	5	6=1	7=(6*4)/100	8=(7*5)/100
Уул уурхай, олборлох үйлдвэр	90.0	127.5	177.0			90.0	104.5	134.0
нүүрс олборлолт	10.0	15.0	18.0	101.1	103.0	10.0	10.1	10.4
газрын тос, шатдаг хий олборлолт	5.0	6.0	3.0	102.5	105.0	5.0	5.1	5.4
металлын хүдэр олборлолт	66.0	94.5	142.0			66.0	80.1	108.8
<i>алт болон бусад төмрийн хүдэр олборлолт</i>	20.0	25.5	50.0	120.0	135.0	20.0	24.0	32.4
.....								
бусад ашигт малтмал олборлолт	9.0	12.0	14.0	101.5	103.0	9.0	9.1	9.4
Боловсруулах аж үйлдвэр	173.0	219.5	283.0			173.0	178.2	187.6
хүнс, ундаа үйлдвэрлэлт	52.0	66.0	86.0			52.0	55.3	59.8
мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	5.0	6.0	8.0	102.0	103.6	5.0	5.1	5.3
.....								
ундаа үйлдвэрлэл	31.0	38.0	47.0			31.0	33.6	37.2
<i>Архи, спирт үйлдвэрлэл</i>	15.0	16.0	19.0	110.0	111.5	15.0	16.5	18.4
<i>Дарс үйлдвэрлэл</i>	4.0	6.0	7.0	105.0	107.5	4.0	4.2	4.5
<i>Пиво үйлдвэрлэл</i>	9.0	11.0	13.0	107.0	109.8	9.0	9.6	10.6
<i>Ундаа, ус үйлдвэрлэл</i>	3.0	5.0	8.0	110.0	112.0	3.0	3.3	3.7
тамхи үйлдвэрлэл	2.0	4.0	5.0	101.0	101.5	2.0	2.0	2.1
нэхмэлийн үйлдвэрлэл	13.0	16.0	18.0			13.0	13.5	14.1
<i>Ээрэх, нэхэх, будах үйл ажиллагаа</i>	6.0	8.0	9.0	105.0	106.5	6.0	6.3	6.7
<i>Бусад нэхмэл эдлэл үйлдвэрлэл</i>	4.0	3.0	5.0	102.0	101.5	4.0	4.1	4.1
<i>Сүлжмэл даавуу, хувцас үйлдвэрлэл</i>	3.0	5.0	4.0	103.5	104.5	3.0	3.1	3.2
хувцас үйлдвэрлэл	6.0	8.0	7.0	102.0	104.0	6.0	6.1	6.4
арьс шир боловсруулах үйлдвэрлэл	5.0	8.0	12.0	101.5	105.0	5.0	5.1	5.3
.....								
машин, тоног төхөөрөмж үйлдвэрлэл	5.0	4.0	6.0	101.5	106.5	5.0	5.1	5.4
бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл*	6.0	5.0	7.0	102.4	103.7	6=1 6.0	7=(6/4)*100 5.9	8=(6/5)*100 5.8
цахилгаан машин, хэрэгсэл үйлдвэрлэл	2.0	3.5	4.5	101.5	106.5	2.0	2.0	2.2
.....								
мебель тавилга үйлдвэрлэл болон бусад боловсруулах аж үйлдвэр	13.0	18.0	24.5			13.0	12.8	13.0
<i>мебель тавилга үйлдвэрлэл</i>	6.0	7.0	10.0	101.1	100.5	6.0	6.1	6.1
<i>алт, мөнгөн эдлэл үйлдвэрлэл*</i>	5.0	7.5	9.5	106.5	105.0	6=1 5.0	7=(6/4)*100 4.7	8=(6/5)*100 4.8
<i>бусад</i>	2.0	3.5	5.0	102.0	103.4	2.0	2.0	2.1
хоёрдогч түүхий эд бэлтгэл	4.0	5.5	6.0	102.0	103.4	4.0	4.1	4.2
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	29.8	34.3	37.7			29.8	30.5	31.9
эрчим хүч, дулаан үйлдвэрлэл	20.8	22.8	24.7			20.8	21.2	22.0
<i>эрчим хүч, дулаан үйлдвэрлэл</i>	10.0	11.5	13.0	102.0	103.0	10.0	10.2	10.5
<i>эрчим хүч, дулаан түгээлт*</i>	10.8	11.3	11.7	102.2	104.5	6=1 10.8	7=(6/4)*100 11.0	8=(6/5)*100 11.5
усан хангамж	9.0	11.5	13.0	103.5	106.0	9.0	9.3	9.9

* Үнийн индекс ашиглана.

Эрчим хүч, дулаан түгээлтийн суурь онтой харьцсан үнийн индексийг дараах байдлаар тооцно.

Үзүүлэлт	Мөрийн дугаар	Суурь он (t_0)		t_1		t_2	
		Нэгжийн үнэ (төг)	Биет хэмжээ	Нэгжийн үнэ (төг)	Биет хэмжээ	Нэгжийн үнэ (төг)	Биет хэмжээ
А	Б	1	2	3	4	5	6
Үйлдвэрлэсэн эрчим хүч (квт.цаг)	1	51	7000	51	7100	51	7250
Үйлдвэрлэсэн дулаан (Гкал)	2	1300	8000	1330	8220	1360	8300
Эрчим хүчний нийт үйлдвэрлэлт (төг)	3	багана1*багана2 357000		багана3*багана2 357000		багана5*багана2 357000	
Дулааны нийт үйлдвэрлэлт (төг)	4	багана1*багана2 10400000		багана1*багана2 1060000		багана1*багана2 1088000	
Нийт үйлдвэрлэлт (төг)	5=мөр3+мөр4	10757000		10997000		11237000	
Үнийн индекс	6			10997000/10757000*100 = 102.2		11237000/10757000*100 = 104.5	

БАРИЛГА

- Барилгын салбарын зэрэгцүүлэх үнээр үнэлсэн нэмэгдэл өртгийг тооцоходоо тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн орон сууцны урсгал засварын материалын бүлгийн суурь онтой харьцсан индексэд хуваана.

БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА, МАШИН, ГЭР АХУЙН БАРААНЫ ЗАСВАРЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн тайлант оны нэмэгдэл өртгийг дэд салбар тус бүрээр тооцож гаргана.

Машин, мотоцикл, түлш, шатахууны худалдаа, засвар үйлчилгээ:

- Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн хувийн тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ дэд салбарын суурь онтой харьцсан индексэд хуваана.

Машин, мотоциклоос бусад барааны бөөний болон комиссын худалдаа:

- Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн барааны бүлгийн үнийн суурь онтой харьцсан ерөнхий индексэд хуваана.

Машин, мотоциклоос бусад барааны жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ:

- Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн барааны бүлгийн үнийн суурь онтой харьцсан ерөнхий индексэд хуваана.

ЗОЧИД БУУДАЛ, ЗООГИЙН ГАЗАР

Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн тайлант оны нэмэгдэл өртгийг дэд салбар тус бүрээр тооцож гаргана.

Зочид буудал

- Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн ресторан, кафе, бусад зоогийн газар бүлэг дэх рестораны хоолны үнийн суурь онтой харьцсан индексэд хуваана.

Зоогийн газар

- Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн ресторан, кафе, бусад зоогийн газар бүлэг дэх зоогийн газрын хоолны үнийн суурь онтой харьцсан индексэд хуваана.

ТЭЭВЭР, АГУУЛАХЫН АЖ АХУЙ, ХОЛБОО

Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн тайлант оны нэмэгдэл өртгийг дэд салбар тус бүрээр тооцож гаргана.

Хуурай замын тээвэр

- *Төмөр зам*
 - Төмөр замын салбарын ачаа болон зорчигч эргэлтийн шилжүүлсэн тн.км-ыг өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.
- *Авто тээвэр*
 - Хүн тээвэр*
 - Авто тээврийн салбарын зорчигч эргэлтийг өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.
 - Ачаа тээвэр*
 - Авто тээврийн салбарын ачаа эргэлтийг өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.

Усан зам

- Усан замын салбарын ачаа тээвэрлэлтийг өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.

Агаарын тээвэр

- Агаарын тээврийн салбарын ачаа болон зорчигч эргэлтийн шилжүүлсэн тн.км-ыг өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.

Тээврийн үйл ажиллагаатай холбоотой бусад туслах үйл ажиллагаа, аялал жуулчлал

- *Агуулахын үйл ажиллагаа*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн тээврийн үйлчилгээ дэд салбарын үнийн суурь онтой харьцсан индексэд хуваана.
- *Автомашинь зогсоол*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн тээврийн үйлчилгээ дэд салбарын суурь онтой харьцсан индексэд хуваана.
- *Тээвэр зохицуулалтын үйл ажиллагаа*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн тээврийн үйлчилгээ дэд салбарын суурь онтой харьцсан үнийн индексэд хуваана.
- *Иргэний нисэхийн ерөнхий газар*
 - Нийт дамжин өнгөрсөн нислэгийн тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.
- *Аялагчдад зуучлах, тээвэр зохицуулалт*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн тээврийн үйлчилгээ дэд салбарын суурь онтой харьцсан индексэд хуваана.
- *Аялал жуулчлал*
 - Жуулчдын тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.
- *Тээвэр зуучлал*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн тээврийн үйлчилгээ дэд салбарын суурь онтой харьцсан индексэд хуваана.
- *Билетийн касс*

- Иргэний агаарын тээврээр үйлчлүүлсэн олон улсын нислэгийн зорчигчдын тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.

Холбоо

- *Шуудан*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн холбоо, шуудангийн үйлчилгээ дэд салбарын суурь онтой харьцсан индексэд хуваана.
- *Зарлага, элчийн үйл ажиллагаа*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ салбар (08)-ын үнийн суурь онтой харьцсан индексэд хуваана.
- *Утас, телеграф*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн утас, факсын үйлчилгээ бүлгийн суурь онтой харьцсан индексэд хуваана.
- *Радио, телевизийн нэвтрүүлгийг дамжуулах*
 - Кабелийн телевизийн хэрэглэгчдийн тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.
- *Сүлжээний засвар үйлчилгээ*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ салбарын суурь онтой харьцсан индексэд хуваана.
- *Интернетийн үйлчилгээ*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн утас, факсын үйлчилгээ бүлгийн интернэт кафед интернэт ашиглах хөлсний суурь онтой харьцсан индексэд хуваана.
- *Үүрэн утас*
 - Үүрэн утас хэрэглэгчдийн тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.

САНХҮҮГИЙН ГҮЙЛГЭЭ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн тайлант оны нэмэгдэл өртгийг дэд салбар тус бүрээр тооцож гаргана.

Даатгал, тэтгэврийн сангаас бусад санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа

- *Банк*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн үйлчилгээний бүлгийн суурь онтой харьцсан ерөнхий индексэд хуваана.
- *Банк бус санхүүгийн байгууллага*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн үйлчилгээний бүлгийн үнийн суурь онтой харьцсан ерөнхий индексэд хуваана.
- *Хадгаламж, зээлийн хоршоо*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн үйлчилгээний бүлгийн үнийн суурь онтой харьцсан ерөнхий индексэд хуваана.
- *Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн үйлчилгээний бүлгийн суурь онтой харьцсан ерөнхий индексэд хуваана.
- *Валют солих цэгүүдийн үйл ажиллагаа*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн үйлчилгээний бүлгийн үнийн суурь онтой харьцсан ерөнхий индексэд хуваана.

Нийгмийн даатгал, халамжийн сангаас бусад даатгал, тэтгэврийн сан

- *Даатгал*

- Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн үйлчилгээний бүлгийн суурь онтой харьцсан ерөнхий индексэд хуваана.

Бусад санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа

- *Хөрөнгийн бирж, брокерийн пүүс*

- Арилжаалагдсан хувьцааны тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг, биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ, ТҮРЭЭС, БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн тайлант оны нэмэгдэл өртгийг дэд салбар тус бүрээр тооцож гаргана.

Үл хөдлөх хөрөнгөтэй холбогдох үйл ажиллагаа

- *Үл хөдлөх хөрөнгийн түрээс*

- Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн үйлчилгээний бүлгийн суурь онтой харьцсан индексэд хуваана.

- *Орон сууцны конторын үйл ажиллагаа*

- Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн усан хангамж болон орон сууцны бусад үйлчилгээ дэд салбарын үнийн суурь онтой харьцсан индексэд хуваана.

- *Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагаа*

- Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн засвар, үйлчилгээний хөлсний суурь онтой харьцсан индексэд хуваана.

- *Орон сууцны хийсвэр түрээс*

- Түрээслэгч болон өөрийн эзэмшлийн орон сууцанд амьдардаг өрхийн тоог суурь оны түрээсийн жилийн төлбөрөөр үнэлсэн биет хэмжээний индексийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийн хэмжээг дээрх биет хэмжээний индексээр үржүүлж, зэрэгцүүлэх үнээр үнэлсэн тухайн жилийн нэмэгдэл өртгийн хэмжээг тооцно.

Машин, тоног төхөөрөмж, гэр ахуйн бараа түрээслэл

- Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн бусад бараа, үйлчилгээний бүлгийн суурь онтой харьцсан индексэд хуваана.

Компьютер, түүнтэй холбогдох үйл ажиллагаа

- Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн мэдээллийг боловсруулах тоног төхөөрөмж бүлгийн суурь онтой харьцсан индексэд хуваана.

Эрдэм шинжилгээний ажил

- *Төрийн*

- Төрийн албаны тухайн салбарт ажиллагчдын тоог өмнөх оны үзүүлэлттэй нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг, биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.

- *Хувийн*

- Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн соёл, боловсролын бараа, үйлчилгээний бүлгийн үнийн суурь онтой харьцсан индексэд хуваана.

Бизнесийн бусад үйлчилгээ

- *Судалгаа хийх үйл ажиллагаа*

- *Төрийн*

- Төрийн албаны тухайн салбарт ажиллагчдын тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.

- *Хувийн*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн бусад бараа, үйлчилгээний бүлгийн суурь онтой харьцсан индексэд хуваана.
- *Зөвлөгөө өгөх, хяналтын үйл ажиллагаа*
 - *Барилгын зураг төсөл, геологи хайгуулын ажиллагаа*
- *Төрийн*
 - Төрийн албаны тухайн салбарт ажиллагчдын тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг, биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.
- *Хувийн*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн бусад бараа, үйлчилгээний бүлгийн суурь онтой харьцсан индексэд хуваана.
- *Техникийн туршилт, шинжилгээ*
- *Төрийн*
 - Төрийн албаны тухайн салбарт ажиллагчдын тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг, биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.
- *Хувийн*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн бусад бараа, үйлчилгээний бүлгийн суурь онтой харьцсан индексэд хуваана.
- *Зар сурталчилгаа*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн бусад бараа, үйлчилгээний бүлгийн суурь онтой харьцсан индексэд хуваана.
- *Бизнесийн бусад үйл ажиллагаа*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнийн суурь онтой харьцсан индексэд хуваана.

ТӨРИЙН УДИРДЛАГА, БАТЛАН ХАМГААЛАХ, АЛБАН ЖУРМЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Төрийн албаны тухайн салбарт ажиллагчдын тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг, биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн тайлант оны нэмэгдэл өртгийг дэд салбар тус бүрээр тооцож гаргана.

Анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа

- Цэцэрлэгийн хүүхдийн тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг, биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.

Ерөнхий боловсрол олгох үйл ажиллагаа

- Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын (орой, эчнээ ангид суралцагчид орно) тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг, биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.

Дээд боловсрол олгох үйл ажиллагаа

- Их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагчдын тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг, биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.

Насанд хүрэгчдийн ба бусад боловсрол олгох үйл ажиллагаа

- Мэргэжлийн болон түр сургалтанд хамрагдагчдын тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг, биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн тайлант оны нэмэгдэл өртгийг дэд салбар тус бүрээр тооцож гаргана.

Хүн эмнэлгийн үйл ажиллагаа

- Хэвтэн эмчлүүлэгчид болон амбулаториор үйлчлүүлэгчдийн тооны жигнэсэн дундаж индексийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийн хэмжээг дээрх биет хэмжээний индексээр үржүүлж, зэрэгцүүлэх үнээр үнэлсэн тухайн жилийн нэмэгдэл өртгийн хэмжээг тооцно.

Мал эмнэлгийн үйл ажиллагаа

- Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малын тоог өмнөх онтой харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийг ашиглана.

Нийгмийн халамжийн үйл ажиллагаа

- Төрийн албаны тухайн салбарт ажиллагчдын тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг, биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.

НИЙГЭМ, БИЕ ХҮНД ҮЗҮҮЛЭХ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн тайлант оны нэмэгдэл өртгийг дэд салбар тус бүрээр тооцож гаргана.

Бохир ус, хаягдал, цэвэрлэгээ, ариутгалын үйлчилгээ

- *Төрийн*
 - Төрийн албаны тухайн салбарт ажиллагчдын тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.
- *Хувийн*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн бусад бараа, үйлчилгээний бүлгийн суурь онтой харьцуулсан индексэд хуваана.

Олон нийтийн байгууллагын үйл ажиллагаа

- *Сүм, хийдийн үйл ажиллагаа*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн үйлчилгээний бүлгийн суурь онтой харьцуулсан ерөнхий индексэд хуваана.
- *Төрийн бус байгууллагын үйл ажиллагаа*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн үйлчилгээний бүлгийн суурь онтой харьцуулсан ерөнхий индексэд хуваана.
- *Ахмадын хороо*
 - Төрийн албаны тухайн салбарт ажиллагчдын тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг, биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.

Чөлөөт цаг, соёл, биеийн тамирын үйл ажиллагаа

- *Кино, радио телевиз, бусад чөлөөт цагт зориулагдсан ажиллагаа*
 - *Төрийн*
 - Төрийн албаны тухайн салбарт ажиллагчдын тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг, биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.
 - *Хувийн*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн үйлчилгээний бүлгийн суурь онтой харьцуулсан ерөнхий индексэд хуваана.
- *Мэдээллийн агентлагийн үйл ажиллагаа*
 - *Төрийн*
 - Төрийн албаны тухайн салбарт ажиллагчдын тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг, биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.
 - *Хувийн*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн үйлчилгээний бүлгийн суурь онтой харьцуулсан ерөнхий индексэд хуваана.
- *Номын сан, архив, музей болон соёлын үйл ажиллагаа*
 - Төрийн албаны тухайн салбарт ажиллагчдын тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг, биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.
- *Биеийн тамир, чөлөөт цагт зориулагдсан бусад үйл ажиллагаа*
 - *Төрийн*
 - Төрийн албаны тухайн салбарт ажиллагчдын тоог өмнөх онтой нь харьцуулсан биет хэмжээний өөрчлөлтийн хувийг ашиглан тооцно. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг, биет хэмжээний өөрчлөлтийн хувиар үржүүлнэ.
 - *Хувийн*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн үйлчилгээний бүлгийн суурь онтой харьцуулсан ерөнхий индексэд хуваана.

Үйлчилгээний бусад үйл ажиллагаа

- *Хими цэвэрлэгээ, угаалга*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн үсчин, гоо сайхны үйлчилгээ бүлгийн суурь онтой харьцуулсан индексэд хуваана.
- *Үсчин, гоо сайхны үйлчилгээ*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн үсчин, гоо сайхны үйлчилгээ бүлгийн суурь онтой харьцуулсан индексэд хуваана.
- *Оршуулга, түүнд холбогдох үйл ажиллагаа*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн үйлчилгээний бүлгийн суурь онтой харьцуулсан ерөнхий индексэд хуваана.
- *Үйлчилгээний бусад үйл ажиллагаа*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнийн суурь онтой харьцуулсан индексэд хуваана.

САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУУД БУС ҮЙЛЧИЛГЭЭ

- Тайлант оны үнээрх санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээний хэмжээг хэрэглээний үнийн индексийн үйлчилгээний бүлгийн суурь онтой харьцуулсан ерөнхий индексэд хуваана.

БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАТВАР, ТАТААС

Татвар

- *Дотоодын үйлдвэрлэлтийн архины онцгой татвар:*
 - Боловсруулах аж үйлдвэрийн салбарын ундаа үйлдвэрлэлтийн дэд салбарын биет хэмжээний жилийн өсөлтийн индексийг ашиглана. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн тайлант оны нэмэгдэл өртгийг тооцохдоо зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг, энэ индексээр үржүүлнэ.
- *Дотоодын үйлдвэрлэлтийн тамхины онцгой татвар:*
 - Боловсруулах аж үйлдвэрийн салбарын тамхи үйлдвэрлэлтийн салбарын биет хэмжээний жилийн өсөлтийн индексийг ашиглана. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн тайлант оны нэмэгдэл өртгийг тооцохдоо зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг энэ индексээр үржүүлнэ.
- *Бараа, үйлчилгээний бусад татвар буюу нэмэгдэл өртгийн татвар, гадаад үйл ажиллагааны орлогын албан татвар (импортоор оруулж ирсэн архи, тамхины онцгой албан татвар орно.)*
 - Тайлант оны үнээрх нэмэгдэл өртгийг хэрэглээний үнийн индексийн үйлчилгээний бүлгийн суурь онтой харьцуулсан ерөнхий индексэд хуваана.

Татаас

- *Эрчим хүчний татаас:*
 - Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамжийн салбарын цахилгаан, дулаан үйлдвэрлэлтийн дэд салбарын биет хэмжээний жилийн өсөлтийн индексийг ашиглана. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн тайлант оны нэмэгдэл өртгийг тооцохдоо зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг энэ индексээр үржүүлнэ.
- *Нийтийн тээврийн татаас:*
 - Авто тээврийн ачаа тээвэрлэлтийн жилийн өсөлтийн индексийг ашиглана. Зэрэгцүүлэх үнээр үнэлсэн тайлант оны нэмэгдэл өртгийг тооцохдоо зэрэгцүүлэх үнээр үнэлсэн өмнөх оны нэмэгдэл өртгийг энэ индексээр үржүүлнэ.

2.3 Дотоодын нийт бүтээгдэхүүний зэрэгцүүлэх үнийн суурийг шинэчлэх

Зэрэгцүүлэх үнийн “суурь”-ийг шинэчлэхэд дараахь асуудлуудыг урьдчилан авч үзэх шаардлагатай.

Зэрэгцүүлэх үнийн суурийг ихэнх орнууд өөрийн орны онцлогийг харгалзан 5-10 жилд өөрчлөн тооцож байна. Өндөр хөгжилтэй орнуудад эдийн засгийн хөгжил нь тогтворжсон, эдийн засгийн бүтцэд тэр бүр хурдан өөрчлөлт ороод байдаггүйтэй холбоотойгоор суурь оныг шинэчлэх хугацаа нь хөгжиж буй орнуудтай харьцуулахад харьцангуй удаан байдаг бөгөөд харин хөгжиж байгаа орнуудын хувьд эдийн засгийн салбаруудын бүтэц хурдан өөрчлөгдөж байдагтай уялдан суурийг 5 жил тутамд шинэчлэх нь тохиромжтой гэж үздэг байна.

Суурь болгож байгаа оныг сонгож авахдаа дараахь зүйлүүдийг анхаарах нь чухал.

Суурь болгон сонгож байгаа он нь “ердийн” он байх ёстой. Байгалийн онцгой гамшигт үзэгдэл, ган гачиг, зуд, дайн дажин, газар хөдлөл зэрэг онцгой тохиолдол гарсан оныг энд сонгож авч болохгүй. Иймэрхүү онцгой тохиолдлоос шалтгаалж улс орны хэмжээнд эдийн засагт гэнэтийн өсөлт, бууралт гарч бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэд шууд нөлөөлөх учраас суурь болгож авах оныг сонгохдоо дээрх тохиолдлуудыг онцлон анхаарах шаардлагатай.

Зэрэгцүүлэх үнийн суурь оныг хэрхэн шинэчлэх талаар YTC-93 зөвлөмжид хэд хэдэн аргыг дурьдсан бөгөөд тэдгээрээс санал болгож буй үндсэн арга нь шинэ суурь оноос өмнөх онуудын тооцоог зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ салбаруудын нэмэгдэл өртөг, санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ, бараа, бүтээгдэхүүний цэвэр татварын болон ДНБ-ий өсөлтийн хувийг хадгалах арга юм. Зэрэгцүүлэх үнийн суурь оныг шинэчлэхдээ салбаруудын өсөлтийн хувийг хадгалах энэхүү аргыг ашиглана. Үүнийг жишээн дээр үзүүлбэл:

ДНБ-ий зэрэгцүүлэх үнийн суурь шинэчлэх жишээ

Салбар	Мөрийн дугаар	2000 оны зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ-ий жилийн өсөлт, бууралт		ДНБ-ий 2005 оны гүйцэтгэл, тэрбум төгрөг	2005 оны зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ, тэрбум төгрөг		2005 оны зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ-ий жилийн өсөлт, бууралт	
		2004% 2003	2005% 2004		2004	2003	2004% 2003	2005% 2004
А	Б	1	2	3	4=3/2* 100	5=4/1* 100	6=4/5* 100	7=3/4* 100
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	1	117.7	111.0	608.2	548.2	465.6	117.7	111.0
Загасны аж ахуй	2	188.1	120.0	0.1	0.1	0.05	188.1	120.0
Уул уурхай, олборлох үйлдвэр	3	134.3	110.9	608.2	548.3	408.1	134.3	110.9
Боловсруулах үйлдвэр	4	101.3	82.1	102.0	124.1	122.5	101.3	82.1
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	5	106.3	100.8	80.0	79.4	74.7	106.3	100.8
Барилга	6	98.4	115.4	58.8	51.0	51.8	98.4	115.4
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	7	106.3	104.9	226.2	215.6	202.8	106.3	104.9
Зочид буудал, зоогийн газар	8	117.3	112.0	19.3	17.2	14.7	117.3	112.0
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	9	110.6	119.8	309.1	258.0	233.2	110.6	119.8
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	10	121.7	114.3	100.0	87.5	71.9	121.7	114.3
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	11	104.7	109.7	217.1	198.0	189.0	104.7	109.7
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	12	104.0	103.4	68.4	66.2	63.6	104.0	103.4
Боловсролын салбарын үйл ажиллагаа	13	93.4	97.0	84.8	87.4	93.6	93.4	97.0
Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	14	105.3	100.4	36.9	36.8	34.9	105.3	100.4
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	15	121.6	115.4	28.0	24.2	19.9	121.6	115.4
Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ	16	126.5	115.1	-79.9	-69.4	-54.9	126.5	115.1
Бүтээгдэхүүний цэвэр татвар	17			311.7	301.4	265.6	113.5	103.4
2005 оны үнээр үнэлсэн Дотоодын нийт бүтээгдэхүүн (2000 оны үнээрх ДНБ-ий өсөлтийн хувийг хадгалсан)	18	110.1	107.3	2,779.0	2,588.7	2,352.1	110.1	107.3
2005 оны үнээр үнэлсэн Дотоодын нийт бүтээгдэхүүн (салбаруудын нийлбэрээр)	19 = мөр (1:17)				2,573.7	2,256.8		
Тооцооны зөрүү	20 = мөр18-мөр19				-15.0	-95.2		

Энэ аргыг ашиглахад гарах нэг бэрхшээл нь салбаруудын болон ДНБ-ий өсөлтийн хувийг хадгалснаар дэд салбаруудын нэмэгдэл өртгийн нийлбэр нь ДНБ-ий дүнд барихгүй, зөрөх явдал юм. Иймд улс орнууд ДНБ-ий болон салбаруудын нэмэгдэл өртгийн өсөлтийг хадгалан уг зөрүүг тусад нь харуулдаг. Энэ зөрүүг салбаруудын түвшинд хүчээр шингээж өгөх нь буруу бөгөөд ингэснээр динамикийн бодит байдлыг гажуудуулдаг байна.

Иймд дээрх жишээнд үзүүлсэнчлэн дэд салбаруудын өсөлтийн хувийг хадгалж; тооцооны зөрүүг тусгайлан харуулж өгнө.

ГУРАВ. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААР ТООЦОХ АРГА ЗҮЙ

ДНБ-ий эцсийн ашиглалтын тооцоо нь үйлдвэрлэгчдийн тухайн жилд бий болгосон нэмэгдэл өртгийг зах зээлийн арилжаа солилцооны эцэст нийгмийн хэрэгцээнд хаана, ямар хэлбэрийн өртөг болгож ашигласан болохыг харуулдаг. Эцсийн ашиглалтын

аргаархи ДНБ нь дотроо өрхийн аж ахуйн хэрэглээ, төрийн удирдлагын байгууллагын хэрэглээ, өрхийн аж ахуйд үйлчилдэг төрийн бус байгууллагын хэрэглээ, үндсэн хөрөнгийн хуримтлал, материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал, бараа үйлчилгээний цэвэр экспорт гэсэн дэд хэсгүүдэд хуваагдана. ДНБ-ийг эцсийн ашиглалтын аргаар дараах бүдүүвчээр тооцно. Үүнд:

1. Эцсийн хэрэглээ (1.1 + 1.2 + 1.3)
 - 1.1 Өрхийн аж ахуйн хэрэглээ
 - 1.2 Төрийн удирдлагын байгууллагын хэрэглээ
 - 1.3 Төрийн бус байгууллагын хэрэглээ
2. Нийт хөрөнгийн хуримтлал (2.1+ 2.2 + 2.3)
 - 2.1 Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал
 - 2.2 Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт
 - 2.3 Үнэт зүйлсийн хуримтлал
3. Бараа, үйлчилгээний цэвэр экспорт ± (3.1-3.2)
 - 3.1 Бараа, үйлчилгээний экспорт
 - 3.2 Бараа, үйлчилгээний импорт
4. Дотоодын нийт бүтээгдэхүүн (1+2) ± 3

3.1 Дотоодын нийт бүтээгдэхүүнийг эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр тооцох

3.1.1 Эцсийн хэрэглээ

Эцсийн хэрэглээ нь өрхийн аж ахуйн хэрэглээ, төрийн удирдлагын байгууллагын хэрэглээ, өрхийн аж ахуйд үйлчилдэг төрийн бус байгууллагын хэрэглээнээс бүрдэнэ.

А. Өрхийн аж ахуйн хэрэглээ

Хамрах хүрээ. Өрхийн аж ахуйн хэрэглээнд дараахи зүйлсийг хамруулна. Үүнд:

- Тайлант хугацаанд хүн амын худалдаж авсан хүнсний болон хүнсний бус бараа, үйлчилгээний зардлууд. Хүнсний бус хэрэглээний хувьд өрх зөвхөн хувийн хэрэглээндээ зориулж худалдан авсан тээврийн хэрэгсэл, цахилгаан бараа, тавилгыг хүнсний бус хэрэглээнд оруулж тооцно. Өрх үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа зориулж худалдаж авсан дээрхи төрлийн удаан эдэлгээт эд зүйлс нь өрхийн аж ахуйн хэрэглээнд орохгүй.
- Өрхийн аж ахуйгаас биет байдлаар хэрэглэсэн бүтээгдэхүүн
- Бусдаас үнэгүй авсан бүтээгдэхүүн, үйлчилгээ
- Хувийн орон сууцны хийсвэр түрээсийн зардал
- Хүн амын амь нас, эд хөрөнгийн даатгалын зардал

Мэдээллийн эх үүсвэр. ҮСГ-аас улирал тутам явуулдаг Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа нь мэдээллийн эх үүсвэр болно.

Ангилал. Өрхийн аж ахуйн хэрэглээ нь “Хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний ангилал (СОICOP)”-ын дагуу ангилагдсан байх ба уг ангиллын нэр төрөл бүрээр өрхийн хэрэглээг тооцно.

Тооцох аргачлал. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)-ны маягтын 3-р бүлэг болох Хүнсний хэрэглээ, 4-р бүлэг болох Хүнсний бус барааны худалдан авалтын мэдээллийг ашиглаж нийт хэрэглээг тооцно. **Хүнсний хэрэглээ нь** худалдан авсан, бусдаас үнэгүй авсан болон өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн бүтээгдэхүүний /гол төлөв өрхийн мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүн орно/ нийлбэрээс бүрдэх бөгөөд бусдаас үнэгүй авсан, өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүнийг үнэлэхдээ тухайн байршил дахь зах зээлийн дундаж үнийг ашиглана. Харин **хүнсний бус хэрэглээ нь** худалдан авсан болон бусдаас үнэгүй авсан бүтээгдэхүүн, үйлчилгээнээс бүрдэнэ.

Тухайн тайлант жилийн өрхийн аж ахуйн нийт хэрэглээг тооцохдоо нэг өрхийн сарын дундаж хэрэглээг нийт 12 сараар болон тухайн жилийн нийт өрхийн тоогоор үржүүлж тооцно. Өрхийн аж ахуйн хэрэглээг дараахи байдлаар тооцно:

	Судалгаанд сонгогдсон өрхийн сарын дундаж хэрэглээ				Сарын тоо	Улсын хэмжээний нийт өрхийн тоо	Жилийн нийт хэрэглээ – Бүгд
	Худалдан авсан	Бусдаас үнэгүй авсан	Өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн бүтээгдэхүүн	Өрхийн нийт хэрэглээ			
	1	2	3	4	5	6	7
Хүнсний хэрэглээ							
Мах				1+2+3	12	N	4*5*6
Сүү				1+2+3	12	N	4*5*6
.....				1+2+3	12	N	4*5*6
Дүн				1+2+3	12	N	4*5*6
Хүнсний бус хэрэглээ							
Хувцас			x	1+2	12	N	4*5*6
Гутал			x	1+2	12	N	4*5*6
.....			x	1+2	12	N	4*5*6
Дүн			x	1+2	12	N	4*5*6

Б. Төрийн удирдлагын байгууллагын хэрэглээ

Хамрах хүрээ. Засгийн газраас өрх, хүн амд үзүүлэх нийгмийн нийтлэг үйлчилгээ, төр, захиргааны удирдлага, батлан хамгаалах болон нийгмийг аюулаас хамгаалах, шинжлэх ухаан, соёл, боловсрол зэрэг нийгмийн үйлчилгээний өргөн хүрээ бүхий үйл ажиллагааг төрийн удирдлагын байгууллагын хэрэглээнд хамруулна.

Мэдээллийн эх үүсвэр. Мэдээллийн эх үүсвэр нь улсын нэгдсэн төсвийн улирал, жилийн гүйцэтгэл байна.

Ангилал. Засгийн газраас санхүүжүүлдэг үйл ажиллагааны салбарыг олон улсын (COFOG) ангиллын дагуу авах бөгөөд улсын төсвийн гүйцэтгэл ч доорхи ангиллаар гарна.

Үүнд:

- Нийтийн ерөнхий үйлчилгээ
- Батлан хамгаалах
- Нийгмийн хэв журам аюулгүй байдал
- Боловсрол
- Эрүүл мэнд
- Нийгмийн даатгал, нийгмийн халамж
- Орон сууц, нийтийн аж ахуй
- Амралт, спорт, соёл урлаг
- Эрчим хүч, дулаан хангамж
- Хөдөө аж ахуй, ойн аж ахуй
- Эрдэс баялаг, уул уурхай, үйлдвэр, барилга
- Тээвэр, холбоо
- Эдийн засгийн бусад үйл ажиллагаа

Тооцох аргачлал. Төрийн удирдлагын байгууллагын хэрэглээг дээрхи ангилал тус бүрийн хувьд дараахи бүдүүвчээр тооцож, нийт дүнг гаргана. Үүнд:

1. Завсрын хэрэглээ
2. Нэмэгдэл өртөг (2.1+2.2+2.3+2.4)
 - 2.1 Цалин, түүнтэй адилтгах орлого
 - 2.2 НДШ, ЭМД
 - 2.3 Үндсэн хөрөнгийн элэгдэл
 - 2.4 Онцгой болон бүтээгдэхүүний татвар, татаас, ашиг
3. Нийт үйлдвэрлэлт (1+2)
4. Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого
5. Төрийн удирдлагын байгууллагын хэрэглээ (3-4)

Нийт үйлдвэрлэлт нь ерөнхийдөө төсвийн нийт урсгал зардалтай тэнцэнэ. Өөрөөр хэлбэл улсын нэгдсэн төсөв дэх тухайн салбарын нийт зардлаас хөрөнгө оруулалтын зардлыг хасч, урсгал зардлын хэмжээг тооцно.

Завсрын хэрэглээнд түүхий эд, үндсэн материал, түлш шатахуун, цахилгаан эрчим хүч, дулааны эрчим хүч, уур ус, урсгал засвар, хөдөлмөр хамгааллын зардал, албан томилолт, гадны байгууллагаар үйлчлүүлсний төлбөр, даатгалын хураамж, бичиг хэргийн зардал, шуудан холбоо, байрны түрээсийн төлбөр, бусад зардал зэрэг зардлуудыг улсын төсвийн зарлагын мэдээнээс авч тооцно.

В. Төрийн бус байгууллагын хэрэглээ

Хамрах хүрээ. Өрхийн аж ахуйд үйлчилдэг төрийн бус байгууллагад улс төрийн нам, эвсэл холбоод, үйлдвэрчний эвлэл, эмэгтэйчүүд, залуучууд, оюутны зэрэг эрх ашгийн байгууллагууд, мэргэжлийн зөвлөлгөө өгөх газрууд, шашны байгууллагууд зэрэг төрийн бус байгууллагууд, мөн дипломат болон олон улсын байгууллагууд хамаарна.

Мэдээллийн эх үүсвэр. Мэдээллийн эх үүсвэр нь “Төрийн бус байгууллагын орлого, зарлагын 20.. оны ...-р улирлын тайлан” ТББ-1, “Сүм хийдийн үйл ажиллагааны ..-р улирлын, жилийн тайлан” СХ-1 маягтаар авсан мэдээлэл болно.

Тооцох аргачлал. Төрийн бус байгууллагын хэрэглээг *төрийн байгууллагын хэрэглээг тооцохтой адил зарчмаар буюу урсгал зардлаар нь* тооцно. Төрийн бус байгууллагын мөнгөн тусламжийг өрх, хүн амын орлогоор нөхөгддөг хувийн хэрэглээний өртгийн нэг эх үүсвэр гэж үзэж давхар тооцоололт гаргахгүйн үүднээс төрийн бус байгууллагын зардлын дүнд оруулдаггүй. Хэрэв өрхийн аж ахуйд үйлчилдэг төрийн бус байгууллагууд үндсэн хөрөнгийн элэгдэл тооцдог бол элэгдлийг хэрэглээнд оруулж тооцно.

3.1.2 Нийт хөрөнгийн хуримтлал

Нийт хөрөнгийн хуримтлал нь гадаад болон дотоод эх үүсвэрээс санхүүжиж, тайлант жилд эдийн засагт шинээр бүтээгдэж бий болсон хөрөнгийн хэмжээ бөгөөд олон улсын ангиллаар *үндсэн хөрөнгийн хуримтлал, материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлалаас* бүрддэг. Нийт хөрөнгийн хуримтлалд бэлэглэсэн, үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийг оруулж тооцно.

Нийт хөрөнгийн хуримтлалын бүрдэл хэсэг тус бүрийн агуулга, бүтэц, тэдгээрийг тооцох аргачлалыг авч үзье.

А. Үндсэн хөрөнгийн хуримтлал

Хамрах хүрээ: Эдийн засаг, нийгмийн салбарын бүх аж ахуйн нэгж, өрхийн аж ахуйн үндсэн хөрөнгийн хуримтлалыг хамруулна.

Мэдээллийн эх үүсвэр. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС), салбаруудын аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны улирал, жилийн тайлангийн үндсэн хөрөнгийн хуримтлалын талаарх мэдээлэл нь мэдээллийн эх үүсвэр болно.

Ингэхдээ өрхийн орлого, зарлагын судалгаанаас зөвхөн өрх хүн амын худалдаж авсан автобус, ачааны болон хүнд даацын машины дүнг үндсэн хөрөнгийн хуримтлалд оруулж тооцно. Харин салбаруудын дээрхи мэдээллийн маягтад үндсэн хөрөнгө нь дараахи үзүүлэлтүүдээр оны эхний болон эцсийн байдлаар тусгагдсан байгаа бөгөөд эдгээрийн зөрүүгээр үндсэн хөрөнгийн хуримтлал тооцогдоно. Үүнд:

Үндсэн хөрөнгийн хуримтлал тооцох үзүүлэлтүүд

А		мөрийн дугаар	оны эхэнд	оны эцэст	Зөрүү буюу ҮХХ* /2-1/
		Б	1	2	3
Үндсэн хөрөнгө	мөр 1 = мөр (2+15)	1			
Биет хөрөнгө	мөр 2 = мөр (3+4+8+9+12)	2			
Орон сууцны барилга		3			
Бусад барилга, байгууламжууд	мөр 4 = мөр (5+6)	4			
<i>орон сууцны бус барилга</i>		5			
<i>бусад байгууламжууд</i>		6			
<i>үүнээс: авто зам</i>		7			
Их засвар, өргөтгөл, шинэчлэлт, сэргээн босголтын ажил		8			
Машин, тоног төхөөрөмж	мөр 9 = мөр (10+11)	9			
<i>тээврийн хэрэгсэл</i>		10			
<i>бусад машин, тоног төхөөрөмж</i>		11			
Өсөж үрждэг хөрөнгө	мөр 12 = мөр (13+14)	12			
<i>Ажлын болон ашиг шимийн мал, амьтан</i>		13			
<i>Олон наст ургамал</i>		14			
Биет бус хөрөнгө	мөр 15 = мөр (16+17+18+19)	15			
Геологи, хайгуул, зураг төслийн ажил		16			
Компьютерийн программ хангамж		17			
Утга зохиол, урлагийн эх бүтээл		18			
Бусад биет бус үндсэн хөрөнгө		19			

* - Үндсэн хөрөнгийн хуримтлалт

Үндсэн хөрөнгийн ойлголт, тодорхойлолт. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэг жилээс дээш хугацаанд давтагдаж эсвэл үргэлжлэн ашиглагддаг хөрөнгө бөгөөд үндсэн хөрөнгө нь биет ба биет бус хөрөнгөөс бүрдэнэ.

Үндсэн хөрөнгийг бусдаас худалдан авах, бараа солилцоогоор, биет хөрөнгийн шилжүүлэг байдлаар, мөн өөрөө үйлдвэрлээд өөртөө хэрэглэх байдлаар олж эзэмшиж, харин ашиглаж байсан үндсэн хөрөнгөө худалдах, бараа солилцоогоор бусдад өгөх, бусдад үнэ төлбөргүй шилжүүлэх зэрэг хэлбэрээр эзэмшлээсээ хасна.

Үндсэн хөрөнгийн бүрэлдэхүүн бүрт дараахи зүйлсийг хамруулж ойлгоно. Үүнд:

Биет үндсэн хөрөнгө

- *Орон сууцны барилга* - Орон сууцны барилгад сууцны зориулалттай барилгаас гадна, дуусаагүй барилга, тухайлбал эзэмшигчдэд нь шилжүүлэх зорилготой баригдаж байгаа амины сууц, бусад орон сууцны барилга болон завь, ачааны усан онгоцон дээрх орон байр, нүүдлийн орон гэр зэргийг хамруулна. Цэргийн албан хаагчдын эзэмшиж буй орон сууцны барилгыг орон сууцны барилгад мөн хамруулна.
- *Бусад барилга, байгууламж* - Энэ нь орон сууцны бус барилга, бусад барилга байгууламжаас бүрдэнэ:
 - *Орон сууцны бус барилга, байгууламжид* барилга, түүний бүрэлдэхүүн хэсэгт хамаарах байгууламж, талбайг цэвэрлэх, бэлтгэхтэй холбоотой зардал, түүнчлэн орон сууцны бус барилга гэж тодорхойлогдох үйлдвэрлэл, худалдаа, нийтийн үзвэр үйлчилгээний барилга, зочид буудал, рестораны, боловсрол, эрүүл мэндийн байгууллагын барилга гэх мэт барилгууд орно.
 - *Бусад барилга, байгууламжид* орон сууцны болон орон сууцны бус барилгаас бусад байгууламж болох гудамж, суваг шуудууг барьж байгуулах, тэдгээрийг цэвэрлэх, бэлтгэхтэй холбоотой зардлууд орно. Орон сууцны болон орон сууцны бус барилгын алинд нь ч тодорхойлогдох боломжгүй байгууламж, тухайлбал, багана, туннель болон газар доорхи хөрөнгийг олборлохтой холбоотой байгууламжийг оруулна. Түүнчлэн орон сууцны бус барилгын жишээнд иргэний инженерийн байгууламжууд, тухайлбал авто зам, гудамж, төмөр зам, онгоцны нислэгийн зам, гүүр, өргөгдсөн зам, туннель, газар дорхи зам, усан зам, усан зогсоол, далан болон бусад усан замын ажил, хол зайд тавигдсан хоолой, холбооны болон эрчим хүчний шугам, кабель болон бусад байгууламжууд, олборлох, боловсруулах үйлдвэрийн байгууламж, спорт, амралтын байгууламж орно.
- *Их засвар, өргөтгөл, шинэчлэлт, сэргээн босголтын ажил* - Их засвар гэдэг нь үндсэн хөрөнгө, компьютерийн программ хангамж болон газрын үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, ашиглагдах хугацааг уртасгах, тухайн хөрөнгөөр үйлдвэрлэх бүтээгдэхүүний чанарыг сайжруулах буюу хөрөнгийн бүтээмжийг сайжруулах зорилгоор хийгдэх ажил юм. Жишээлбэл өргөтгөл, шинэчлэлт, сэргээн босголтын ажилд ой мод, чулуутай газрыг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор цэвэрлэх, мөн үерийн хамгаалалт, далан, шуудуу барих зэрэгт зарцуулсан зардал нь үйлдвэрлэгддэггүй биет хөрөнгө болох газрын өртгийг нэмэгдүүлэх зардалд хамаарна. Харин усан цахилгаан станцын усны далан барихад зарцуулж буй зардал нь үйлдвэрлэлийн барилга байгууламжийн зардал учраас үүнийг үйлдвэрлэгддэггүй үндсэн хөрөнгийг сайжруулах зардалд бус харин үндсэн хөрөнгийн зардалд оруулна.
- *Машин, тоног төхөөрөмж* - Энэ бүлэгт өрхийн аж ахуйн судалгааны дүнгээр өрхийн худалдан авсан автобус, ачааны болон хүнд даацын машины дүнг тусгана. Мөн тухайн жилд аж ахуйн нэгж байгууллагуудын худалдан авсан тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийг оруулна.
 - *Тээврийн хэрэгсэл* - Хүн, ачаа тээш зөөх хэрэгсэл, хүнд, хөнгөн даацын автомашин, усан онгоц, галт тэрэг, трамвай болон бусад моторт тэргэнцэр хэрэгсэл, нисдэг тэрэг, сансрын хөлөг, мотоцикл гэх мэт орно.
 - *Бусад машин, тоног төхөөрөмж* - Ерөнхий зориулалтын машин, албан хэрэгцээний тооцоолох төхөөрөмж, цахилгаан машин, аппарат хэрэгсэл, радио, телевиз болон холбооны тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэл, нарийн хэмжилтийн аппарат хэрэгсэл, цаг, бугуйн цаг, цөмийн тогооны шингэн элементүүд, хөгжмийн зэмсэг, албан газрын тавилга, уурын халаалтын генератор зэрэг орно.

- *Мал, амьтан, олон наст ургамал* - Байгууллагын шууд хяналт, хариуцлага, удирдлагын дор бүтээгдэхүүнийг давтан үйлдвэрлэх зорилгоор өсгөж буй үржлийн, сүүний, махны, ноос, ноолуурын чиглэлийн мал, амьтан, ажлын мал, амьтан, тарьж ургуулж байгаа олон наст ургамал буюу усан үзэм, жимсний мод зэргийг оруулна.
 - *Ажлын болон ашиг шимийн мал, амьтан* - Тухайн жилд бойжуулсан төлөөс бусад малыг үндсэн хөрөнгө буюу өсөж үрждэг хөрөнгө гэж тооцно. Иймд үндсэн сүргийн малын өсөлт энэ ангилалд хамаарна. Үүнд мөн өндөглөгч тахиа, шувууны өсөлт орно.
 - *Олон наст ургамал* - Энд жилээс жилд бүтээгдэхүүнээ өгдөг тарьж ургуулж буй таримал мод, тухайлбал чацарганы мод, жимсний бут, самарны мод, шүүс, холтос, навчаар нь бүтээгдэхүүн хийдэг мод, бут орно.

Биет бус үндсэн хөрөнгө

- *Геологи, хайгуул, зураг төслийн ажил* - Газрын тос, байгалийн хий зэрэг ашигт малтмалын геологи, хайгуулын ажлын өртөг орно. Энэ өртөгт лиценз авахын өмнөх зардал, лицензийн болон орд эзэмших зардал, хайгуулын өрөмдлөгө, цооног гаргах, агаарын зураглал хийх зэрэг зардлууд орно.
- *Компьютерийн программ хангамж* - Системийн болон хэрэглээний программ, программын тодорхойлолт, бусад туслах материалыг оруулна. Энд худалдан авсан болон өөрсдийн хэрэглээнд боловсруулсан программ хангамжийн аль алиныг нь оруулдаг. Түүнчлэн нэг жилээс дээш хугацаанд ашиглахаар төлөвлөж худалдан авсан, өөрсдөө боловсруулсан, өргөжүүлсэн томоохон хэмжээний мэдээллийн баазын зардлыг түүнийг зарж борлуулах эсэхээс хамаарахгүйгээр энд оруулна.
- *Утга зохиол, урлагийн эх бүтээл* - Урлагийн эх бүтээлүүдэд кино, дуу бичлэг, гар бичмэл, соронзон хальсанд буулгасан спорт, радио телевизийн нэвтрүүлэг, утга зохиол, дуу хөгжим, урлагийн бүтээлүүд зэргийг бичсэн бичлэг, хадгалсан зүйлүүд орно. Урлагийн эх бүтээлийг нийт хөрөнгийн хуримтлалд үнэлэхдээ худалдан авагчаас худалдагч талд төлсөн төлбөрийн хэмжээгээр бүртгэнэ. Харин эзэмшигч тухайн бүтээлийг бүтээсэн бол үүнийг үнэлэхдээ ирээдүйд өгөх ашгийн хэмжээг харгалзах бөгөөд өөр нэмэлт мэдээлэл байхгүй тохиолдолд үүнийг үйлдвэрлэсэн зардлаар нь үнэлнэ.
- *Бусад биет бус хөрөнгө* - Үйлдвэрлэлийн хэрэглээ нь хязгаарлагдмал, зөвхөн тухайн нэгжид өмчлөх эрх нь хадгалагддаг, эсвэл өөр нэгжид лицензээр эзэмшүүлсэн шинэ мэдээлэл, тодорхой мэдлэг орно.

Үндсэн хөрөнгийн үнэлгээ:

- Тайлант хугацаанд шинээр бий болсон болон ашиглаж байсан хөрөнгийг худалдан авсан бол бодит эсвэл худалдан авагчийн үнэ, түүн дээр тухайн хөрөнгийг олж эзэмших явцад гарсан тухайн өмчийн эзэмшигчийн эрхийг шилжүүлэхтэй холбоотой гарсан зардлуудыг нэмж тооцно. Үндсэн хөрөнгийг шилжүүлэхтэй холбоотойгоор дараахь төрлийн зардлууд гарч болно. Үүнд:
 1. Тухайн үндсэн хөрөнгийг олж эзэмшиж байх явцад гарсан бүх төрлийн төлбөр, хураамжууд тухайлбал, хуульч, архитектор, инженер, үнэлгээч, судлаачид, түүнчлэн үл хөдлөх хөрөнгийн газар, дуудлага худалдааны газар төлсөн төлбөр г.м зардлууд
 2. Тухайн хөрөнгийг олж эзэмшихээр эзэмшигчийг шилжүүлж байх явцад олж эзэмшиж байгаа талаас төлөгдсөн бүх төрлийн татварууд
- Ашиглаж байсан хөрөнгө эзэмшлээс хасагдсан тохиолдолд тухайн хөрөнгийг худалдсан үнээс худалдан авч байгаа талаас төлсөн төлбөр болон тухайн хөрөнгийн эзэмшигчийг шилжүүлэхтэй холбоотойгоор худалдагч талаас гарсан зардлыг хасч тооцно.
- Дуусаагүй барилга, байгууламж зэрэг хөрөнгийг олж эзэмшсэн бол тухайн үеийн зардлаар нь үнэлэх бөгөөд үүнд ашиг багтсан байна. Төлбөрийг барагдуулах үйл явц нь гэрээний үндсэн дээр хийгддэг бөгөөд тухайн үед гүйцэтгэсэн ажлын өртгийн хэмжээгээр хөрөнгийн хуримтлалд оруулна.
- Өөрийн хөрөнгөөр үйлдвэрлээд өөрөө хэрэглэсэн тохиолдолд тухайн хөрөнгийг үндсэн үнээр нь үнэлнэ. Хэрэв тухайн хөрөнгийг үнэлэх боломжгүй бол үйлдвэрлэлийн нийт өртгөөр нь тооцно.

- Биет бус үндсэн хөрөнгийг үнэлэхдээ худалдан авсан, эсвэл шилжүүлэн авсан бол худалдан авагчийн үнээр, өөрөө үйлдвэрлэсэн бол үндсэн үнээр (үндсэн үнээр тооцох боломжгүй тохиолдолд үйлдвэрлэлийн зардлаар) тус тус үнэлнэ.

Б. Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт

Хамрах хүрээ: Эдийн засаг, нийгмийн салбарын бүх аж ахуйн нэгжийн материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийг хамруулна.

Мэдээллийн эх үүсвэр: Салбаруудын аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улирал, жилийн тайлангийн материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл нь мэдээллийн эх үүсвэр болно.

Салбаруудын дээрхи мэдээллийн маягтад материаллаг эргэлтийн хөрөнгө нь дараахи үзүүлэлтүүдээр оны эхний болон эцсийн байдлаар тусгагдсан байгаа бөгөөд эдгээрийн зөрүүгээр эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийг тооцно. Үүнд:

Материаллаг эргэлтийн хөрөнгийн үзүүлэлтүүд

	мөрийн дугаар	оны эхэнд	оны эцэст	Зөрүү буюу МЭХӨ*
А	Б	1	2	3=2-1
Материаллаг эргэлтийн хөрөнгө, мөр 1 = мөр (2+3+6+7)	1			
Түүхий эд, материал	2			
Дуусаагүй үйлдвэрлэл мөр 3 = мөр (4+5)	3			
<i>өсөж үрждэг бүтээгдэхүүнээс тооцсон дуусаагүй үйлдвэрлэл</i>	4			
<i>бусад дуусаагүй үйлдвэрлэл</i>	5			
Бэлэн бүтээгдэхүүн	6			
Дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүн	7			

* - Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт

Материаллаг эргэлтийн хөрөнгийн ойлголт, тодорхойлолт. Тайлант ба тайлант оноос өмнө үйлдвэрлэгдэж борлуулахад бэлэн болсон, үйлдвэрлэлийн өөр бусад үйл ажиллагаанд хэрэглэхээр төлөвлөж байгаа бүтээгдэхүүнүүд нь материаллаг эргэлтийн хөрөнгө болно.

Материаллаг эргэлтийн хөрөнгө нь түүхий эд, материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн болон дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүнээс бүрдэх бөгөөд эдгээрт дараахи зүйлсийг хамруулж ойлгоно. Үүнд:

- *Түүхий эд, материал* - Дахин борлуулах зориулалтаар биш, харин үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа зарцуулах материал, түүхий эд тухайлбал, түлш, шатахуун, үндсэн түүхий эд, сав, баглаа боодол гэх мэтийг хамруулна. Зарим алт, эрдэнийн чулуу зэрэг үнэт зүйлс нь тодорхой үйлдвэрлэгчийн хувьд завсрын хэрэглээ (түүхий эд) байдлаар ашиглагддаг ба тухайлбал: гоёл, чимэглэлийн зүйл хийдэг үйлдвэрлэгч нь үйлдвэрлэлийнхээ үйл ажиллагаанд алт, үнэт зүйлсийг завсрын хэрэглээ байдлаар ашигладаг. Энэ тохиолдолд энэхүү завсрын хэрэглээнд ашиглагдсан алт, үнэт зүйлс нь материаллаг эргэлтийн хөрөнгөнд орно.
- *Дуусаагүй үйлдвэрлэл* - Үйлдвэрлэгчээс цаашид боловсруулалт хийхгүйгээр бусдад шилжүүлдэггүй, эсвэл үйлдвэрлэлийн дараачийн үе шатанд үргэлжлүүлэн боловсруулах хэсэгчилсэн боловсруулалт хийгдсэн бүтээгдэхүүн орно.
 - *Мал, амьтан, олон наст ургамлын дуусаагүй үйлдвэрлэл* - Нядалгаанд зориулж өсгөж буй мал, арилжааны зорилгоор үржүүлж буй шувуу, загас, түүнчлэн бүтээгдэхүүнээ давтан өгдөг боловч нас бие гүйцээгүй өсөж үрждэг мал амьтан, олон наст ургамал орно. Тухайлбал, нядалгааны зориулалтаар өсгөж байгаа мал, ажлын төл мал, үр жимсээ өгөөгүй байгаа таримал мод, ургамал дуусаагүй үйлдвэрлэлд орно.
 - *Бусад дуусаагүй үйлдвэрлэл* - Бусад дуусаагүй үйлдвэрлэлд цаашдын боловсруулалт хийхгүйгээр борлуулдаггүй, өөр нэгжид шилжүүлдэггүй, тухайн үйлдвэрлэгчээс хэсэгчилсэн боловсруулалт хийсэн, үйлдвэрлэсэн, угсарсан бүтээгдэхүүн, үйлчилгээ орно. Тухайлбал, барилга, байгууламжууд болон бусад үндсэн хөрөнгө нь бүрэн гүйцэт үйлдвэрлэгдэж дуусах хүртлээ хоёр буюу түүнээс

- дээш жил зарцуулдаг. Энэ тохиолдолд тухайн тайлант хугацаанд бүрэн гүйцэт дуусаагүй үндсэн хөрөнгө нь тухайн хөрөнгийг барьж байгуулж байгаа үйлдвэрлэгчийнхээ дуусаагүй үйлдвэрлэл болно. Өөрөө үйлдвэрлээд өөртөө хэрэглэх зорилгоор үйлдвэрлэж байгаа болон урьдчилан байгуулсан худалдааны гэрээний үндсэн дээр үйлдвэрлэгдсэн үндсэн хөрөнгө нь тэдний эцсийн хэрэглэгчийн эзэмшилд шууд очиж үндсэн хөрөнгө нь болдог учраас энэ тохиолдолд дуусаагүй үйлдвэрлэлд орохгүй.
- *Бэлэн бүтээгдэхүүн* - Бэлэн бүтээгдэхүүн нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнд бүрэн гүйцэд бүтээгдсэн, хэрэглэгчдэд нийлүүлэхэд бэлэн болсон бүтээгдэхүүн юм.
 - *Дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүн* - Бөөний болон жижиглэн худалдааны байгууллагууд хэрэглэгчдэд худалдахаар дахин боловсруулалт хийхгүйгээр олж эзэмшсэн бараа, бүтээгдэхүүн юм. Өөрөөр хэлбэл хэрэглэгчийн сонирхлыг татахуйц байдлаар чимэглэснээс өөрөөр өөрчлөөгүй бараа бүтээгдэхүүнүүд юм.

В. Үнэт зүйлсийн хуримтлал

Мэдээллийн эх үүсвэр. Монголбанкны жил, улирлын тайлангаас мөнгөжөөгүй алт /дансны дугаар 1203, 1205/, зоос, түүх, соёлын үнэт зүйлс /дансны дугаар 1206-1208/, бусад үнэт металл /дансны дугаар 1202, 1204/ гэсэн үзүүлэлтүүдийг оны эхний ба эцсийн үлдэгдлээр авч зөрүүгээр нь үнэт зүйлсийн хуримтлалыг тооцно.

Үнэт зүйлсийн ойлголт, тодорхойлолт. Үнэт зүйлсийн хуримтлалд үйлдвэрлэл, хэрэглээнд ашиглагддаггүй, цаг хугацааны явцад хэрэглээний чанар эсвэл бодит үнэ цэнээ алддаггүй, үнэ нь улам нэмэгддэг зүйлс орно.

Үнэт зүйлсийн хуримтлал тооцох үзүүлэлтүүд

	мөрийн дугаар	оны эхэнд	оны эцэст	Зөрүү буюу ҮЗХ*
А	Б	1	2	3=2-1
Үнэт зүйлсийн хуримтлал мөр 1 = мөр (2+3+4)	1			
Мөнгөжөөгүй алт	2			
Зоос, түүх, соёлын үнэт зүйлс	3			
Бусад үнэт металл	4			

* - Үнэт зүйлсийн хуримтлал

3.1.3 Бараа, үйлчилгээний цэвэр экспорт

Эцсийн ашиглалтын аргаархи ДНБ-д бараа, үйлчилгээний гадаад худалдааны зөрүү буюу цэвэр экспортын дүнг тусгадаг ба энэ нь эдийн засгийн гадаад харилцааны данс болон төлбөрийн тэнцэлтэй уялдсан байх шаардлагатай.

Мэдээллийн эх үүсвэр нь Монгол банкнаас эмхтгэн гаргадаг төлбөрийн тэнцлийн улирал, жилийн статистик мэдээлэл байна.

Тооцооны аргачлал, ойлголт, тодорхойлолт. Төлбөрийн тэнцэлд барааны экспорт, импортыг аль алиныг нь FOB нөхцлийн үнээр үнэлж тусгах ёстой бөгөөд харин барааны импорт нь гаалийн статистикт СИФ нөхцлийн үнээр үнэлэгдсэн байдаг. Иймээс төлбөрийн тэнцлийн статистикийн олон улсын стандартын дагуу импортын дүнгээс даатгал, тээврийн өртгийг салган үйлчилгээний бүлэгт шилжүүлэн импортыг FOB нөхцлөөр тооцож тусгана.

Америк доллараар үнэлсэн бараа, үйлчилгээний гадаад худалдааны мэдээг тухайн жилийн болон улирлын америк доллартай харьцах төгрөгийн албан ёсны дундаж ханшаар бодож, төгрөгт шилжүүлнэ.

Бараа, үйлчилгээний гадаад худалдаанд дараахи зүйлсийг хамруулж ойлгоно. Үүнд:

Барааны экспорт

Барааны экспорт нь тухайн улсын эдийн засгийн харъяатаас эдийн засгийн харъяат бус этгээдтэй хийсэн бараа, бүтээгдэхүүний худалдаа, бараа солилцоо, бэлэг, тусламжаас бүрдэнэ.

Барааны импорт

Барааны импорт нь тухайн улсын эдийн засгийн харъяат биш этгээдээс тухайн улсын эдийн засгийн харъяатад худалдсан, солилцсон, бэлгэнд эсвэл тусламжинд авсан бараа, бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Үйлчилгээний тэнцэл

Эдийн засгийн харъяат оршин суугчаас эдийн засгийн харъяат бус оршин суугчид үзүүлсэн үйлчилгээний орлогыг экспортод, харин эдийн засгийн харъяат оршин суугчийн эдийн засгийн харъяат бус оршин суугчид төлсөн үйлчилгээний зардлыг импортод бүртгэнэ.

Үйлчилгээний тэнцэл нь тээвэр, аялал жуулчлал, харилцаа холбоо, барилгын ажил, даатгал, санхүү, компьютер мэдээлэл, патент, барааны тэмдэгтийн хураамж, лиценз, бусад бизнес, амралт соёлын ба Засгийн газрын үйлчилгээний нийлбэрээс бүрдэнэ.

- *Тээвэр.* Тээврийн үйлчилгээнд бүх төрлийн ачаа тээврийн хэрэгслээр хийж байгаа зорчигч тээвэрлэлт, ачаа тээш, тээвэрлэлттэй холбоотой үйлчилгээнүүд (боомтын үйлчилгээ, навигацийн үйлчилгээ, дамжин өнгөрсний үйлчилгээ) хамрагдана.
- *Аялал жуулчлал.* Нисэх буудлын хураамж, визийн хураамж зэрэг аялалтай холбогдох зардал, хувийн болон албан хэрэгцээний зориулалтаар худалдан авсан бэлэг дурсгалын зүйлс, бараа, хоол хүнс болон зочид буудал, хоол хүнс, үзвэр үйлчилгээ зэрэг үйлчилгээний зардлуудыг тусгана. Аялалыг зорилгоор нь албан томилолт, жуулчлал ба бусад аялал гэсэн 3 бүлэгт ангилж бүртгэнэ.
- *Харилцаа холбооны үйлчилгээ.* Эдийн засгийн харъяат болон харъяат бусын хооронд харилцаа холбооны хэрэгслээр дамжин хийгдэж байгаа үйлчилгээ хамаарна. Үүнд: энгийн болон буухиа шуудангийн бүх төрлийн үйлчилгээ, телефон, телекс, телеграф, факсын үйлчилгээ, Ройтерс, СВИФТ зэрэг бүх төрлийн мэдээллийн сүлжээ ба кабелийн телевизийн суваг гэх мэт хиймэл дагуулын ашиглалт орно.
- *Барилгын ажил.* 1 жилийн дотор гүйцэтгэсэн барилгын ажил үйлчилгээний болон суурилуулах ажлын орлого, зардал хамаарна. Монгол Улсад татвар төлөгч гадаадын барилгын компани, салбар компани нь эдийн засгийн харъяат оршин суугч учир энд хамаарахгүй.
- *Даатгалын үйлчилгээ.* Эдийн засгийн харъяат болон харъяат бус оршин суугчийн хооронд хийгдсэн даатгалын бүх төрлийн үйлчилгээний орлого, зардал хамрагдана.
- *Санхүүгийн үйлчилгээ.* Эдийн засгийн харъяат болон харъяат бус оршин суугчийн хооронд хийгдсэн даатгал, тэтгэврийн сангаас бусад аккредитивын шимтгэл, санхүүгийн лизингийн шимтгэл, валют хөрвүүлсний шимтгэл гэх мэт санхүүгийн зуучлал, санхүүгийн брокерийн хөлс, активын удирдлагын үйлчилгээний хөлс, диллерүүдийн хөлс зэрэг туслах чанарын ажил, үйлчилгээний орлого, зардлыг бүртгэнэ.
- *Компьютер, мэдээллийн үйлчилгээ.* Эдийн засгийн харъяат ба харъяат бус оршин суугчийн хооронд үзүүлсэн цахим тооцоолон бодох техникийн талаар зөвлөгөө өгөх болон авах, программ хангамж, мэдээлэл солилцох, мэдээллийн сан бий болгох, мэдээллийн суваг бэлтгэх зэрэг мэдээллийн үйлчилгээ, компьютер, түүнтэй холбоотой тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнүүд хамрагдана.
- *Патент, тэмдэгт, лицензийн хураамж.* Үйлдвэрлэгддэггүй, санхүүгийн бус актив хөрөнгө болох худалдааны тэмдэгт, зохиогчийн эрх, патент, технологийг ашиглах, франчайзийн эрхийн хураамж ба үйлдвэрлэгчийн давуу эрх, бүтээлийн бүрэн эхийг ашиглах эрхийн хураамжууд хамрагдана.
- *Бусад бизнесийн үйлчилгээ.* Бараа зуучлах үйлчилгээ, тээврийн хэрэгслэлийн түрээс, зөвлөхийн үйлчилгээ, бараа, ажил үйлчилгээний сурталчилгаа, эрдэм шинжилгээний болон судалгааны ажил, соёл урлаг, биеийн тамирын чиглэлийн үйлчилгээний орлого, зардлыг хамруулна.
- *Эмчилгээ, боловсрол, соёлын үйлчилгээ.* Үүнд эмчилгээ болон сургалтын төлбөр, дуу бичлэг, кино жүжгийн зурагт авалт, киног нийтэд гаргах эрхийн хураамж, музей ба номын сантай холбоотой үйлчилгээний хураамжуудыг бүртгэнэ.
- *Засгийн газрын үйлчилгээ.* Засгийн газрын үйлчилгээнд олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газар, гадаад орнуудын элчин сайдын яам, консулын газруудын үйлчилгээний зардал хамрагдана.

3.2 Дотоодын нийт бүтээгдэхүүнийг эцсийн ашиглалтын аргаар, зэрэгцүүлэх үнээр тооцох

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ийг зэрэгцүүлэх үнээр үнэлэхдээ ДНБ-ий эцсийн ашиглалтын бүрэлдэхүүн бүрийг холбогдох индекс хувааж тооцно.

3.2.1 Эцсийн хэрэглээ

А. Өрхийн аж ахуйн хэрэглээ

Өрхийн аж ахуйн хэрэглээ болон хэрэглээний үнийн индекс аль аль нь “Хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний ангилал (СОICOP) “-ын дагуу ангилагдсан тул өрхийн аж ахуйн хэрэглээг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ өрхийн аж ахуйн хэрэглээний бүлэг бүрийн дүнг хэрэглээний үнийн индексийн холбогдох бүлэг бүрийн индекс хувааж тооцно. Үүнд:

- *Хүнсний бараа, ундаа, ус* – ХҮИ-ийн хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн индекс хуваана.
- *Согтууруулах ундаа, тамхи* – ХҮИ-ийн согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнийн индекс хуваана.
- *Хувцас, бөс бараа, гутал* – ХҮИ-ийн хувцас, бөс бараа, гуталны бүлгийн үнийн индекс хуваана.
- *Орон сууц, ус, цахилгаан, түлш* – ХҮИ-ийн орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн индекс хуваана.
- *Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа* – ХҮИ-ийн гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнийн индекс хуваана.
- *Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ* – ХҮИ-ийн эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнийн индекс хуваана.
- *Тээвэр* – ХҮИ-ийн тээврийн бүлгийн үнийн индекс хуваана.
- *Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ* – ХҮИ-ийн холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнийн индекс хуваана.
- *Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ* – ХҮИ-ийн амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнийн индекс хуваана.
- *Боловсролын үйлчилгээ* – ХҮИ-ийн боловсролын үйлчилгээний бүлгийн үнийн индекс хуваана.
- *Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ* – ХҮИ-ийн зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнийн индекс хуваана.
- *Бусад бараа, үйлчилгээ* – ХҮИ-ийн бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнийн индекс хуваана.

Б. Төрийн удирдлагын байгууллагын хэрэглээ

Төрийн удирдлагын байгууллагын хэрэглээг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ төрийн удирдлагын салбар бүрийн хэрэглээг холбогдох үйлдвэрлэлийн аргаар тооцсон төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагааны салбарын болон дэд салбарын дефляторт хуваана. Ингэхдээ :

- *Боловсролын салбарын хэрэглээ* - үйлдвэрлэлийн аргын тооцооны төрийн өмчийн сургууль /802/-ийн нэмэгдэл өртгийн дефляторт хуваана.
- *Эрүүл мэндийн салбарын хэрэглээ* - үйлдвэрлэлийн аргаар тооцсон төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага /851/ -ын нэмэгдэл өртгийн дефляторт хуваана.

Харин төрийн удирдлагын бусад салбаруудын хэрэглээг үйлдвэрлэлийн аргаар тооцсон төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын салбарын нэмэгдэл өртгийн дефляторт хувааж зэрэгцүүлэх үнэд шилжүүлнэ.

В. Төрийн бус байгууллагын хэрэглээ

Төрийн бус байгууллагын хэрэглээг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ төрийн удирдлагын байгууллагын хэрэглээг зэрэгцүүлэх үнэд шилжүүлсэнтэй адил зарчмыг баримтална. Үүнд:

- *Сүм хийдийн хэрэглээ* - үйлдвэрлэлийн аргын тооцооны сүм хийдийн үйл ажиллагааны салбарын /905/ нэмэгдэл өртгийн дефляторт хуваана.
- *Төрийн бус байгууллагын хэрэглээ* - үйлдвэрлэлийн аргын тооцооны төрийн бус байгууллагын /906/ нэмэгдэл өртгийн дефляторт хуваана.

3.2.2 Нийт хөрөнгийн хуримтлал

А. Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал

Үндсэн хөрөнгийн нийт хуримтлалыг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ бүрэлдэхүүн бүрийг тохирох дефляторт хувааж тооцно. Үүнд:

Биет үндсэн хөрөнгө:

- *Орон сууцны барилга* - үйлдвэрлэлийн аргын тооцооны барилгын салбарын нэмэгдэл өртгийн дефляторт хуваана.
- *Бусад барилга, байгууламжууд* - үйлдвэрлэлийн аргын тооцооны барилгын салбарын нэмэгдэл өртгийн дефляторт хуваана.
- *Их засвар, өргөтгөл, шинэчлэлт, сэргээн босголтын ажил*- үйлдвэрлэлийн аргын тооцооны барилгын салбарын нэмэгдэл өртгийн дефляторт хуваана.
- *Машин, тоног төхөөрөмж:*
 - *тээврийн хэрэгсэл* - гадаад худалдааны авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгслэлийн бүлгийн импортын үнийн индекст хуваана.
 - *бусад машин, тоног төхөөрөмж* – гадаад худалдааны машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, телевизийн сэлбэг эд ангийн бүлгийн импортын үнийн индекст хуваана.
- *Мал, амьтан, олон наст ургамал:*
 - *үндсэн сүргийн мал* – мал аж ахуйн бүтээгдэхүүний тооцооноос нас гүйцсэн малын зэрэгцүүлэх үнээр тооцсон дүнг авна.
 - *жимс, жимсгэнэ болон модны ургац* – газар тариалангийн нийт бүтээгдэхүүний тооцооноос жимс, жимсгэнийн бүлгийн зэрэгцүүлэх үнээр тооцсон дүнг авч тавина.

Биет бус үндсэн хөрөнгө

- *Геологи, хайгуулын ажил* - үйлдвэрлэлийн аргын тооцооны геологийн салбарын /742/ нэмэгдэл өртгийн дефляторт хуваана.
- *Компьютерийн программ хангамж* - үйлдвэрлэлийн аргын тооцооны компьютер, түүнтэй холбоотой үйл ажиллагаа гэсэн дэд салбарын /72/ нэмэгдэл өртгийн дефляторт хувааж зэрэгцүүлэх үнэд шилжүүлнэ.
- *Утга зохиол, урлагийн эх бүтээлүүд* - үйлдвэрлэлийн аргын тооцооны үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагааны салбарын бусад гэсэн дэд салбарын /749/ нэмэгдэл өртгийн дефляторт хувааж зэрэгцүүлэх үнэд шилжүүлнэ.
- *Бусад биет бус үндсэн хөрөнгө* - үйлдвэрлэлийн аргын тооцооны үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагааны салбарын бусад гэсэн дэд салбарын /749/ нэмэгдэл өртгийн дефляторт хувааж зэрэгцүүлэх үнэд шилжүүлнэ.

Б. Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт

Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ дээрхитэй адил бүрэлдэхүүн бүрийг тохирох дефляторт нь хуваана. Үүнд:

- *Түүхий эд, материал* – аж үйлдвэрийн салбарын боловсруулах үйлдвэрийн нийт үйлдвэрлэлтийн дефляторт хувааж тооцно.
- *Дуусаагүй үйлдвэрлэл* - аж үйлдвэрийн салбарын боловсруулах үйлдвэрийн нийт үйлдвэрлэлтийн дефляторт хувааж тооцно.
- *Бэлэн бүтээгдэхүүн* - аж үйлдвэрийн салбарын боловсруулах үйлдвэрийн нийт үйлдвэрлэлтийн дефляторт хувааж тооцно.
- *Дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүн* – бөөний болон жижиглэн худалдааны салбарын нэмэгдэл өртгийн дефляторт хувааж тооцно.

В. Үнэт зүйлсийн хуримтлал

Үнэт зүйлсийн хуримтлалыг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ мөн адил бүрэлдэхүүн бүрийг тохирох дефляторт нь хувааж тооцно. Үүнд:

- *Мөнгөжөөгүй алт* – экспортонд гаргасан мөнгөжөөгүй алтны /7108/ үнийн индекс хувааж тооцно.
- *Зоос, түүх, соёлын үнэт зүйлс* - экспортонд гаргасан зоосны /7118/ үнийн индекс хувааж тооцно.
- *Бусад үнэт металл* - экспортонд гаргасан бусад үнэт ба хагас үнэт чулууны /7103/ үнийн индекс хувааж тооцно.

3.2.3 Бараа, үйлчилгээний цэвэр экспорт

А. Барааны экспорт, импорт

Барааны экспорт, импортыг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ:

- *Барааны экспорт* – гадаад худалдааны экспортын үнийн ерөнхий индекс хувааж тооцно.
- *Барааны импорт* – гадаад худалдааны импортын үнийн ерөнхий индекс хувааж тооцно.

Б. Үйлчилгээний экспорт, импорт

Үйлчилгээний экспорт, импортыг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ бүрэлдэхүүн бүрийг боломжит тохирох индекс, дефляторт хуваана гэсэн ерөнхий зарчмыг баримтлана.

Өнөөдөр ихэнхи орны хувьд үйлчилгээний экспорт, импортыг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхэд ихээхэн асуудалтай байгаа ба аль болохуйц боломжит мэдээллийн эх үүсвэрийг ашиглаж тооцож байна.

Манай орны хувьд ч байдал мөн адил байгаа бөгөөд одоо байгаа мэдээллийн эх үүсвэрийг ашиглан дараахи байдлаар зэрэгцүүлэх үнийн тооцоог хийж болох юм.

Үйлчилгээний экспорт

Тээвэр:

- *Зорчигч тээвэр* - ХҮИ-ийн УБ-Бээжингийн онгоцны билетийн үнийн индекс хувааж тооцно.
- *Ачаа тээвэр* - ХҮИ-ийн тээврийн үйлчилгээний бүлгийн үнийн индекс хуваана.
- *Бусад* - ХҮИ-ийн тээврийн үйлчилгээний бүлгийн үнийн индекс хуваана.

Аялал жуулчлал:

Аялал жуулчлалын үйлчилгээг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ юуны өмнө албан ажлаар болон жуулчлалын зорилгоор ирсэн хүмүүс тухайн улсдаа ямар ямар төрлийн зардал гаргасныг судалгааны дүнг ашиглан гаргана. Энэ төрлийн мэдээллийг ЗТАЖЯ, Монголбанк зэрэг газруудаас явуулсан тухайн төрлийн судалгааны үр дүнг ашиглах боломжтой. Судалгаагаар гарсан зардлын бүтцийг ашиглан нийт дүнгээ задалж тохирох индекс хуваан тооцно.

Албан томилолт – Олон улсын аялал жуулчлалын судалгаагаар албан томилолтоор ирсэн хүмүүс дараахи зүйлсэд мөнгөө зарцуулдаг гэсэн дүн гарсан байна. Үүнийг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ:

- *Зочид буудал* – ХҮИ-ийн зочид буудал, дотуур байрны үйлчилгээний дэд бүлгийн үнийн индекс хуваана.
- *Ресторан, кафе* - ХҮИ-ийн ресторан, кафе, бусад зоогийн газрын дэд бүлгийн үнийн индекс хуваана.
- *Такси, машины түрээс* - ХҮИ-ийн тээврийн бүлгийн үнийн индекс хуваана.
- *Дотоодын онгоцны нислэг* - ХҮИ-ийн дотоодын нислэгийн үнийн индекс хуваана.
- *Бусад /хоол хүнс, хөтчийн зардал/* - ХҮИ-ийн хүнсний бүлгийн үнийн индекс хуваана.

Жуулчлал – Олон улсын аялал жуулчлалын судалгаагаар жуулчлалаар ирсэн хүмүүс дараахи зүйлсэд мөнгөө зарцуулдаг гэсэн дүн гарсан байна. Үүнийг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ:

- *Зочид буудал* – ХҮИ-ийн зочид буудал, дотуур байрны үйлчилгээний дэд бүлгийн үнийн индекс хуваана.
- *Ресторан, кафе* - ХҮИ-ийн ресторан, кафе, бусад зоогийн газрын дэд бүлгийн үнийн индекс хуваана.
- *Дурсгалт газруудтай танилцах аялал* – ХҮИ-ийн соёлын үйлчилгээний дэд бүлгийн үнийн индекс хуваана.
- *Такси, машины түрээс* - ХҮИ-ийн тээврийн бүлгийн үнийн индекс хуваана.
- *Дотоодын онгоцны нислэг* - ХҮИ-ийн дотоодын нислэгийн үнийн индекс хуваана.
- *Гар урлалын зүйлс худалдан авах* - ХҮИ-ийн хээгүй, дунд гарын мөнгөн аяганы үнийн индекс хуваана.
- *Ноос, ноолуур, савхин хувцас, эдлэл худалдан авах* - ХҮИ-ийн хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн индекс хуваана.
- *Бусад /хоол хүнс, хөтчийн зардал/* - ХҮИ-ийн хүнсний бүлгийн үнийн индекс хуваана.

Бусад - Олон улсын аялал жуулчлалын судалгаагаар бусад зорилгоор ирсэн хүмүүс ч мөн адил дараахи зүйлсэд мөнгөө зарцуулдаг байна. Үүнийг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ:

- *Зочид буудал* – ХҮИ-ийн зочид буудал, дотуур байрны үйлчилгээний дэд бүлгийн үнийн индекс хуваана.
- *Ресторан, кафе* - ХҮИ-ийн ресторан, кафе, бусад зоогийн газрын дэд бүлгийн үнийн индекс хуваана.
- *Такси, машины түрээс* - ХҮИ-ийн тээврийн бүлгийн үнийн индекс хуваана.
- *Дотоодын онгоцны нислэг* - ХҮИ-ийн дотоодын нислэгийн үнийн индекс хуваана.
- *Бусад /хоол хүнс, хөтчийн зардал/* - ХҮИ-ийн хүнсний бүлгийн үнийн индекс хуваана.

Харилцаа холбооны үйлчилгээ - ХҮИ-ийн холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн индекс хуваана.

Барилгын ажил - үйлдвэрлэлийн аргын тооцооны барилгын салбарын нэмэгдэл өртгийг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхэд ашигласан дефляторт хуваана.

Даатгалын үйлчилгээ - үйлдвэрлэлийн аргын тооцооны даатгалын салбарын /661/ нэмэгдэл өртгийг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхэд ашигласан дефляторт хуваана.

Санхүүгийн үйлчилгээ - ХҮИ-ийн санхүүгийн үйлчилгээний бүлгийн индекс хуваана.

Компьютер, мэдээллийн үйлчилгээ - үйлдвэрлэлийн аргын тооцооны компьютер, түүнтэй холбоотой үйл ажиллагаа гэсэн дэд салбарын /72/ нэмэгдэл өртгийн дефляторт хувааж зэрэгцүүлэх үнэд шилжүүлнэ.

Патент, тэмдэгт, лицензийн хураамж - үйлдвэрлэлийн аргын тооцооны үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагааны салбарын бусад гэсэн дэд салбарын /749/ дефляторт хувааж зэрэгцүүлэх үнэд шилжүүлнэ.

Бусад бизнесийн үйлчилгээ - үйлдвэрлэлийн аргын тооцооны үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагааны салбарын бусад гэсэн дэд салбарын /749/ дефляторт хувааж зэрэгцүүлэх үнэд шилжүүлнэ.

Эмчилгээ, боловсрол, соёлын үйлчилгээ:

- *Эмчилгээ*- ХҮИ-ийн эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн индекс хуваана.
- *Боловсрол* - ХҮИ-ийн боловсролын үйлчилгээний бүлгийн индекс хуваана.
- *Бусад* - ХҮИ-ийн чөлөөт цаг, соёлын үйлчилгээний дэд бүлгийн индекс хуваана.

Засгийн газрын үйлчилгээ - үйлдвэрлэлийн аргын тооцооны төрийн удирдлагын байгууллагын /L/ нэмэгдэл өртгийн дефляторт хувааж зэрэгцүүлэх үнэд шилжүүлнэ.

Үйлчилгээний импорт

Үйлчилгээний экспортыг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхтэй адил зарчмаар үйлчилгээний импортыг гол харилцагч орны үнийн дефляторыг ашиглан зэрэгцүүлэх үнэд шилжүүлнэ. Өөрөөр хэлбэл тухайн үйлчилгээг аль орноос импортлосон байна гэдгийг

тодорхойлох ёстой. Хэрвээ гол харилцагч орон хоёроос дээш байвал нийт үйлчилгээний импортын ихэнх хувийг нийлүүлж байгаа орныг сонгоно. Орноо сонгосны дараа тухайн сонгогдсон орны хэрэглээний үнийн индексийг ашиглан тооцоог хийнэ.

ДӨРӨВ. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ОРЛОГЫН АРГААР ТООЦОХ АРГА ЗҮЙ

ДНБ-ийг дараах орлогуудын нийлбэрээр тооцно. Үүнд:

- цалин, шагнал, урамшуулал, түүнтэй адилтгах орлого
- үндсэн хөрөнгийн элэгдэл
- бараа, үйлчилгээний татвар, татаас
- ашиг, холимог орлого

Мэдээллийн эх үүсвэр. ДНБ-ийг орлогын аргаар тооцоход дараах мэдээллүүдийг ашиглана.

- Улсын нэгдсэн төсвийн мэдээ
- Үндэсний татварын ерөнхий газрын мэдээлэл
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээлэл
- Салбаруудын нэмэгдэл өртгийн тооцоо

Цалин, шагнал, түүнтэй адилтгах орлого. Төрийн байгууллагын хувьд улсын болон орон нутгийн төсвийн зарлагын мэдээ, бусад газруудын хувьд үндэсний татварын ерөнхий газар, улсын нэгдсэн төсвийн мэдээлэл, Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээлэл, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тооцоо нь мэдээллийн эх үүсвэр болно.

Цалин хөлс гэдэг бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас үйлдвэрлэл явуулахад зарцуулсан хөдөлмөрийнх нь хувь хэмжээнд тохируулан ажиллагчиддаа мөнгөн болон биет хэлбэрээр олгож байгаа нөхөн төлбөр юм. Хөдөлмөрийн хөлсний ерөнхий бүдүүвч:

- Цалин хөлс
 - Мөнгөөр олгосон
 - Биет хэлбэрээр олгосон
- Хөдөлмөрийг нь урамшуулах зорилгоор олгосон шагнал
- Ажил олгогчоос ажилчдынхаа нийгмийн даатгалд төлсөн шимтгэл
 - жинхэнэ шимтгэл
 - хийсвэр шимтгэл

Цалингийн хэмжээг тодорхойлохдоо эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг оролцуулан тооцно.

Манайд мөрдөж байгаа нийгмийн даатгалын төрөл:

- тэтгэврийн даатгал
- тэтгэмжийн даатгал
- эрүүл мэндийн даатгал
- үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал
- ажилгүйдлийн даатгал

Олон улсын жишгээр эдгээр төрлийн даатгалд ажил олгогчоос төлж буй шимтгэлийг жинхэнэ шимтгэл гэнэ. Үүнээс гадна тооцсон шимтгэл гэж байх бөгөөд энэ нь ажил олгогч одоо ажиллаж байгаа болон ажиллаж байсан хүмүүстээ, тэрчлэн тэдний тэжээлгэгчдэд өөрийн нөөцөөс шууд олгож буй тэтгэмж юм. Гэхдээ практикт ихэнх тохиолдолд хийсвэр шимтгэл нь бараг тохиолддоггүй байна.

Үндсэн хөрөнгийн элэгдэл: Улсын нэгдсэн төсвийн мэдээ, үндэсний татварын ерөнхий газар, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тооцоо нь мэдээллийн эх үүсвэр болно. Үндсэн хөрөнгөөс тайлант хугацаанд байгуулсан элэгдлийг оруулна.

Бараа, үйлчилгээний татвар, татаас: Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын мэдээ нь мэдээллийн эх үүсвэр болно. Бараа, үйлчилгээний татвар, татаасын хэмжээг энэхүү аргачлалын 2.1.3.2-д тусгасан байдлаар тооцно.

Ашиг, түүнтэй адилтгах орлого буюу холимог орлого: Үндэсний татварын ерөнхий газар, салбаруудын бүтээгдэхүүний тооцоо нь мэдээллийн эх үүсвэр болно. Энэ үзүүлэлтийг үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэмэгдэл өртгөөс цалин, түүнтэй адилтгах орлого, үндсэн хөрөнгийн хэрэглээ, бараа, үйлчилгээний татварыг хасч, татаасыг нэмэх замаар тооцно.

ТАВ. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АРГААР ТООЦОХ АРГА ЗҮЙ

5.1 Ерөнхий зүйл

ДНБ-ий тооцоог аймаг, бүсээр хийх нь улс орны эдийн засагт тухайн аймаг, бүсийн эзэлж буй байр суурийг харуулдаг чухал мэдээлэл юм.

“Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” Монгол улсын хуулийн 3 дугаар зүйлийн 1 дүгээр заалтын “Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд..., нийслэл нь дүүрэгт... хуваагдана” гэж заасан нь ДНБ-ийг аймаг, нийслэлээр тооцоход баримтлах үндсэн ангилал болно.

Мөн “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” батлах тухай Улсын их хурлын 2001 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 57 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын эдийн засгийн бүс бүрт хамаарах аймгуудын ерөнхий хуваарийг удирдлага болгоно.

Аймаг, нийслэлийн ДНБ-ийг тооцохдоо эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалд үндэслэн тооцно.

Эдийн засгийн харъяаллын зарчим нь аймаг, нийслэлийн тооцоонд баримтлах зарчим байна. Аж ахуйн нэгжийн бий болгосон өртгийн хэмжээ нь хаана үйл ажиллагаа явуулж байгаагаас үл хамааран тухайн нэгжийн бүртгэгдсэн аймаг, нийслэлийн тооцоонд хамаарагдана. Харин тухайн нэгж, байгууллагуудын орон нутагт үйл ажиллагаа явуулдаг харъяа нэгжүүд нь бие даасан тайлан тэнцэл гаргадаг бол энэхүү нэгжүүдийн үйл ажиллагааг тухайн орон нутагт хамааруулан тооцно.

5.2 Аймаг, нийслэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнийг оны үнээр тооцох

Аймаг, нийслэлийн ДНБ-ий тооцоог эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар, үйлдвэрлэлийн аргаар тооцно. Энэхүү тооцооны үндсэн зарчим нь ДНБ-ийг үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцох арга зүйтэй адил байна. Аймаг, нийслэлээс ДНБ-ийг тооцож ҮСГ-т ирүүлэх бөгөөд ирүүлсэн ДНБ-ий тооцооны дүнг ҮСГ-т шалган хянаж, зохих засварлалт тооцоог тусгана. Энэхүү засварлалт нь аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг ҮТЕГ-ын мэдээлэлтэй тулгаж хянах явцад гарах нэмэлт өөрчлөлт, улсын түвшинд нэгтгэгдсэн түүвэр судалгааны үр дүнг аймаг, нийслэлийн тооцоонд хуваарилж тусгах, мөн улсын хэмжээнд нэгтгэгдсэн албан бус секторын тооцооны тархаалтыг аймаг, нийслэлийн тооцоонд хуваарилан тархаах зэрэг засварлалтууд байна.

Аймаг, нийслэлд хийх салбарын нэмэгдэл өртгийн тооцоо нь тухайн салбараас шалтгаалж, ургац хураалтын мэдээ, мал тооллого, нилэнхүй судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн тооцоонд тулгуурлана. Үүнийг салбаруудаар харуулбал:

1. Газар тариалан (011), Мал аж ахуй (012)

Газар тариалангийн салбарын нийт үйлдвэрлэлтийг ургац хураалтын эцсийн мэдээнд үндэслэн тооцох ба улсын хэмжээнд тодорхой давтамжтайгаар явуулах түүвэр судалгаагаар бүтээгдэхүүний нэр төрлөөр тогтоосон үйлдвэрлэгчийн улсын дундаж үнийг ашиглана. Завсрын хэрэглээг тооцохдоо аж ахуйн нэгж, өрхийн зардлын бүтцийг тус тус ашиглана.

Мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлтийг малын тоонд үндэслэн тооцох бөгөөд улсын хэмжээнд тодорхой давтамжтайгаар явуулах түүвэр судалгаагаар бүсчлэн тогтоосон ашиг шимийн гарц, бүсийн үйлдвэрлэгчийн дундаж үнийг ашиглана. Завсрын хэрэглээг тооцохдоо аж ахуйн нэгж, өрхийн зардлын бүтцийг тус тус ашиглана. Малын аргал хөрзөн, өтөг бууцыг аж ахуйд ашигласан хэмжээгээр нь бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэд оруулан тооцохдоо бүсийн үйлдвэрлэгчийн дундаж үнээр үнэлнэ.

2. Ан агнуур, ойн аж ахуй, мод бэлтгэл, загасны аж ахуй

Эдгээр салбаруудын тооцоог ҮСГ-т тооцож; аймаг, нийслэлд хуваарилан тархаана.

3. Аж үйлдвэр, барилга, бөөний болон жижиглэн худалдаа, машин, гэр ахуйн барааны засварлах үйл ажиллагаа, зочид буудал, зоогийн газар

Нэлэнхүй судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн мэдээлэлд тулгуурлан тооцоог хийнэ. Түүвэр судалгаанд хамрагдсан нэгжүүд, албан бус секторын тооцоог ҮСГ-т тооцож; аймаг, нийслэлд хуваарилан тархаана.

4. Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо

1. Тээвэр, агуулахын аж ахуйн салбарын үйл ажиллагаа

Нэлэнхүй судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн мэдээлэлд тулгуурлан тооцоог хийнэ. Албан бус секторын тооцоог ҮСГ-т тооцож; аймаг, нийслэлд хуваарилан тархаана.

2. Аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаа

Нэлэнхүй судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн мэдээлэлд тулгуурлан тооцоог хийнэ.

3. Холбооны салбарын үйл ажиллагаа

Нэлэнхүй судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн мэдээлэлд тулгуурлан тооцоог хийнэ. “Монголын цахилгаан холбоо” компанийн үйл ажиллагааг ҮСГ-т тооцож; аймаг, нийслэлд хуваарилан тархаана.

5. Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа

1. Банкны үйл ажиллагаа

Тус салбарын тооцоог ҮСГ-т тооцож; уг тооцоог зээлийн өрийн үлдэгдэлд үндэслэн аймаг, нийслэлд хуваарилан тархаана.

2. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа, Даатгалын үйл ажиллагаа

Тус салбарын тооцоог Санхүүгийн зохицуулах хорооны мэдээлэлд үндэслэн ҮСГ-т тооцож; аймаг, нийслэлд хуваарилан тархаана.

3. Хөрөнгийн бирж, брокерийн пүүсүүдийн үйл ажиллагаа

Тус салбарын тооцоог Хөрөнгийн биржийн мэдээлэлд үндэслэн ҮСГ-т тооцож; аймаг, нийслэлд хуваарилан тархаана.

6. Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа

1. Орон сууц

Нэлэнхүй судалгаанд хамрагдсан орон сууцны хувийн хэвшлийн конторуудын мэдээлэлд тулгуурлан тооцоог хийнэ. Төрийн өмчийн байгууллагуудын тооцоог ҮСГ-т тооцож; аймаг, нийслэлд хуваарилан тархаана.

2. Сууц өмчлөгчдийн холбоо

Нэлэнхүй судалгаанд хамрагдсан сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааны мэдээлэлд тулгуурлан тооцоог хийнэ.

3. Үл хөдлөх хөрөнгийн төлбөрт үйлчилгээ

Нэлэнхүй судалгаанд хамрагдсан байр түрээслүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг нэгжүүд, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний газрын үйл ажиллагааны мэдээлэлд тулгуурлан тооцоог хийнэ.

4. Өөрийн эзэмшлийн орон сууцны түрээс

Тус салбарын тооцоог ҮСГ-т тооцож; аймаг, нийслэлд хуваарилан тархаана.

5. Машин, тоног төхөөрөмжийн түрээсийн үйл ажиллагаа, Компьютер түүнтэй холбогдох үйл ажиллагаа

Нэлэнхүй судалгаанд хамрагдсан нэгжүүдийн үйл ажиллагааны мэдээлэлд тулгуурлан тооцоог хийнэ.

6. Эрдэм шинжилгээний ажил

Нэлэнхүй судалгаанд хамрагдсан эрдэм шинжилгээний ажил эрхэлдэг хувийн хэвшлийн мэдээлэлд тулгуурлан тооцоог хийнэ. Төрийн өмчийн байгууллагуудын тооцоог ҮСГ-т тооцож; аймаг, нийслэлд хуваарилан тархаана.

7. Зураг төсөл, Геологи хайгуул, Техникийн туршилт, шинжилгээ

Нэлэнхүй судалгаанд хамрагдсан нэгжүүдийн мэдээлэлд тулгуурлан тооцоог хийнэ. Төрийн өмчийн байгууллагуудын тооцоог ҮСГ-т тооцож; аймаг, нийслэлд хуваарилан тархаана.

8. Гэрэл зураг, Бизнесийн бусад үйл ажиллагаа

Нэлэнхүй судалгаанд хамрагдсан нэгжүүдийн үйл ажиллагааны мэдээлэлд тулгуурлан тооцоог хийнэ.

7. Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа

Тус салбарын тооцоог улсын нэгдсэн болон орон нутгийн төсвийн гүйцэтгэлд тулгуурлан ҮСГ-т тооцож; аймаг, нийслэлд хуваарилан тархаана.

8. Боловсролын салбарын үйл ажиллагаа

Насанд хүрэгчдийн болон бусад боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг нэгжүүдийн хувьд нэлэнхүй судалгаанд хамрагдсан нэгжүүдийн мэдээлэлд тулгуурлан тооцоог хийнэ.

Төрийн өмчийн боловсролын байгууллагууд, хувийн өмчийн сургуулиудын тооцоог улсын нэгдсэн болон орон нутгийн төсвийн гүйцэтгэл, Боловсрол, соёл шинжлэх ухааны яамны мэдээлэлд тулгуурлан ҮСГ-т тооцож; аймаг, нийслэлд хуваарилан тархаана.

9. Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа

Тус салбарын тооцоог улсын нэгдсэн болон орон нутгийн төсвийн гүйцэтгэлд тулгуурлан ҮСГ-т тооцож; аймаг, нийслэлд хуваарилан тархаана.

10. Нийтэд болон хамт олон, бие хүнд үзүүлэх үйлчилгээ

Нэлэнхүй судалгаанд хамрагдсан нэгжүүдийн мэдээлэлд тулгуурлан тооцоог хийнэ. Төрийн өмчийн байгууллагуудын тооцоо, албан бус секторын тооцоог ҮСГ-т тооцож; аймаг, нийслэлд хуваарилан тархаана.

11. Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ

Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээний хэмжээг аймаг, нийслэлийн ДНБ-ий тооцоонд хуваарилахдаа банкны салбарын тайлант жилийн зээлийн хүүгийн орлогод аймаг, нийслэлийн салбаруудын тухайн үзүүлэлтийн эзлэх хувийн жинг ашиглан хуваарилна.

12. Бараа, үйлчилгээний татвар, татаас

Татвар

- Дотоодын үйлдвэрлэлтийн архи, тамхины онцгой албан татварыг аймаг, нийслэлийн ДНБ-ий тооцоонд хуваарилахдаа тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг салбаруудын нийт үйлдвэрлэлтэд аймаг, нийслэлийн холбогдох салбаруудын эзэлж буй хувийн жинг ашиглан хуваарилна.
- Бараа, үйлчилгээний бусад татвар буюу нэмэгдэл өртгийн татвар, гадаад үйл ажиллагааны орлогын албан татвар (импортоор оруулж ирсэн архи, тамхины онцгой албан татвар орно)-ыг аймаг, нийслэлийн ДНБ-ий тооцоонд хуваарилахдаа худалдааны салбарын маягтаар авдаг бүтээгдэхүүний татварын нийт дүнд аймаг, нийслэлийн салбаруудын тухайн үзүүлэлтийн эзэлж буй хувийн жинг ашиглан хуваарилна.

Татаас

- Эрчим хүчний татаасыг аймаг, нийслэлийн ДНБ-ий тооцоонд хуваарилахдаа цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлтийн салбарын мэдээгээр ирсэн эрчим хүчний татаасын нийт дүнд аймаг, нийслэлийн салбаруудын тухайн үзүүлэлтийн эзэлж буй хувийн жинг ашиглан хуваарилна.
- Нийтийн тээврийн татаасыг нийслэлийн ДНБ-ий тооцоонд хуваарилна.

5.3 Аймаг, нийслэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнийг зэрэгцүүлэх үнээр тооцох

Олон улсын хэмжээнд бүс, мужийн түвшинд ДНБ-ий зэрэгцүүлэх үнийн тооцоог хийхдээ тухайн бүс, мужийн үйлдвэрлэгчийн үнэ, хэрэглээний үнийн индекс, биет хэмжээний индексийг ашиглан зэрэгцүүлэх үнэд шилжүүлдэг тооцооны аргыг ашигладаг байна. Улсын түвшний зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ-ий хэмжээг бүс, мужаар зэрэгцүүлэх үнээр үнэлэн тооцсон ДНБ-ий нийлбэрээр тооцдог байна.

Түүнчлэн бүс, мужийн түвшний мэдээллийн боломжоос шалтгаалан эхлээд улсын түвшний ДНБ-ийг зэрэгцүүлэх үнээр үнэлэн тооцож; дараа нь салбаруудын нэмэгдэл өртгийн дефляторыг ашиглан бүс, мужийн ДНБ-ийг зэрэгцүүлэх үнээр үнэлэн тооцож гаргадаг арга бий.

Манай орны хувьд үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон аймаг, нийслэлийн ДНБ-ий тооцоог зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ улсын түвшний ДНБ-ий зэрэгцүүлэх үнийн тайлант оны тооцооны дефляторыг ашиглан тооцно. Аймаг, нийслэлийн ДНБ-ий оны үнийн тооцоог зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ дэд салбар бүрийн нэмэгдэл өртгийг улсын түвшинд тооцсон тухайн харгалзах дэд салбар бүрийн дефляторт хувааж тооцно.

Аймаг, нийслэлийн ДНБ-ий оны үнийн тооцооны санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ, бараа, үйлчилгээний татвар, татаас гэсэн үзүүлэлтүүдийг мөн адил улсын түвшинд тооцсон холбогдох үзүүлэлтүүдийн дефляторт хувааж, зэрэгцүүлэх үнэд шилжүүлнэ.

Аймаг, нийслэлийн ДНБ-ий тооцоог зэрэгцүүлэх үнэд шилжүүлэх аргыг хийсвэр жишээгээр харуулбал:

Салбар	Нэмэгдэл өртөг, оны үнээр, тэрбум төгрөг		Салбаруудын дефлятор	Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр, тэрбум төгрөг	
	1-р аймаг	2-р аймаг		1-р аймаг	2-р аймаг
A	1	2	3	4=1/3*100	5=2/3*100
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	46,733.8	50,782.1		44,416.4	48,200.5
газар тариалан	3,710.9	6,503.9	108.1	3,432.9	6,016.6
мал аж ахуй	42,659.1	43,802.4	105.0	40,627.7	41,716.6
...	178.1	99.8	103.0	172.9	96.9
Загасны аж ахуй	9.3	8.3	103.6	9.0	8.0
Уул уурхай, олборлох үйлдвэр	53,586.7	82,721.5		52,327.3	75,915.4
нүүрс олборлолт	3,452.1	4,083.0	107.4	3,214.2	3,801.7
газрын тос, шатдаг хий олборлолт	804.7	544.8	181.2	444.1	300.6
металлын хүдэр олборлолт	48,856.5	76,723.5		48,223.6	70,524.1
алт болон бусад төмрийн хүдэр олборлолт	20,796.1	24,284.2	96.0	21,662.6	25,296.0
зэсийн баяжмал, молибдены баяжмал олборлолт	27,536.7	45,603.6	104.1	26,452.2	43,807.5
цайрын баяжмал	523.7	6,835.8	481.2	108.8	1,420.6
бусад ашигт малтмал олборлолт	473.5	1,370.2	106.3	445.4	1,289.0
Боловсруулах үйлдвэр	8,982.3	9,583.0		8,019.8	8,374.2
хүнс, ундаа үйлдвэрлэлт	2,390.5	3,551.8		2,160.4	3,020.0
мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	297.7	296.7	130.3	228.4	227.7
...	99.3	85.2	91.4	108.6	93.2
мебель тавилга үйлдвэрлэл болон бусад боловсруулах аж үйлдвэр	39.2	83.9		30.0	56.4
мебель тавилга үйлдвэрлэл	5.8	36.9	247.8	2.4	14.9
алт, мөнгөн эдлэл үйлдвэрлэл	17.9	12.4	134.7	13.3	9.2
бусад	15.4	34.7	107.1	14.4	32.4
хоёрдогч түүхий эд бэлтгэл	10.5	4.8	100.0	10.5	4.8
Барилга	5,183.7	4,698.0	102.2	5,072.1	4,596.8
...
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	2,462.6	2,578.0		2,323.8	2,443.3
Бохир ус, хаягдал, цэвэрлэгээ, ариутгалын үйлчилгээ	182.6	180.1		171.3	169.2
- төрийн	12.9	14.3	94.1	13.7	15.2
- хувийн	169.7	165.8	107.7	157.6	153.9
...
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	107.6	143.7		103.5	138.2
Хими цэвэрлэгээ, угаалга	10.9	14.6	103.8	10.5	14.0
...
Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ	-7,036.0	-8,977.7	110.1	-6,390.5	-8,154.1
Шууд бус татвар, цэвэр	27,465.9	30,130.4		25,911.2	28,424.9
онцгой татвар - архины	2,002.0	2,154.9	106.0	1,888.7	2,032.9
онцгой татвар - тамхины	533.8	607.5	106.0	503.5	573.1
бараа, үйлчилгээний бусад татвар	25,391.4	27,980.2	106.0	23,954.1	26,396.5
татаас - тээвэр	73.2	67.9	106.0	69.0	64.0
татаас -эрчим хүчний	388.0	544.3	106.0	366.1	513.5
Дотоодын нийт бүтээгдэхүүн	328,062.5	383,011.1		313,739.4	361,782.3

ЗУРГАА. ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО ТООЦОХ АРГА ЗҮЙ

6.1 Үндэсний нийт орлогыг оны үнээр тооцох

Мэдээллийн эх үүсвэр: ДНБ-ий үйлдвэрлэлийн аргын тооцоо, Монголбанкны Төлбөрийн тэнцэл байна.

Үндэсний нийт орлого (ҮНО) нь хаана үйлдвэрлэгдсэнээс нь шалтгаалахгүйгээр манай орны эдийн засгийн харъяатуудын эзэмшиж байгаа үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн орлогын нийлбэр үзүүлэлт юм.

ҮНО-ыг тооцохдоо төлбөрийн тэнцлээс урсгал дансны цэвэр орлого, урсгал шилжүүлгийн ажилчдын гуйвуулгын дүнг авна. Урсгал шилжүүлгийн ажилчдын гуйвуулгын дүнг нэмж авахын учир нь гадаадад ажиллаж буй манай иргэд өөрсдийн цалин хөлснөөс шилжүүлж байгаа гэж үзнэ.

Төлбөрийн тэнцлээс авч буй урсгал дансны цэвэр орлого, урсгал шилжүүлгийн ажилчдын гуйвуулгын дүнг гадаад хүчин зүйлийн орлого гэж нэрлэнэ. Энэ үзүүлэлтүүд нь ам. доллараар гардаг тул тайлант жилийн ам.долларын төгрөгтэй харьцуулсан дундаж ханшаар үржүүлж, ДНБ дээр нэмнэ.

6.2 Үндэсний нийт орлогыг зэрэгцүүлэх үнээр тооцох

ҮНО-ыг зэрэгцүүлэх үнээр тооцохдоо эхлээд оны үнээрх гадаад хүчин зүйлийн орлогын хэмжээг үйлдвэрлэлийн аргын тооцооны ДНБ-ий дефляторт хувааж зэрэгцүүлэх үнэд шилжүүлнэ. Дараа нь зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ дээр зэрэгцүүлэх үнэд шилжүүлсэн гадаад хүчин зүйлийн орлогыг нэмж тооцно.